

БАРИЛГЫН НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО

МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ, ДҮРЭМ

ОЛОН НИЙТИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

БНБД 31-03-22

Албан ёсны хэвлэл

**МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

Улаанбаатар хот
2022 он

БАРИЛГЫН НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО

МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ, ДҮРЭМ

ОЛОН НИЙТИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

БНБД 31-03-22

Албан ёсны хэвлэл

МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

Улаанбаатар хот
2022 он

Монгол Улсын Барилга, хот байгуулалтын Сайдын 2022 оны дугаар сарын-ны өдрийн дүгээр тушаалаар батлав.

Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Дэд бүтцийн Сайдын 2003 оны 252 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Олон нийт иргэний барилга” /БНБД 31-03-03/, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын Сайдын 2011 оны 125 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Боловсруулсан:

Ж.Гомбо доктор (Ph.D) , дэд профессор, зөвлөх архитектор

И.Гончигбат доктор (Ph.D), профессор, зөвлөх архитектор

Ж.Даваацэрэн зөвлөх инженер, магистр (MSc)

Д.Эрдэнэцэцэг зөвлөх инженер, магистр (MSc)

Оролцсон:

М.Жигжид архитектор, мэргэшсэн архитектор магистр (MSc)

С.Сугар доктор (Ph.D) , дэд профессор, инженер

Д.Цэвэлмаа зөвлөх архитектор, магистр (MSc)

Хянан тохиолдуулсан:

Ч.Дагшигдорж зөвлөх архитектор

Шүүмж хийсэн:

Г.Мягмар зөвлөх архитектор

Энэхүү нормативын баримт бичгийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүрэн болон хэсэгчлэн хувилах, олшруулах, тараахыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ, ДҮРЭМ

ОЛОН НИЙТИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ
PUBLIC BUILDINGS

1. ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

Энэхүү барилгын норм, дүрмийг Монгол улсын нутаг дэвсгэрт, газрын түвшнээс дээш 55 (51; 0) метр хүртэл өндөртэй (хэрэв тухайн барилга хэвгий газар байршсан бол түүний өндөрлөг хэсэгт баригдсаныг тооцно) газар доорх хэсэг нь газрын төлөвлөлтийн түвшнээс доош 15 м-ээс илүүгүй гүнтэй, шинээр барих, шинэчлэн өөрчлөх олон нийтийн барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулахад мөрдөнө.

Орон сууцны барилга болон бусад барилга дотор төлөвлөсөн олон нийтийн зориулалттай өрөө, тасалгаа, түүнчлэн ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн шаардлагын хувьд олон нийтийн барилгад хамаарагдах бусад барилгад тус норм, дүрмийн шаардлага нэгэн адил хамаарна.

Энэхүү нормын шаардлагад нийцүүлэн төлөвлөвөл зохих олон нийтийн зориулалттай бүлэг барилга болон өрөө тасалгааны төрлийг хавсралт А-д үзүүлэв.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

“Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт” /БД 31-113-11/
“Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт сургууль” /БНБД II-76-79/
“Сургалт хүмүүжлийн барилгын зураг төсөл” /БНБД II-66-88/
“Усан сэлэлтийн барилга байгууламж” /БД 31-116-12/
MNS 6541 Мэргэжлийн боловсрол сургалт Ерөнхий шаардлага
MNS ISO 11799 - 2007 19 Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага
MNS 5742 ... Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага
“Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал” /БНБД 21-01-02/
“Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн байдал” /БНБД 21-02-02/
“Барилга, байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл” /БНБД 21-04-05*/18/
“Барилга байгууламж, өрөө тасалгааны тэсрэх, шатах галын аюулын ангиллыг тодорхойлох дүрэм” /БД 21-101-12/
“Барилга байгууламжийн галын тээвэрлэлтийн лифтүүд. Ерөнхий техникийн шаардлагууд” /НПБ 250-97/
“Галын аюулгүйн ба галын тэсрэлтээр гаднах төхөөрөмж ба барилга, өрөөний категори тодорхойлох” /НПБ 105-03/
MNS 0640:1989 Галын аюулгүй байдал. Нэр томъёо ба тодорхойлолт
MNS 3839:1985 Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм. Барилгын бүтээцийн галд тэсвэрлэлтийг турших арга
MNS 4115:1991 Барилгын галын аюулгүй байдал. Барилгын материалын ноцох чанар. Тэсвэрлэн шатдаг материалын анги тодорхойлох арга
MNS ISO 1182:2008 Галын аюулаас хамгаалах. Барилгын зориулалттай бүтээгдэхүүний галд тэсвэржилтийн зэргийг тодорхойлох
MNS 0012-104:1994 Тэсрэлтийн аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
“Захиргааны зориулалттай олон нийтийн барилга” /БНБД 31-04-11/
“Захиргаа аж аж ахуйн барилга” /БНБД 31-04-03/

Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм /ЗТБХБСайдын 2008 оны 53 дугаар тушаал/
 Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм /ЗТБХБСайдын 2008 оны 53 дугаар тушаал/
 “Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер” /БНБД 41-01-11/
 “Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж” /БНБД 40-02-06/
 “Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж” /БНБД 40-01-14/
 “Барилгын дулаан хамгаалалтын төлөвлөлт” /БД 23-103-10/
 “Барилгын дулаан техник” /БНБД 2.01.03- 92/2003/
 “Барилгын дулаан хамгаалалт” /БНБД 25-01-20/
 “Хийн хангамж” /БНБД 42-01-19/
 “Орон сууц, олон нийтийн барилгын хог дамжуулах хоолой” /31-11-10/
 “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” /БНБД 30-01-04/
 “Тохижилтын ажил” /БНБД 3.01.05.88/
 “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага” /БНБД 31-101-04/
 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм” /БД 31-112-11/
 MNS 6055:2009 Иргэний барилгын төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин
 MNS 6056:2009 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар
 “Цахилгаан байгууламжийн зураг төсөл угсралтын дүрэм” /БД 43-101-03/
 “Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг угсрах ба төлөвлөх” /БНБД 43-102-07
 “Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар” /БД 43-103-08/
 “Эмнэлгийн барилга” /БД 31-22-21/
 “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт” /БНБД 23-01-09/
 “Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг” /БНБД 23-02-08/
 “Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын /эзвэрлэлтийн/ хангамж” /БНБД 23-04-07/
 “Дуу чимээ тусгаарлалт” /БНБД 23-05-10/
 “Орон сууц, олон нийтийн барилгын хашлага бүтээцийн дуу тусгаарлалт” /БД 23-104-15/
 “Орон сууц, олон нийтийн барилгын байгалийн гэрэлтүүлэг” /БД 31-112-11/
 MNS 0012-1-009:1985 ХХСС. Шуугиан. Орон сууц, иргэний барилгад байж болох шуугианы төвшин
 MNS0900:2018 Хүрээлэн буй орчин.Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ"
 MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй.
 “Барилгын бүтээц ба буурийн найдваршил” /БНБД 20-01-11
 “Авто зогсоол” /БНБД 21-05-10/
 MNS 5021-2007 Худалдааны газар- түүний үйлчилгээний ерөнхий шаардлага
 MNS 6034:2009 Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага
Түлхүүр үг: аюулгүй ажиллагаа, гал түймрийн аюул, үндсэн үүргийн бүлэг өрөө, тооцооны онцлог параметр, хүн амд үйлчлэх өрөө-тасалгаа, найдваршил хангалт, эрчим хүчний хэмнэлт, ариун цэвэр,эрүүл ахуйн шаардлага хангалт.

3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Аванвестибюль:

а- хүйтэн агаар гаднаас орохоос хамгаалахаар үүдний танхимыг угтуулан төлөвлөсөн нэмэлт тусгай өрөө - гонх

б– үүдний харуулын шийдлийг хүлээхэд зориулсан үүдний нэмэлт танхим.

Авантайз/Авансцена «avant-scène гэх франц үг» - гэдэгт үндсэн тайзны нүүрэн талын хэсгийг ойлгоно. Энэ нь хөгжмийн байр ба үндсэн тайзны дунд, тайзны хөшигний өмнөх хэсэгт байрладаг.

Актовый зал -assembly hall / (“нийтлэг танхим”) -нийтийг хамарсан олон талт арга хэмжээ зохион байгуулахад чиглэгдсэн жирийн шалтай танхим. Энд “нийтлэг танхим” гэдэг томъёоллоор ашигласан болно.

Амбулатори: Нарийн мэргэжлээр төрөлжин дагнасан, зөвхөн үзлэг, эмчилгээ хийдэг эмнэлэг (хэвтүүлэхгүй).

Амбулатори-поликлиникийн байгууллага: Үзлэгт ирсэн хүмүүсийг эмнэлэгт хэвтүүлэхгүйгээр эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд

Антракт / intermission – Концерт, жүжиг тоглолтын явцад гаргадаг түр завсарлага.

Аэрозоль - (Аэро- + золь)- А /хатуу болон шингэн хэсэг агуулаагүй хий буюу хийн хольцын дисперс тогтолцоо. Б/ Агаар мандал дахь тоос, утааны өчүүхэн жижиг ширхэгүүдээс бүрдсэн хийн холимог. Энэ нь 0,1-ээс 10мкм хэмжээтэй байдаг.

Антресоль: Хоёр давхрын чинээ өндөр таазтай цэлгэр танхим дотор түүний өндөртэй адилхан, уг танхимынхаа талбайн 40%-аас багагүй зайтай бөгөөд танхим руугаа нээлттэй / задгай/, ашиглах боломж бүхий хагас задгай талбайг ойлгоно. Антресоль нь давхар биш юм.

Апартамент-отели: Хүн түр хугацаагаар амьдарахад зориулсан өрөө бүхий барилга. (Байнгын оршин суугч байлгах эрх эдлэхгүй).

Аудитори (лат. auditorium—«яриа сонсох байр») — Лекц уншихад зориулан тоногдсон том танхим.

Аквапарк: усан тоглоом тоглох дэд бүтэц бүхий зугаа цэнгээний цогцолборыг ойлгоно.

Агаарын рециркуляци - агаарыг эргүүлэн ашиглах систем.

Арьертайз /Арьерсцена (фр. arriere — арын) — тайцны үндсэн талбайн ард гаргасан өвөрмөц орон зай. Арьертайзыг үндсэн тайзны үргэлжлэл гэж үзэх ба энэ нь тайцны тоглолтыг илүү үнэмшилтэй болгохын хамт ба түүний чимэглэлийг байршуулах нөөц талбайн үүрэг давхар гүйцэтгэдэг.

Амфитеатр- (грек. amphitheatron, amphī–эргэн тойрон/ хүрээлсэн гэсэн, ба theatron – театр гэсэн нийлмэл үг). Энд үзмэрийн заалны, дараалан өндөрсөн суудлын эгнээ бүхий дугуйрсан хэсэг гэдэг утгаар ашигласан болно.

Атриум – Атриум гэдэгт олон давхар барилгын голд дунд үүсгэсэн, галерей, өрөө, тасалгаагаар хүрээлэгдсэн, түүний түүний давхаруудын (гурав ба түүнээс олон давхар) нийт өндөртэй дүйцхүйц өндөр таазтай, тодорхой хэсэг чөлөөт орон зай гэж ойлгоно. Атриум нь дээврээсээ нэвт гэрэлтүүлэгтэй байхынгол зориулалт нь агаар солилцоог сайжруулахад зориулагддаг.

Ийм орон зай нь байгуулалтын дагуу чигт / хөндлөн / үргэлжилсэн байж болох ба тэр нь өндөрийнхөө хэмжээнээс давуутай байвал түүнийг пассаж гэж нэрлэнэ.

Атриумын галлерейнуудын хооронд зорчих лифт буюу эскалатор төлөвлөж болно.

Спортын **арен/ спортивная арена** (от лат. *[h]arena* «песок») /sports arena –

а- Спортын уралдаан тэмжээн зохион байгуулахаар зориудаар тоногдсон байр.

б - спортын тэмцээн зохион байгуулагддаг гол талбар / задгай талбай буюу том танхим, заал/.

в- Албаны хүмүүс, сэлгээний тамирчид, шүүгчийн байртай ба явах зам гарцтай бөгөөд үзэгчдийн суудалд ойр спортын уралдаан тэмжээн зохион байгуулахад зориулан гаргасан заалны (гулсалтын талбай) шалны талбайн хэсэг.

г – Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад зориулсан байгууламж

Аянга зайлуулагч –Аянга хүлээн авах хэсэг, гүйдэл дамжуулах хэсэг, газардуулах төхөөрөмж гэсэн бүрдлүүдээс тогтсон иж бүрэн төхөөрөмж;

Амбулатори: Нарийн мэргэжлээр төрөлжин дагнасан, зөвхөн үзлэг, эмчилгээ хийдэг эмнэлэг (хэвтүүлэхгүй).

Амбулатори-поликлиникийн байгууллагууд: Үзлэгт ирсэн үйлчлүүлэгчдэд эмнэлэгт хэвтүүлэхгүйгээр эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд

Апартамент-отели: Хүн түр хугацаагаар амьдарахад зориулсан өрөө бүхий барилга. (Байнгын оршин суугч байлгах эрхгүй)

Аппарат, аппаратур: Эмчилгээ оношлогооны буюу бусад олон төрлийн зориулалт, нарийн үйл ажиллагаатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл.

Ариун цэврийн өрөө /санузел- гэдэгт угаагуур, суултуур, шүршүүр, усанд орох онгоцоор тоноглогдсон ариун цэвэр-эрүүл ахуйн өрөөг ойлгоно. Мөн нэмэлт тоног, хэрэгсэлтэй байж болно.

Атриум – Атриум гэдэгт олон давхар барилгын гол дунд үүсгэсэн, галерей, өрөө, тасалгаагаар хүрээлэгдсэн, түүний түүний давхаруудын (гурав ба түүнээс олон давхар) нийт өндөртэй дүйцхүйц өндөр таазтай, тодорхой хэсэг чөлөөт орон зай гэж ойлгоно. Атриум нь дээврээсээ нэвт гэрэлтүүлэгтэй байхба түүнийгол зориулалт нь агаар солилцоог сайжруулахад зориулагддаг. Атриумын галлерейнуудын хооронд зорчих лифт буюу эскалатор төлөвлөж болно.

Ийм орон зай нь байгуулалтын дагуу чигт / хөндлөн / үргэлжилсэн байж болох ба , тэр нь өндөрийнхөө хэмжээнээс давуутай байвал түүнийг пассаж гэж нэрлэнэ.

Аюулгүй бүс (галын аюулгүй бүс): Барилгын дотор буюу гадна талд байгаа хүмүүсийг галын аюултай нөлөөллөөс хамгаалсан, эсвэл тийм нөлөөлөл байхгүй буюу байж болох дээд хэмжээг даваагүй бүс

Хөгжим тоглох **байр** /Оркестровая яма/ orchestra pit - Энэ нь театрын тайз болон үзэгчдийн суудлын шалны түвшингээс зориуд дор байрлуулсан, хөгжим тоглох байр.

Барилга байгууламж гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг;

Барилга байгууламжийг засварлах гэж ашиглалтын хэвийн нөхцөлийг дээшлүүлэх зорилгоор барилга байгууламжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн засварлаж, нэмэлт болон тусгай тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг;

Барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх” гэж барилга байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн үндсэн бүтээц болон инженерийн шугам сүлжээг өөрчлөх, өргөтгөл, шинэчлэлт хийх үйл ажиллагааг;

Барилгын баримт бичиг гэж барилгын ажлын зөвшөөрөл олгох, барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай энэ хуульд заасны дагуу боловсруулж, баталгаажуулсан техникийн нөхцөлүүд, зураг төсөл, ил, далд ажлын акт, талбайн журнал болон холбогдох бусад баримт бичгийг;

Бие засах газар /уборная: гэдэгт бүхээгт суурьлуулсан суултуур, угаагуураар тоноглогдсон ариун цэвэр-эрүүл ахуйн өрөөг ойлгоно. Эрэгтэй хүнд зориулсан хэсэгт хөтөвчтэй байна.

Больниц – Нарийн оношлогоо хийж хэвтүүлэн эмчилдэг эмнэлэгийн стационар байгууллын өвөрмөц төрөл.

Барилгын өндөр (архитектур) нь Давхрын тоогоороо буюу газрын төлөвлөлтийн түвшинээс, барилгын бүтээцийн хамгийн өндөр түвшинд байгаа элемент (налуу дээврийн шувуу нуруу, хавтгай дээврийн хашлага хана / парапет/, бөмбөгөр орой гм-г хүртэл) хүртлэх босоо шугаман хэмжээгээр илэрхийлэгддэг барилгын үндсэн онцлогийн нэг. Үүний тусламжтайгаар уг барилгын зориулалтын агуулга, орчиндоо архитектурын зохиомж (хэлбэр, харьцаа, маштааб, өнгө, контраст, нюанс г.м)-ийн илрэл болдог.

Шигүү барилгажилт /затесненная застройка - тухайн газр дээрх барилгын тоог тогтоосон хэмжээнээс хэтрүүлсэн буу газрын хэмжээ нь дутагдсан байдал.

Веранд-Барилгы үндсэн дээвэрт багтсан буюу барилгад залган барьсан дээвэртэй, хоёр болон гурван талыг нь шиллэсэн, халаалтгүй тасалгаа.

вестибюль –vestibule –гэдэг нь үүдний танхимын тухай цогц олголт ,

“**Гадна тохижилтын ажил**” гэж барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, автозам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, архитектурын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж байгуулах үйл ажиллагааг;

Галын бүслэвч /Пожарный отсек- түймэр түгэхээс хамгаалсан барилгын эзэлхүүн – төлөвлөлтийн шийдлийн орон зайн нэгэн хэсэг

Галерей нь францын “galerie”, мөн италийн “galleria” гэсэн үгээс гаралтай ба дээвэр бүхий урт үргэлжилсэн өрөө тасалгаа буюу барилгын тодорхой хэсгээс нөгөөд хүрэх мөн зэрэгцээх хоёр барилгын хооронд хүн явах гарц, хүзүүвчийг нэрэлдэг болно. Гэхдээ галерей гэдэг үг өргөн утгатай бөгөөд жишээ нь урлагийн галерей (дүрслэх урлагийн бүтээл дэлгэн харуулах орон зай) гэдэг нэр томъёог хэрэглэдэг.

Гонх /тамбур- Хүйтэн агаар, утаа, эвгүй үнэр орохоос хамгаалан барилгын орцын гадна болон дотор хаалганы хооронд гаргасан дамжин өнгөрөх орон зай.

Ажлын **галерей-/театр/** рабочая галерея-technical gallery – тайзны дүүжин чимэглэл, гэрэл ба дууны төхөөрөмж харьцах зорилгоор хүн очиход зориулсан тайзны ханы дээд хэсэгт гарсан хүн явахад зориулсан барилгын бүтээц /байгууламж/

Двор /courtyards/-Барилгын буюу тэдгээрийн дунд, гол үүдийг нь зориуд угтуулан төлөвлөсөн олон зориулалт бүхий задгай талбай

Дельфинари-Сургуультай дельфиний /загас/ тоглолтыг хүмүүст үзүүлэхэд зориулсан тусгай усан сан

Депозитарий (от лат. *depositarium* - хадгаламж): гэдгийг үнэт цаасны сертификат хадгалах үйлчилгээ эрхэлдэг зах зээлийн мэрэгжлийн субъект гэж ойлгоно.

Довжоо - Байшингийн үүдний гишгүүр бүхий тавцан.

Дээврийн хөндий/чердак/ attic - Дээд давхрын хучилт ба дээврийн дундах хөндий орон зай.

Мансардын **давхар** /этаж мансардный (мансарда) гэж Нүүрэн тал нь /фасад/ нь бүхэлдээ буюу тодорхой хэсэгтээ налуу буюу нугаларсан гадаргуугаас эсвэл муруй дүрстэй дээврээс тогтсон бөгөөд мөн дээврийн ба нүүрэн талын гадаргуугийн

огтолцолын шугам нь энэхүү давхарын шалны түвшингээс 1,5 метрээс илүүгүй өндөрт тохиосон дээврийн хөндийд үүсгэсэн орон зайг ойлгоно. Ишлэл:[СП 54.13330.2016,]

Техникийн **давхар** /этаж технический -Инженерийн шугам сүлжээ / коммуникацийн /. Тоног төхөөрөмж байрлуулахад зориулсан өрөө. Харин инженерийн шугам сүлжээ байрлуулах 1,8 метрийн өндөртэй орон зайг өрөөнд тооцохгүй.

Хаяавчийн **давхар** /этаж цокольный: Гадна ханатай харьцах шалны түвшин нь газрын төлөвлөлтийн түвшинөөс доош, өрөөний өндөрийн талаас илүүгүй гүнд байдаг давхар /өрөө/.

Газар дээрхи (газрын) давхар /этаж надземный (наземный) гэдэгт газрын төлөвлөлтийн тэмдэгтээс өрөөнүүдийн шалны тэмдэгт нь доошгүй байршилтэй давхрыг нэрлэнэ.

Газар доорх давхарууд/этажи подземные гэдэгт Өрөөний нийт өндөр нь газрын төлөвлөлтийн тэмдэгтээс доош байрласан өрөөнүүд бүхий давхаруудыг ойлгоно

Биеийн тамир-спортын заал / физкультурно-спортивные залы- Биеийн тамир-спортоор хичээл, дасгал сургууль хийх болон уралдаан тэмцээн зохион байгуулах боломж бүхий 150 м² - аас том талбайтай, үзэгчдийн суудалтай болон суудалгүй том танхим.

Инсоляци нь латины *in* — «дотор» + *sōl* — «нар» гэсэн үгээс гаралтай ба энэ нь нарны гэрлийг гадаргуун дээр тусгах гэсэн санаа илэрхийлэх ба түүний гэрэл, дулаан , эрүүл мэндийн , гоо сайхны зэрэг олон талын ач холбогдолыг танин мэдсэн учраас архитектур, хот байгуулалтын чухал элемент гэж үздэг.

Капсула зочид буудал / капсульная гостиница гэж хэдэн цагаас 2-3 хоногийн хугацаагаар хүн түр /дүрэмд заасны дагуу / хугацаагаар амрах өрөө буюу капсультай зочид буудлыг нэрлэдэг. Давхар бүртээ зочидод зориулсан эрэгтэй, эмэгтэй хүний бие засах ба шүршүүрийн өрөөтэй байна. Бусад өрөөнүүдийг зураг төсөл зохиох даалгаварт зааснаар тодорхойлно.

Капсула гэдэг нь нэг хүнд зориулсан 2,0-м-ийн урттай/ гүн, 1,0 м-ийн өргөнтэй, тазаа хүртэл 1,25 м-ийн өндөртэй зочны өрөө болно. Энд ном унших, телевирзор харах боломжтой.

Карман /тайзны/ - тайзны чимэглэл солих ажиллагааг шуурхай болгох зорилгоор түүний зарим хэсгийг хадгалах зориулалт бүхий хажуу булангийн өрөө

Кулуар /Кулуáры /lobby–ыг театр, концертийн танхим, парламент, албан газрын барилгад үндсэн танхимаас тусад нь гаргасан тусгай зориулалт бүхий **өрөө, өргөн хонгил, мөн хажуугийн талын танхим** гэж ойлгоно. Үүнийг хурал цуглаан, үзвэрийн завсарлагаар хүмүүс түр амрах, санал бодлоо солилцох, албан бус уулзалт хийх, түүнчлэн сэтгүүлчид ажиллахад зориулан төлөвлөнө.

Колосники гэдэг нь театрын тайзны дээрх сараалжин тавцан бөгөөд хөшиг өргөх, буулгах, тайз солих, гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж байрлуулахад зориулсан тусгай байр юм (тайзны дээр гаргасан тусгай зориулалттай давцан, бас сам тайз гэж нэрлэх нь бий).

Коммуникаци гэдэг нь латины *communicatio* - мэдээлэл, дамжуулалт гэсэн утгатай үгнээс гаралтай ба олон салбарт хэрэглэгддэг үг юм.

Энд өрөөний хооронд мөн давхар хооронд хүн явах, эд бараа зөөхөд зориулсан хэрэгсэл (шат, шатны хонгол, лифт, лифтийн хонгил, эскалатор , галерей, хонгил /коридор /) гэсэн утгаар ашигласан болно.

Кондиционер (агаарын):

а - хүний тав тух болон технологийн үйл ажиллагаа явагдах тааламжтай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор өрөөний агаарын нийт эсвэл зарим параметрыг (агаарын температур, чийглэг, хөдөлгөөний хурдг.м) тодорхой түвшинд тогтвортой байлгахыг хэлнэ.

Агаарын кондиционерыг кондиционерын систем (КС) гэж нэрлэдэг цогц тоног төхөөрөмжөөр гүйцэтгэнэ. /Ишлэл:Кондиционерийн систем ба хөргөлтийн ачаалал ном УБ 2012 /

б – хүний тав тухыг хангах, технологийн үйл ажиллагаа явуулах ба эд юмсын бүрэн бүтэн байдлыг хадгалах хамгийн тааламжтай цаг уурын зохистой нөхцлийг бий болгох зорилгоор хаалттай өрөөний агаарын бүх болон зарим үзүүлэлтийг (температур, харьцангуй чийгшил, цэвэр байдал, хөдөлгөөний хурд) автоматаар барих.

Лифт: босоо чиглэлд тээвэрлэх зориулалттай, тусгай бүхээг бүхий цахилгаан шат

Лифтийн холл: хүн буух, суух, ачаа ачих ,буулгах зэрэгт зориулан лифтийн хаалгыг амдуулан төлөвлөсөн тусгай талбай.

Лоожи /лодж - барилгын гадна хананаас илүү гараагүй, нүүрэн тал нь задгай, бусад талаараа ханатай, хучилт бүхий задгай тасалгаа,

Люлька /барилгын / /строительная люлька /construction cradle – гэдэгт бэхэлсэн ган троссын дагуу дээшээ, доошоо явах боломж бүхий дүүжин тавцанг /төнөөрөмж/ ойлгоно. Люлькиг барилгын гадна тал /фасад/-ыг өнгөлөх, засах, цэвэрлэхэд голчлон ашигладаг тул фасадны люлька гэж нэрлэх нь олон оронд түгээмэл болжээ.

Люк - юм оруулах, гаргахад зориулан төлөвлөсөн онгорхой зай,

Медиатека /media library/- Цахим санд (electronic media) хадгалаастай мэдээллийг тав тухтай ашиглахад зориулсан орон зай буюу орчин үеийн цогц номын сан.Үүний фонд нь уламжлалт ном бичмэл материалын зэрэгцээ компьютер, видеокамер, магнитофон, видеомангитофон, проектор зэрэг цахим хэрэгсэл байдаг. Энэ нэр томъёоны тодорхойлолт нь дэлхий дахинаа нэг мөр болж амжаагүй байна.

Мотель нь жолооч нарыг хүлээн авахад зориулсан, төв замын дагуу байрласан жижигхэн зочид буудал юм. Буудлын өрөө болон үйлчилгээний сонголтын төрөл нь цөөн ба харин авто засварын тодорхой үйлчилгээ үзүүлдэг.

Норм /норма- norm / - нэгдсэн тодорхойлолт одоогоор байхгүй ба ерөнхийд нь журамлан тогтсон зөвшөөрөгдөх хэмжээ , хязгаар гэж ойлгоно.

а/ Нормыг эдийн засгийн ухаанд хязгааргүй хэрэглээг хязгаарлагдмал нөөцөөр хэрхэн хангахыг судалдаг шинжлэх ухаан гэж тайлбарладаг . Эл асуудлыг шийдвэрлэх нэг арга зам нь норм, норматив тогтоох явдал юм.

Норматив:

а - Нормын хэмжээнд үндэслэж тооцоологдсон, тухайн үйл ажиллагааны нөхцөлд байгаа нөөцөө үр нөлөөтэй зарцуулах боломжоор хангадаг, нөөцийн зардлын нэгжийн жигнэсэн дундаж хэмжээ.

б- /Тогтоосон хэм хэмжээ/

Нийтлэг зориулалтын танхим”/ Актовая зала -assembly hall - нийтийг хамарсан олон талт арга хэмжээ зохион байгуулахад чиглэгдсэн жирийн шалтай танхим.

Объект /архитектур/ – гэдэг бол зураг төслийн шийдлийн дагуу бүтээн байгуулах буюу барьсан цогц барилга байгууламж юм. Энэ ойлголтод экологи, барилга, байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, барилгын интерьер, ландшафт, орчны тохижилт, зэрэг өргөн хүрээтэй асуудал хамрагддаг .

Океанариум (фр. *Oceanarium*) — гэдэг нь энгийн утгаараа далайн ургамал, амьтны музей /үзүүлэн / ба мөн шинжлэх ухаан, танин мэдэхүйн байгууллага гэсэн утгыг агуулдаг байна. Энэ нэр томъёоны тодорхойлолт дэлхий дахинаа нэр мөр болоогүй.

Олон нийтийн барилга – гэж нийт иргэдэд үйлчилэх үйл ажиллаа эрхэлдэг байгууллагад зориулсан төрөл бүрийн зориулалт бүхий олон хэв шинжийн (А хавсралт) барилгыг ойлгоно.

Цэлгэр өрөө /орон зай / многосветное пространство, помещение / - гэдэг нь хэд хэдэн давхрыг нэгтгэн, тэдгээрийн өндөртэй дүйцхүйц өндөр таазтай, барилга дотор зориудаар гаргасан уужим цэлгэр орон зай болно.

Шалан доорх техникийн хөндий / Техническое подполье-1-р давхрын хучилт, хаяавчийн давхрын хооронд буюу ийм давхаргүй бол шал, газрын хөрсний хооронд инженерийн сиситемийн шугам хоолой байрлуулахад зориулсон орон зай.

“сургалтын **орчин**” гэж боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг нөхцөл болон сурах, сургах харилцааг ;

Организация – байгууллага , Жишээ нь :“сургалтын байгууллага” гэж боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийг;

Газрын төлөвлөлтийн тэмдэгт - түвшин / планировочная **Отметка** земли / - гэж барилгын хаяавч ба газрын зааг дээрхи өндөржилтийн төлөвлөлтийн **тэмдэгтийг** /геодези / ойлгоно.

Биеийн тамирын хичээл сургууль, дасгалын **өрөө**/ помещения для физкультурных занятий и тренировок- Ритмит гимнастик, тренажер, тулаан, хореограф гм-ийн хичээл сургууль, дасгал хийхэд зориулсан 150 м² ба түүнээс бага хэмжээтэй өрөө,

Ажлын тогтонго байртай **өрөө**/ помещение с постоянными рабочими местами – Албан хаагч нь тасралтгүйгээр 2 цагаас багагүй хугацаагаар буюу эсвэл ажлын цагийн 50 % -иас багагүй хугацаанд ажилдаг өрөө.

Хүн олноороо цуглардаг **өрөө** /помещение с массовым пребыванием людей/ - 50 м² ба түүнээс дээш талбайтай, цугларсан хүмүүсийн нягтрал нь 1 м² талбайд 1-ээс олон ноогддог өрөө. Тухайлбал: Үзмэрийн газрын фойе, танхим, хурлын танхим, лекцийн аудитори, хооллох танхим, хүлээлгийн танхим нь энд багтана.

Чиг үүргийн **уян зориулалттай** сууцны бус өрөө тасалгаа гэдэгт ашиглалтын тодорхой чиг үүрэг урьдчлан оноогоогүй бөгөөд харин ашиглалтын үед барилгын даацын бүтээцийг өөрчлөлгүйгээр албан ба аж ахуйн газрын төрөл бүрийн зориулалтаар өөрчлөх, тоноглох, түүнчлэн тодорхой өрөөг бие даасан байдлаар ашиглаж болохоор төлөвлөсөн ОНБ-н өрөө тасалгааны бүлгийг ойлгоно.

Биеийн тамир - спортын танхим /физкультурно-спортивные залы- Үзэгчидтэй тэмцээн зохион байгуулах буюу эсвэл биен тамир – спортын хичээл сургууль, дасгал хийх үзэгчдийн суудалгүй , 150 м² -ийн хэмжээтэй өрөө.

Ажлын дундын өрөө /общее рабочее помещение/: Эрхлэгчийн хамт 6 хүртэлх тооны хүн ажиллах ажлын байртай өрөө.

Партёр (фр. *parterre* - газар дээр) гэдэгт тайзанд хамгийн ойрхон байрласан үзэгчдийн суудалтай заалны тодорхой хэсгийг ойлгоно.

Пандус- Барилгын буюу гадна тохижилтын талбайн нэг түвшний гадаргуугаас нөгөө түвшний гадаргууд шилжих хөдөлгөөн хийхэд зориулагдсан тэргэнцэр, дугуйтай тэрэг түрэх зориулалттай налуу зам.

Палат / эмнэлэгийн салбар/: Өвчтөнүүдийг хэвтүүлж, өвчний оношлогоо ба эмчилгээ, сувилгаа, ажиглалт хийхэд зориулсан үндсэн өрөө, тасалгаа

Параметр: Тогтмол байвал зохих хэмжээ, үзүүлэлт

Планшет /тайзны/- жүжигчид тоглодог ба чимэглэлийн төхөөрөмж байршуулдаг талбар буюу тайзны шал.

Платформ (фр. *plateforme* от «хатгай» + *forme* «овор») – гэдэг нь олон утгатай үг бөгөөд энд өгсөх, буух гэдэг ойлголтын үүднээс өндөрсгөсөн тавцан /талбай/ гэсэн утгаар ойлгоно.

Подъемный платформ /lifting platform/-өргүүрийн тавцан

Проход – эд юмсийн хоорондуур /завсараар/ дамжин явах замын орон зай. Эсвэл ямар нэгэн зүйлийг дайран өнгөрөх хөдөлгөөн. Ж нь: Барилгын дундуур нэвтрэх гарц

Проем – хүн, машин явах, эд бараа оруулах гаргах, хаалга, цонх суулгах зэрэгт зориулан барилгын хананд, мөн түүний баганын хооронд зориудаар төлөвлөсөн хоосон зай. Проем бол нүх биш .

Сквозные **проезды** /Through passages– байшингийн дундуур /доогуур/ нэвт гарах үйлдэлд

Прямок /pit/ – гэдэг нь газар доорхи давхарт орох шат гаргах болон түүний байгалийн гэрэлтүүлэг , агаарын солилцоог сайжруулах зорилгоор барилгын ханыг дагуулан газарт гаргасан гүнзгийвтэр нүхэн орон зай юм. Хэлбэрийн хувьд тэгш өнцөгтэй эсвэл дугуйрсан байж болдог.

Портик гэдэг нь барилгын гол орцын үүдэнд гаргасан, хучилт (аттик) нь багана буюу арок дээр тогтсон архитектурын өвөрмөц орон зай бөгөөд латины «porticus» үгээс үүсэлтэй ба дэлхий олон орон адилханаар дуудан бичдэг байна.

Предприятие – үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж газар

Приют-ийг гарал үүслийн үүднээс авч үзвэл угтаа эзгүй газар яваа малчин, эрэлчин, анчин, уулчин зэрэг хүмүүсийг цаг агаарын таагүй үзэгдлийн үед хоргодоход зориулан барьсан энгийн хийцтэй, орон нутгийн онцлогтой жижигхэн орон байр юм.

Харин сүүлийн үед байгаль сонирхогч жуулчдад зориулан ийм байрыг зохих хангамжтай, тохилог болгон барьж ашигладаг болсноор жуулчны приют гэдэг болсон байна.

Пюпитр-бичих, сонсох, харах гэм мэт боломж сайжруулсан тусгай зориулалттай суудлын тоноглол (тоноглолтой суудлал).

Рекреа́ци (лат. *recreatio* «алжаал тайлал»)-Эрүүл болон ядарсан хүмүүсийн сэтгэл санааны болон биеийн алжаалыг тайлахад зориулсан, чийрэгжүүлэх ба эрүүлжүүлэх цогц арга хэмжээг ойлгоно.

Рекреацийн орон зай гэдэг нэр томъёо нь ерөнхийдөө алжаал тайлах,, чийрэгжүүлэх ба эрүүлжүүлэх зориулалт бүхий тусгай талбай бөгөөд харин энд сурагчдыг хичээлийн завсарлагаа болон чөлөөтэй үедээ түр амрахад зориулж сургуулийн барилгын төлөвлөлтийн шийдэлд тусгасан орон зай гэсэн утгаар ашиглав. Мөн хот төлөвлөлтийн салбарт ч ашигладаг.

Номын **сан** гэж уншигчид тодорхой хугацаанд ашиглуулах зориулалттай сан хөмрөг бүхий мэдээлэл, соёл, боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, нэгжийг;

Сан хөмрөг гэж уншигчийн эрэлт, хэрэгцээг хангах зорилгоор бүрдүүлсэн хэвлэлийн бүтээгдэхүүн болон мэдээллийн бусад эх сурвалжийн хадгаламжийг;

Сауна/ saunas - халуун хуурай уураар шардаг финийн бань /газар/.

Сейф скатанных декораций/ - Эвхмэл чимэглэл хадгалах шүүгээ.

Сервисийн үйлчилгээ (сервисное обслуживание/ routine servicing) - Гэдэг нь үйлдвэрлэгч буюу худалдагчийн талаас тавьж буй төлбөргүй буюу хөнгөлөлттэй төлбөрийн нэмэлт опци.

Эрчим хүчний салбарын/ аж ахуйн/ байгууламж ,тоног төхөөрөмжийн “Сервисийн үйлчилгээ” гэдэг нь: техникийн хэвийн ажиллагаа ба регламентжүүлсэн засвар, техникийн үйлчилгээ, эвдрэл саатлыг шалтгааныг илэрүүлэх,техникийн дүн шинжилгээний талаархи цогц арга хэмжээ болно.

Стационар (от лат. *stationarius* — тогтмол): - Өвчтөнийг хэвтүүлэх байнгын ортой эмчилгээний байгууллага . Оношлогоо хийгдэггүйгээрээ амбулатор ба больницоос ялгаатай

Стилобат гэдэг нь латин хэлний *stylobatēs*, грек хэлний *stulos pillar + -atēs*, гаралтай бөгөөд утгын хувьд дээр нь тулгуур ,багана болон хана барьсан газрын хөршнөөс ил гарсан хавтгаалж / хаяавчтай төстэй/ гэж тодорхойлдог. Ийм хавтгаалж нь ихэндээ шаталсан хэлбэртэй байдаг байсан ба бүхэлд нь стеробат гэж нэрлэдэг. Харин түүний хамгийн дээд хэсгийг нь эртний архитектурт “**стилобат**” гэж нэрлэдэг. Үүнийг хамгийн энгийнээр баганын суурь гэж ойлгож болно гэж эх сурвалжид тайлбарлажээ.

Стилобатная часть здания (стилобат) барилгын стилобатын хэсэг гэдэгт давхрын дээд талын өндрийн тэмдэгт /түвшин/ нь жигд бөгөөд хэд хэдэн барилгыг нэгтгэж буй тэдгээрийн хаяавчийн давхарын ерөнхий хэсгийг ойлгоно.

Мөн орчин үеийн архитектурт /пост моденизм/ хэд хэдэн өндөр барилгыг /цамхаг хэлбэрт / хооронд холбосон хаяавчийн давхрыг түүний стилобатын хэсэг гэж нэрлэж байна.

Үзэгчдийн суудлын **тавцан /трибуна/** - Үзэгчдэд зориулсан суудлын эгнээ нь уралдаан, тэмцээний талбай талаас эхлэн эгнээ эгнээгээр өндөрссөн барилгын бүтээцлэлийн элемент буюу бие даасан бүтээц.

Тайз /сцена /-Ший жүжиг тоглоход зориулсан тавцан

Тайзны гонхон – үндсэн тайзны хажууд байрлах жүжгийн тайз угсрах байр

Тайз дэлгэц /экрэн – Кино, үзүүлэн гаргах дэлгэц хөшиг

Нийтлэг **танхим** / (“актовая зала - assembly hall”) – нийтийг хамарсан олон талт арга хэмжээ зохион байгуулахад чиглэгдсэн жирийн шалтай танхим. Энд “нийтлэг танхим” гэдэг тогтоололор ашигласан болно.

Тагт – барилгын гадна хананаас тодорхой хэмжээгээр гадагш илүү гарсан , 3 талаараа хашлага бүхий задгай тавцан

Террас – Барилгатай залгаж газраас дээш нэг буюу хэд хэдэн гишгүүрийн дээр буюу эсвэл доод давхрын дээвэр дээр гаргасан, эргэн тойрон хайш хашлагатай задгай талбай.Террас дээвэртэй , мөн залгаа өрөө орох хаалгатай байж болно.

Камерный **театр** — Тодорхой цөөн тооны хүмүүст тоглолт үзүүлдэг жижигхэн /өрөө/ театр.

Газрын төлөвлөлтийн **түвшин / планировочная отметка земли/** - гэж барилгын хаяавч ба газрын зааг дээрхи түвшинг / **тэмдэгт/** ойлгоно.

Трюм – Үндсэн тайзны доорхи техникийн зориулалттай давхар.

Хүмүүсийн хөдөлгөөний **урсгалын нягтрал** / эвакуаци / плотность людского потока / - **Өрөөнөөс** нүүлгэн шилжүүлэхээр гаргаж байгаа хүний тоог **эвакуацийн замын талбайд** харьцуулсан харьцаа хүн/м²).

Фирма — Үйлчилгээ, худалдаа, болон үйлдвэрлэлийн төрөл бүрийн үйл ажиллагаа эрхлэн өөрийн ашиг сонирхолоо хэрэгжүүлдэг хууль ёсны эрх бүхий биенесийн байгууллагын нэгж.

Фойе /foyer фр — бол гол нь үзэгчдийг, концерт, жүжиг тоглолт болон хурал цуглаан эхлэхийгн өмнө түр хүлээлэх хугацаанд тухтай байлгах зориулалтын өрөө. Мөн үйл явдлын завсарлагааны хугацаанд ч ашигладаг.

Өндрийн огцом өөрчлөлт дээрх **хашлага** /ограждение на перепаде высоты: гэж хүн өндрөөс унахаас сэргийлж шат, тагт, антресоль, задгай талбай зэрэгт гаргасан барилгын бүтээцлэлийг ойлгоно.

"Хоолны газар" гэж зах зээлийн эдийн засгийн утгаараа хоол, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглэгчийн үйлчилгээг нэгэн зэрэг хослуулан цогц удирдлагаар хангаж зохион байгуулдаг, төрөл ангилал, хэв маяг, төрөлжилтөөр өөр хоорондоо ялгаатай, өмчийн олон хэвшилд хамаарах ашгийн төлөө болон нийгмийн үйлчилгээний хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны 206 дугаар тушаалын хавсралт /

Харанилице книги гэж ном хадгамжийн байрыг/ өрөөг ойлгоно.

Хоспис – Хүнд өвчтөн асрах эмнэлэгийн салбар – хөнгөвчлөх асаргааны цэг

Хижина гэдэг нь үндсэндээ приюттэй адил утгатай.

Цэвэр шал /чистый пол -finished floor –гэдэгт үндсэн их биеийг зохих ёсоор хийж гүйцэтгэн хивс, хивсэнцэр чулуу, хулдаас, паркет болон будаг гэх мэтээр өнгөлөн бүрэн дуусгасан шалыг ойлгоно.

Шатны хонгил/ **клетка лестничная**: шатны марш болон эргэлтийн талбай бүхий нийтээр ашиглах өрөө.

Шлюз - энэ нь шинжлэх ухааны олон салбарт хэрэглэгддэг нэр томъёо болно.

Энд хэрэглэсэн утга нь /анагаах ухаан/ ариун цэвэр, халдвар хамгааллын шаардлагын дагуу өөр өөр нөхцөлтэй, нэг дор байгаа хэдэн өрөөний нэгээс нөгөө рүү хүн /өвчтөн/ орох, эд зүйлс цөөхөд тэдгээр өрөө тасалгаануудын агаарыг бие биеэс нь тусгаарлах зориулалттай орон зай буюу нэг ёсны өвөрмөц гонх.

Эвакуация / evacuation:

а/ Аюул учирч болзошгүй газраас / бүс / хүн ам, соёлын үнэт зүйлс, эд хөрөнгийг хамгаалах, зохион байгуулалттайгаар нүүлгэх, зөөх ба тэдгээрийн аюулгүй газарт /бүсэд/ байрлуулахтай холбоотой цогц арга хэмжээ.

б/ барилга, байгууламжид онцгой тохиолдол учирсан үед хүмүүсийг аврах, эд хөрөнгө зөөх, аюулгүй газар байршуулах яаралтай арга хэмжээ авах цогц үйл ажиллагаа.

Основные эвакуационные проходы /the main evacuation passages - Эвакуацийн үндсэн гарцын орон зайн хэсэг,

Эстакад (фр. *estacade*) — гэдэгт зайгүй газарт (ялангуяа хотод) буюу замын түгжирэлтэй хэсгийг тойрон гарах зорилгоор газрын **түвшингээс дээгүүр хүн явах, инженерийн шугам сүлжээ байрлуулах, зам тавихад** зориулсан ижилхэн тулгуур, тэдгээрийн байршил нь жигд зайтай **урт үргэлжилсэн инженерийн байгууламжийг** ойлгоно.

Удаан **элэгдэлт** гэж ашиглалтын тооцоот хугацааны туршид техникийн үйлчилгээний доор зураг төслөөр тогтоосон физикийн ба бусад шинж чанарыг хадгалж хэвийн ашиглалтыг хангаж буй барилгын объектын чадварыг хэлнэ.

Ярус-гэдгийг олон янзаар ойлгон хэрэглэдэг. ж-нь ярусыг **архитектурт** /зохиомж/ хэвтээ чиглэлд хувиарласан давтагдах элемент, **байгууламжийн** давтагдах хэсэг гэсэн утгаар ашигладаг бол харин **театрт** үзэгчдийн заалны арын ба хажуу ханын дагуу гаргасан үзэгчдийн суудал бүхий тагт гэж тус тус ойлгоно.

4. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1. ОНБ-ын барилга, байгууламжийн зураг төсөл нь Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-12.1.8 шаардлагыг хангасан байна.

4.2. Боловсролын байгууллагын барилгыг ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламж БНБД 31-25-22, сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролын байгууллага БНБД 31-24-22, дээд боловсролын боловсролын байгууллагын барилга, мэргэжил олгох боловсролын байгууллагын барилгыг холбогдох нормын дагуу төлөвлөнө.

Усанд сэлэлтийн барилгыг Усанд сэлэлтийн барилга БД 31-116-12;

Спортын барилга байгууламжийг Спортын барилга байгууламж. БНБД 31-.....-.....; Хостелын барилгыг Хостел ба дотуур байр. СП 379.1325800.2018-д заасны дагуу тус тус төлөвлөнө.

Зээл-санхүү, татвар, шүүх, прокурар зэрэг бусад байгууллагуудын тусгай өрөөний бүтэц, түүний талбайн хэмжээг зураг төсөл боловсруулах даалгавраар тогтооно.

4.3 ОНБ-ын барилга, байгууламжийн зураг төслийн шийдэл нь “Барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх” /БНБД 31-23-22/-ийн шаардлагын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд саадгүй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх нөхцөл хангасан байна.

ХБИ-ний шаардлагад барилга, байгууламжийг нийцүүлэхтэй холбоотой зарим асуудал холбогдох эрх зүйн актад тусгагдаагүй онцгой тохиолдол гарвал тухайн асуудлыг батлагдсан “ЗТБД”-д заасны дагуу шийднэ.

4.4 Олон нийтийн барилга, байгууламж төлөвлөхдөө энэхүү норм, дүрмээс гадна мөн бусад тодорхой хэв шинжийн барилгын төлөвлөлтөд зориулсан ариун цэвэр, эрүүл ахуйн холбогдох MNS 5825:2007 "Орон сууц, олон нийтийн барилга. Өрөөний үзүүлэлт", MNS 4990:2015 “Ажлын байрны тохиромжтой орчин” зэрэг холбогдох нормативын шаардлагыг тусгана.

ЭДЭЛБЭР ГАЗАР

4.5. Олон нийтийн барилга, үйлчилгээний газар, албан байгууллага, аж ахуйн нэгж газрын нормт хэмжээг БНБД 30-01-04 ба зохих журмын дагуу боловсруулж батлагдсан ЗТБД-г үндэслэн тогтооно.

4.6. Зориулалтаар олгосон газарт барьж байгуулах барилга, байгууламжийг байршуулахдаа барилга байгууламжийн байршил, түүний төлвөлөлтийн шийдэл нь БНБД 30-01-04, УББ 11-202-00, БНБД 3.01.06-90 болон архитектур төлөвлөлтийн даалгавар, зураг төсөл зохиох даалгаврын шаардлага болон бусад норматив баримт бичгийн шаардлагатай нийцсэн байна.

Барилга байгууламжийн гадна тохижилтын талбай, ногоон байгууламж нь “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт БНБД 30-01-04”-д зааснаас багагүй хэмжээтэй байх ба тохижуулах ажлыг БНБД 3.01.06-90-ын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

БАРИЛГЫН ДАВХАР, ӨРӨӨНИЙ ӨНДӨР

4.7 ОНБ-ын давхрын тоо ба нийт, ашигтай, тооцооны талбайг тооцох дүрмийг Б хавсралтаас, давхаржуулалтад тавих шаардлагыг тус норм, дүрмийн 6 дугаар бүлгээс лавлана.

4.8 Шинээр барих олон нийтийн барилгын давхрын (шалнаас тааз хүртлэх) цэвэр өндрийг 3 м-ээс багагүй байхаар тооцох ба хэрэв энэ заалтад хамрагдаагүй бол энэ хэмжээг зочид буудлын өрөөнд “Зочид буудлын барилга төлөвлөлт” СП 257.1325800.16-д; хостелд “Хостель ба Дотуур байр төлөвлөлт СП 379.1325800.18-д; амралт, сувилал ба амралтын газарт MNS 6034–д заасны дагуу тус тус тооцно.

4.8.1 Шинээр төлөвлөж байгаа ерөнхий боловсролын байгууллагын барилгын өрөөний таазны өндөр 3.3 м-ээс багагүй байна. Гэхдээ байгалийн уур амьсгалын хувьд I бүсэд (БНБД 23-01-09) орших, 300-аас дээш тооны суралцагчидтай ерөнхий боловсролын байгууллагын барилгын хувьд энэ хэмжээ 3 м-ээс багагүй байна.

Сургуулийн барилгын дүүжин тааз бүхий хонгилын таазны өндөрийн хэмжээ 2.6 м-ээс багагүй байна.

4.8.2 Олон айлын сууцны барилга дотор төлөвлөх 40 хүртэлх хүний багтаамжтай олон нийтийн зориулалттай байгууллага, албан газар (бүлгээр сургах сургалтын байгууллагаас бусад) мөн 250 м² -аас илүүгүй худалдааны талбай бүхий жижиглэн худалдааны газар болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагад зориулсан өрөөний таазны өндрийг олон айлын сууцны барилга дотор төлөвлөсөн дотуур байрны өрөөний адилаар төлөвлөж болно.

4.8.3 Үйл ажиллагааны зориулалтыг өөрчилж болох уян хатан зориулалт бүхий сууцны бус өрөө тасалгааны цэвэр өндрийг (инженерийн тоног төхөөрөмж, дүүжин тааз тоноглох боломжийг харгалзан) 3.5 м-ээс багагүй төлөвлөнө. Олон нийтийн зориулалттай 4.7 м ба түүнээс дээш өндөртэй өрөө тасалгаанд давхар дундын түвшин дэх хэсэгчилсэн хучилт төлөвлөж болох ба уг хучилтын дээрх ба доорх цэвэр өндөр 2.2 м-ээс багагүй байна.

4.8.4 Засаг захиргааны барилга, албан тасалгаа, нийтийн болон дотуур байрны өрөө тасалгаа, уур амьсгалын I бүсэд (БНБД 23-01-09–д заасан) баригдах "300 хүртлэх суудалтай ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын давхрын цэвэр өндрийг 2.7 м-ээс багагүй байхаар төлөвлөнө.

4.8.5 Үйл ажиллагаа нь технологийн процесстой хамааралтай өрөөний таазны өндрийг холбогдох технологийн болон эрүүл ахуйн нормын шаардлагад нийцүүлэн төлөвлөнө.

Үйл ажиллагааны чиг үүргийн хувьд туслах шинжтэй өрөө болон мөн хонгилын таазны өндрийг 2.2 м хүртэл бууруулж болох ба зочдод зориулсан үүдний танхимын /холл/ таазны өндөрийг 2.4 м-ээс багагүй байхаар төлөвлөвөл зохино.

4.8.6 Олон нийтийн барилгыг (ерөнхий боловсролын сургууль ба сургуулийн өмнөх насны боловсролын байгууллагын) шинэчлэх, өөрчлөхөд одоо байгаа таазны өндрийг хэвээр үлдээж болох боловч энэ хэмжээ нь өрөө тасалгаанд 2.4 м, хонгилд 2.2м-ээс тус тус багагүй байна.

Харин техникийн давхарын хувьд таазны өндөр нь дотогшоо цухуйсан бүтээц хүртэл 2.1 м-ээс багагүй байна.

Үйлчилгээний ажилтан, ажилчид явах битүү орон зайн /хонгил/ таазны өндөр дотогшоо цухайсан бүтээц, инженерийн шугам сүлжээ болон бусад элемент хүртэл 1.8 м-ээс багагүй байна. Харин энэ орон зайн үргэлжлэх замын урт 2 м хүртэл байвал

дээрхи хэмжээ 1.6 м хүртэл байна. Техникийн давхарт төлөвлөсөн эвакуацийн зам дахь /проход/ нэлхийн /проем/ өндөр 1.8 м-ээс багагүй байна.

Шаталтын зэрэглэлийн хувьд БНБД 21-01-02, БНБД 21-02-02-ын заалтаар зөвшөөрөгдсөн материал ашигласан шалтай ба инженерийн шугам сүлжээ тоноглох өрөөний эгц доор төлөвлөсөн техникийн өрөөний өндөр нь шинээр төлөвлөх барилгын хувьд 1.6 м-ээс багагүй байна.

ҮҮД, ОРЦ, ШАТ, ЛИФТ

4.9 Барилгын үүдний талбайн түвшин явган хүний замын түвшингээс дээш байна. Иймд орцын довжоо нь хамгийн багадаа түүнээс 0,15 м-ээс багагүйгээр өргөгдсөн байна. Тухайн газрын төлөвлөсөн түвшин барилгын шалны түвшинтэйгээ адил байж болох ба энэ тохиолдолд хурын ус дотогш орохоос сэргийлсэн арга хэмжээ тусгана.

4.10 Гаднаас үүдний танхим болон шатны хонгил руу шууд орж болохоор төлөвлөх тохиолдолд тэдгээр хаалганд БД 31-112-11-д заасан дагуу үүдний гонх төлөвлөх буюу эсвэл түүнийг БНБД 41-01-02-ын дагуу халуун агаарын хөшгөөр төхөөрөмжлөнө.

Уур амьсгалын нэгдүгээр бүсэд баригдах барилгын орц давхар гонхтой байх ба тэдгээрийг байрлуулах, төлөвлөхдөө гонхноос дотогшоо үүдний танхим руу орох хаалганы байрлалыг гаднаас орсон чигээрээ шууд (сквозно) орохоор эсвэл зөв буюу солгой гар тийшээ хагас эргэн булангийн хаалгаар орох хувилбарын аль нэгийг сонгоно.

Гадна талын гонх нь байгалийн гэрэлтүүлэгтэй байна. Шатны хонгил дахь хаалгыг технологийн хэсгийн шаардлагын дагуу зөвхөн эвакуацийн зориулалтаар ашиглах бол уг хаалгыг дулаалсан тохиолдолд гонхгүй төлөвлөж болно.

4.11 БОСОО ЧИГЛЭЛИЙН ТЭЭВЭР

4.11.1 Төлөвлөж байгаа барилга байгууламжийн үйл ажиллагааны технологид нийцүүлэн босоо чигт тээвэрлэх зориулалтын хэрэгсэл болох лифт, эскалатор мөн ХБИ тээвэрлэх хашлагатай өргөгч тавцан болон ийм зориулалтын бусад өргөх төхөөрөмжийг олон нийтийн барилгад ашиглана.

Эдгээрийг норматив, баримт бичгийн [5]-д болон бэлтгэн нийлүүлэгчийн зааварт заасан аюулгүй ажиллагааны шаардлагад нийцүүлэн төлөвлөж, тоноглоно.

4.11.2 Дараах нөхцөлд зорчигчийн лифт төлөвлөнө. Үүнд:

Шинээр төлөвлөж буй олон нийтийн барилгад (хэрэв эдгээр нь БД 31-112-11-ийн шаардлагад үл хамааралтай бол), Тухайлбал:

- дээд давхрын шалны түвшин нь нэгдүгээр давхрын шалны түвшнээс 9,9 м буюу түүнээс дээш байх;

- амралт - аршаан сувилал, гурван одтой зочид буудал, жуулчны бааз, мотелийн барилгын дээд давхрын шалны түвшин нь нэгдүгээр давхрын шалны түвшнээс 6,6 м буюу түүнээс дээш байх;

- Хоёр ба түүнээс дээш давхар барилга бүхий больниц, төрөх газар, , амбулатор-поликлиник, ерөнхий боловсролын байгууллага, хүн амд нийгмийн үйлчилгээ үзүүлэх сувилалын газар, түүнчлэн “дөрвөн одтой”, “таван одтой” зочид буудал, мотельд;

- Харин айлын сууцны байдлаар төлөвлөсөн “Апартамент-отельд” лифт төлөвлөхдөө БНБД 31-01-10-ын шаардлага дагуу боловсруулсан ЗТБД-ыг баримтлана,

- Эмнэлэг, төрх газар, хосписын барилга, сувилагчийн асаргаатай байранд,

сэхээн амьдруулах төвд, мөн өндөр настны ба ХБИ–ийн дотуур байранд болон дүгээр давхраас дээш байрласан тасагт эмчлүүлж байгаа өвчтнийг дугуйтай ороор зөөхөөр төлөвлөх тохиолдолд лифт төлөвлөнө.

Төслийн технологийн хэсгийн шаардлагаар нотлогдсон бол лифтийг хуучин барилгад мансардын давхар нэмэхэд төлөвлөлхгүй байж болно.

Харин өвчтөн зөөх лифттэй бөгөөд тэдгээрийн хийц бүтээц, бусад систем нь зорчигчд зөөхөөр тоноглогдсон байвал зорчигчийн лифт төлөвлөхгүй байж болно.

4.11.3 Дээрх хэсэгт заагаагүй бол ачааны лифт ба босоо тээврийн бусад хэрэгсэл төлөвлөх зайлшгүй нөхцлийг технологийн шаардлагаар тогтооно.

4.11.4 ОНББ-ын зорчигчийн лифтийн тоог тооцоонд үндэслэн тогтоох ба гэхдээ хоёроос цөөнгүй байна. Босоо чиглэлд тээвэрлэх хэрэгслийн тоо тооцоогоор нэг байх нь хангалттай гэж нотлогдсон бол түүний нэгийг зорчигч, ачаа тээвэрлэх хос зориулалттай байхаар өөрчилж болно.

Сургуулийн өмнөх ба ерөнхий боловсролын байгууллагад лифт нэгийг (хэрэв нэгээс олон лифт байх шаардлагагүй болох нь тооцоогоор нотлогдсон бол) буюу хоёр давхар барилгад лифт төлөвлөхгүйгээр (хэрэв Галын аюулаас хамгаалах систем. Эвакуацийн зам ба гарц СП 1.13130.2009 норм, дүрмийн шаардлагад нийцсэн, ХБИ-н аюулгүй байдал ба галын аюулгүй байдлыг хангахтай холбоотой норм, дүрмийн шаардлагыг хангасан бол), түүний оронд шатны хонгилд байрласан хашлага бүхий өргөгч тавцанг төлөвлөж болно. Гэхдээ өргөгч төхөөрөмж зайлшгүй хэрэгтэй болохыг тухайн орон нутгийн боловсролын асуудал хариуцдаг, сургуулийн өмнөх ба ерөнхий боловсролын байгууллагын сүлжээг тодорхойлдог орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагатай зөвшилцсөн ЗТБД-аар тогтооно.

Тайлбар.

1 Гадаа байрлалтай өргөх төхөөрөмж тоноглох зайлшгүй шаардлагыг “Машин, тоног төхөөрөмж ба техникийн бусад хэрэгсэл. Гадаах орчны уур амьсгалын хүчин зүйл ба технологийн шаардлага ГОСТ 15150 –д заасан болон ЗТБД -аар тодорхойлоно.

2 Шатны хонгилд байрласан хашлага бүхий өргөгч тавцан байх тохиолдолд тус тавцан нь галын автомакийн дохиоллоор нэг дүгээр давхарт буудаг байна. Тэгэхдээ дараах нөхцлийг (хэрэв заасан тавцан нь эвакуацийн гарцын нормативт өргөнийг багасгаагүйгээс бусад тохиолдолд) хангасан байна.Энэ нь:

- түүнийг ашигласаны дараа эвхэх боломжтой байх;*
- өргөгч тавцан нээгдэх үед шатны хонгилын эвакуацийн гарцын өргөн 0,8 м-с багагүй байна.*

Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аврах арга хэмжээнд тэргэнцэр ашиглах нөхцөлд лифтийн тоо тооцоогоор нэг байх нь нотлогдсон бол сургуулийн болон СӨНХБ -д 630 кг-аас багагүй даацтай лифт нэгийг төлөвлөж болно.

Өвчтэй хүмүүсийг эмнэлэгийн дамнуургатай нь зөөх боломж бүрдүүлэх зорилгоор аль нэг лифтний бүхээгний хэмжээг 2100x1100 мм буюу эсвэл 1100 x2100 мм-ээс багагүй байхаар төлөвлөнө. Хэрэв хаалганы нээлхийг лифтний өргөн талд гаргахаар төлөвлөсөн бол тэр нь төвөөсөө хажуу тийшээ /гүйдэг/ шилждэг байх ба нээлхийн өргөн нь 1200 мм байна.

4.11.5 Хамгийн алслагдсан өрөөний хаалганаас хамгийн ойр байх лифтний хаалга хүртлэх зай 60 м-ээс илүүгүй байна. Зорчигчийн лифтний үүдний талбайн өргөн нь лифтийн төрөл,байршлаас хамаарч өөр байх тул доор дурьдсан хэмжээнээс багагүй байна. Үүнд:

Лифтийг нэг эгнээгээр байршуулах бол:

- Лифтний бүхээгийн гүн 1500 мм хүртэл бол 2 м,
- Лифтний бүхээгийн гүн 1500 -ээс их 2000 мм хүртэл бол 2,5 м,
- Лифтний бүхээгийн гүн 2000 мм -ээс их бол бүхээгийн гүний хэмжээг 1.3 дахин өсгөж тооцно.

Харин лифтүүдийг хоёр эгнээгээр байршуулах тохиолдолд үүдний талбайн өргөний хэмжээг тогтоохдоо хамгийн бага хэмжээтэй бүхээгийн гүний хэмжээг хоёр дахин өсгөсөнөөс багагүй байхаар сонгоно.

4.11.6. Лифтийн машины өрөө, агаар сэлгэлтийн суваг /шахт /, шахуургын өрөө, хөргүүрийн төхөөрөмжийн машины тасаг, дулааны зангилаа зэрэг төхөөрөмж суурьлуулсан бусад өрөөнүүд нь дуу шуугиан, чичиргээ үүсгэх гол эх үүсвэр болдог тул тэдгээрийг үзвэрийн ба сургалтын танхим, тайз, дууны аппарат, уншлагын танхим, эмчийн үзлэгийн ба хагалгааны өрөө, өвчтний тасаг, хүүхдийн байгууллага дахь хүүхэд бөөгнөрдөг өрөө, сургалтын танхим, хүмүүс байнга цуглардаг өрөө тасалгаа, кабинет, мөн олон нийтийн барилга дотор төлөвлөсөн сууцны өрөөнүүдийн чанх дээр, дор болон тэдгээрийн бусад талуудад шууд тулгаж байршуулахыг хориглоно.

Хэрэв тэдгээрийг дээр нэрлэсэн өрөө тасалгаануудтай шууд тулгаж байршуулах буюу эсвэл халз дээр, дор нь байрлуулах шаардлага үүсвэл дуу чимээний даралт, чичиргээний түвшиний зөвшөөрөгдөх нормативт хэмжээг БНБД 23-05-10 ба бусад холбогдох норм, дүрмийн заалтуудтай нийцүүлэх нэмэлт арга хэмжээ төлөвлөнө.

4.12 Ус, дулаан, цахилгаан, хий хангамж, цахим хэрэгсэл, холбоо мэдээлэл, галын аюул,

4.12.1 Олон нийтийн барилгад ахуй-унд, гал унтраах ус ба халуун усны хангамж, ариутгах татуургын, борооны ус зайлуулах шугам сүлжээ төлөвлөхдөө БНБД 40-05-16*/20-ын шаардлагад нийцүүлнэ.

Ариун цэврийн хэрэгсэл, технологийн болон бусад тоног төхөөрөмжийг холбогдох ариун цэврийн норм, дүрмийн болон, тоног төхөөрөмжид тавих шаардлага, болон зайлшгүй тохиолдолд зургийн даалгавартай нийцүүлэн төлөвлөнө.

4.12.2 Олон нийтийн барилгад унд ахуй, гал унтраах болон халуун усан хангамж, ариутгах татуурга, борооны ус зайлуулах шугам сүлжээг БНБД 40-01, БНБД 40-02, БНБД 40-05-н шаардлагад нийцүүлэн төлөвлөнө.

Халуун усны шугам хоолойг сантехникийн хэрэгсэл, технологийн болон бусад тоног төхөөрөмжтэй холбохдоо эрүүл ахуйн нормын шаардлага, тоног төхөөрөмжид тавих шаардлага болон зарим тохиолдолд зургийн даалгавартай нийцүүлэн төлөвлөнө.

ОНБ-д төслийн технологийн хэсгийн шаардлагад нийцүүлэн дотор агаарын хэм, чийглэг зэрэг бичил цаг уурын орчны шаардлагыг хангах зорилгоор халаалт, агаар сэлгэлт, кондиционерийн систем төлөвлөнө.

Халаалт, агаар сэлгэлт, агаарын кондиционер мөн түүнчлэн галын аюулын үед утаа зайлуулах системийг БНБД 41-01-11, БНБД 21-01-02, БНБД 21-02-02, эмнэлгийн барилгад БНБД 31-22-21 болон энэхүү норм, дүрмийн шаардлагад нийцүүлэн төлөвлөнө.

4.12.3 ОНБ-д цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, телефон ярианы олон нийтийн сүлжээнд холбогдох систем, телевизийн ба FM радио нэвтрүүлэг хүлээн авах сүлжээ, түүнчлэн аюулт үзэгдэл, байгалийн гамшиг, гал түймэрийн аюулын зарлан мэдээлэл дамжуулах зориулалт бүхий холбоо мэдээллийн цогц сүлжээ төлөвлөх ба 5м²-аас доошгүй талбайтай холбоо мэдээллийн сүлжээний техникийн өрөө төлөвлөнө.

Гамшгаас хамгаалах тухай хууль, Онц байдлын тухай хуулинд нийцүүлсэн ЗТБД-ын дагуу цогцолбор барилга, бие даасан объект болон өрөө тасалгааг электрон цагны, онцгой байдлын холбоо, зарлан мэдээллийн систем, орон нутгийн (дотоод) телефон ярианы тоног хэрэгсэл, телевизор, шууд орчуулгын орон нутгийн төхөөрөмж , цаг дохиоллын төхөөрөмж, мэдээлэлжүүлэлт ба дуу тохиргуулгын систем, барилгын инженерийн хангамжийн тоног төхөөрөмжийн диспетчер, автомажуулалтын систем, цаг агаарын онцгой үзэгдэлийн (салхи, шуурга, агаар бохирдолт ба үер) мэдээ түгээх зориулалтын ба бусад системээр тоноглоно.

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын, өндөр настан ба хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотуур байр болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ба мөн эмнэлэгийн барилгад галын болон бусад онцгой байдлын мэдээлэлийг хяналтын цэг төвд дамжуулах сүлжээний төхөөрөмжөөр тоноглоно.

4.20 ОНБ–д төрөл бүрийн компьютер, серверийн, видео-хурал, видео-дэлгэц, проектор, видео-дэлгэц, проектор зэрэг цахим төхөөрөмж болон бусад электрон техникийн хэрэгсэл бүхий өрөө төлөвлөхдөө эрүүл ахуйн холбогдох норм, дүрэм болон MNS 51 50.2002 стандартын шаардлагатай уялдуулах ба интернетийн сүлжээнд холбох боломжийг тусгасан байвал зохино.

4.21 ОНБ-ын цахилгаан техникийн тоног төхөөрөмж түүнчлэн цахилгаан хангамжийн нөөц, эх үүсвэрийг (зайлшгүй тохиолдолд) БНБД 43-102-07 ба холбогдох норм, дүрмийн шаардлагатай нийцүүлэн төлөвлөнө.

4.22 Барилгыг аянгаас хамгаалах тоноглолыг телевизорын антенн, телефон сүлжээний металл шон буюу өргөн нэвтрүүлэгийн утсан сүлжээ зэрэгтэй уялдуулан БД 43-102-07-ын дагуу суурьлуулна.

4.23 "ХИЙН ХАНГАМЖ"

4.23.1 Олон нийтийн барилгын хийн хангамжийн системийг Хийн хангамж БНБД 42-01-19 -ын шаардлагад нийцүүлэн төлөвлөнө.

"Сургуулийн өмнөх насны боловсролын байгууллага, ерөнхий боловсролын байгууллага, хүн эмнэлэг, театр, кинотеатр зэрэг олон нийтийн барилга доторх хүнсний блок, кафе, гал тогоо, буфетэд 220 граммаар савласан нэг удаагийн зориулалттай хий болон ийм төрлийн зориулалттай хийн тулга, тоног төхөөрөмж, дахин цэнэглэдэг хийн баллон байрлуулж, ашиглахыг хориглоно

Эмнэлгийн барилгын шатдаг хийн хангамжийг эмнэлэгийн барилга төлөвлөх холбогдох норм дүрэм, стандартын шаардлагын дагуу төлөвлөнө.

4.24 БАРИЛГА ДУНДУУР НЭВТ ГАРАХ ГАРЦ, ОСЛЫН ГАРЦ

4.24.1 Тухайн барилга, байгууламжийн газрын төлөвлөлтийн болон нэгдүгээр давхрын түвшиний өндөрт, түүний дундуур нэвт орж, гарах зориулалтын нээлхий орон зайг (галын машинаас бусад явган зорчигч болон авто хөгсгийн гарц) зорчиход хүндрэл учруулахааргүй бол ямар ч хэлбэр, овор хэмжээтэй төлөвлөж болно.

Ийм нээлхий орон зайг галын машин явахад зориулах тохиолдолд түүний өргөн (цэвэр зай) 3.5 м-ээс, өндөр 4.5 м-ээс багагүй байвал зохино.

Барилгуудын дундах задгай талбайн (двор / courtyards) хэмжээ 250 м² -аас бага байвал түүний дундуур галын машин явах гарц төлөвлөхгүй.

Харин барилгуудын (түүхийн дурсгалт барилга, объектуудын дундахаас бусад) дундах задгай талбайн (двор / courtyards) хэмжээ 250 м² –аас их байвал галын машин явах гарцыг Объектын галын тархалтын хамгаалалт БД 50-103-21-ийн шаардлагад нийцүүлэн төлөвлөнө.

4.25 ДЭЭВРИЙН УС ЗАЙЛУУЛАЛТ

4.25.1 Барилгад тавигдах дараах онцлог шаардлагыг харгалзан үзсэний үндсэн дээр түүний дээврийн налуу, ус зайлуулах системийг ялгавартай төлөвлөнө. Тухайлбал:

давхрын тоо таваас хэтрэхгүй барилгад дээврийн усыг нь зохион байгуулалттайгаар гадагш зайлуулахаар,

зургаа ба түүнээс дээш давхартай барилгад дээврийн усыг барилга дотуур зайлуулахаар тус тус төхөөрөмжлөнө.

Тайлбар: Давхрын тоо нь 5-аас хэтрэхгүй барилгад шувуу нуруутай, налуу дээвэр төлөвлөж болно.

Давхрын тоо нь хоёроос хэтрэхгүй, гол орц ба хоёрдугаар давхар дахь тагт нь саравчтай, дээврийн хөвөөний /карнизын/ өнгийлтийг 0,6 м-ээс багагүй байхаар төлөвлөсөн бол дээврийн усыг зохион байгуулалтгүй зайлуулж болно.

Дээврийн усыг дотуур зайлуулах системийг гудамжны борооны ус зайлуулах сувагт холбох ба харин ийм суваг байхгүй тохиолдолд барилгын ойр орчмын зүлэг, ногоон байгууламжийн талбай руу урсгахаар тоноглоно.

Энэ тохиолдолд борооны усны цоргыг хөлдөхөөс сэргийлсэн арга хэмжээ тусгана

Дээврийн өндрийн түвшин шаталсан бөгөөд түүний зөрүү 1,5 м-ээс их байх тохиолдолд дээд талын хэсгээс доод хэсгийн дээвэр рүү зохион байгуулалтгүйгээр ус урсгахаар төлөвлөхгүй ба дээврээс буух ус доод хэсгийн дээврийн бүтээцийг гэмтээхээс хамгаалах арга хэмжээ тусгана.

Ашигладаг дээвэртэй ОНБ төлөвлөхдөө БНБД 31-07-05 баримтлана.

4.27 ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТ

4.27.1 ОНБ-д Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн дагуу барилгын эрчим хүчийг хэмнэх бүх арга хэмжээг тусгах бөгөөд юуны өмнө хэрэгцээнээс илүү талбай, илүү эзэлхүүн төлөвлөхгүй, гадна ханын талбай ба барилгын талбайн харьцаа хамгийн үр ашигтай байх оновчтой төлөвлөлт сонгох, барилгын хана, дээвэр зэрэг хаших хийцийг дулаалах, цонх, хаалганы дулаан тусгаарлалтыг сайжруулах, шиллэгээний зохистой харьцаа сонгох зэрэг болно.

БУСАД ЗОРИУЛАЛТЫН ӨРӨӨ ТАСАЛГАА

4.28 Олон нийтийн барилгад хүн түр хугацаагаар суух (амьдрах) өрөө төлөвлөхдөө БД 31-01-10–ын шаардлагатай уялдуулна.

Зочид буудлын зочны өрөө төлөвлөхдөө “Зочид буудлын барилга. СП 257.1325800.2016. Барилгын зураг төсөл боловсруулах дүрмийг мөрдөнө.

4.29 Байгууллагын үйл ажиллагааны технологийн шаардлагын бүрэлдүүнд багтсан, зураг төсөл зохиох даалгаварт заасан, үйлдвэрлэл, агуулахын зориулалттай өрөөг олон нийтийн барилгад багтаан төлөвлөж болно.

4.30 Тухайн олон нийтийн барилгын аюулгүй ажиллагааны мөн эрүүл ахуй, экологийн шаардлагын нөхцөл хангагдахаар байвал уг барилга байгууламжид өөр зориулалтын өрөө төлөвлөхийг зөвшөөрнө.

4.31 Засаг захиргаа, боловсролын байгууллагын барилгад төрөл бүрийн зориулалттай үйлдвэрлэл эрхлэх болон лабораторын өрөө төлөвлөхдөө БНБД 31-11-09–ын шаардлагад нийцүүлнэ.

Харин хуулбарлан олшруулах техникт зориулсан өрөө төлөвлөхдөө “Хуулбарлан олшруулах ажлын зохион байгуулалтад тавигдах эрүүл ахуйн шаардлага. СанПиН 2.2.2.1332-03” –г удирдлага болгоно.

4.32 Гал түймрийн онц аюултай болон гал түймрийн аюултай нэг, хоёрдугаар зэргийн барилга байгууламж байршуулах шаардлагаар сонгосон тухайн ОНБ-д хосолмол зориулалттай өрөө , тасалгаа төлөвлөх тохиолдолд зураг төсөл зохиох даалгавар болон холбогдох норм, дүрмийг баримтлана.

4.33 Хаяавчийн болон газар доорхи давхарт болон стилобатын хэсэгт байршуулахыг цэвшөөрөх өрөө, тасалгааны жагсаалтыг В хавсралтаас үзнэ

4.34 Олон айлын сууцны барилгын стилобатын хэсэгт байршуулахыг зөвшөөрөх өрөөний жагсаалтыг В хавсралтаас ашиглана.

Тайлбар: Стилобатын хэсгийн дээвэр дээр холбогдох өрөө рүү орох хаалга, хүүхэд тоглох, биеийн тамирын, насанд хүрэгсэд амрах талбай төлөвлөж болно.

4.35 ОНБ дотор амьтны хүрээлэн байгуулахыг хориглоно.

5 ҮНДСЭН ӨРӨӨНИЙ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ХАМГИЙН ЗОХИСТОЙ ПАРАМЕТР

Нийтлэг заалт

5.1 Тухайн ОНБ-ын төрөл, түүний үйл ажиллагааны ба технологийн онцлогт нийцүүлэн өрөө тасалгааны бүтэц бүрэлдүүн , талбайн хэмжээг энэхүү норм, дүрэмд заасан тооцооны нормтой нийцүүлэн тодорхойлоно.

5.2 Олон нийтийн барилгын тодорхой бүлэг өрөө ба өрөө тасалгааг шинэчлэн өөрчлөх болон өөр зориулалтыг өөрчлөхдөө Барилгын тухай хуулийн 46.4-д заасантай нийцүүлэх ба ингэхдээ нийт талбайг 10 хүртэл хувиар, харин сууцны зориулалтын өрөөг өөр зориулалтад тохируулан төлөвлөхдөө зориулсан талбайн нормт хэмжээг 15 хүртэл хувиар тус тус бууруулж болно. Бууруулсан нормын хэмжээ нь тухайн өрөөнд явагдах үйл ажиллагааны чанарыг бууруулахааргүй байна.

5.3 Боловсролын байгууллага

5.3.1 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын (цаашид СӨББ гэнэ) хүчин чадал, эдэлбэр газрын хэмжээг БНБД 30-01-д заасны дагуу төлөвлөнө. Эдэлбэр газарт бүлгийн тоглоомын талбайг насны ялгавраар тус тусд нь төлөвлөнө.

5.3.2 Сургуулийн өмнөх олон насны бичил бүлгүүдийг бие биеэс нь салангад өөр өрөөнд байрлуулна.

Сургуулийн өмнөх олон насны бичил бүлгүүдийн өрөөг хоёр ба гуравдугаарт давхарт байршуулахаар төлөвлөхдөө тэдгээр хүүхдүүдийн хувцасаа тайлах өрөөг нэг дүгээр давхарт байхаар тусгана.

5.3.3 Уур амьсгалын I бүсэд (БНБД 23-01-09) баригдах СӨББ-ын барилгад хүүхэд зугаацуулахад зориулсан, нэг хүүхдэд 2м²-ээс багагүй талбай ноогдохоор тооцон дулаан веранд төлөвлөж болно. Веранд нь агаар оруулах боломжтой байхаас гадна яслийн ба цэцэрлэгийн насны хүүхдийн зориулалтаар тус тусдаа байна.

Бичил бүлэг нэг бүрт зориулсан хоёроос дутуугүй аврах гарцтай байх ба тэдгээр нь саланга байршилтай гарц байна.

5.3.4 Орон сууцны барилгад байрлах сургуулийн өмнөх насны хүүхдийн бүлгийн өрөөний 1 хүүхдэд 4м²-аас багагүй талбай ноогдохоор тооцож өлгүүр, амралтын өрөө, тоглоомын өрөө, ариун цэврийн өрөө, ажилчдын цайны газартай байхаар төлөвлөнө.

5.3.5 Хичээлийн цөм бичил бүлэгт суралцдаг хүүхдүүд таван цагаас урт хугацаагаар хичээллэх тохиолдолд өрөөний талбайн хэмжээг 5.1 дүгээр хүснэгтэд зааснаар тогтооно. Хүүхдүүдийн байх хугацаа таван цагаас бага бол унтлагын өрөө төлөвлөхгүй.

5.1 дүгээр хүснэгт: Цөм бичил бүлгийн өрөөний талбайг тогтооход ашиглаж болох хэмжээ

Бүлгийн өрөө тасалгаа	Бага бүлэг (3 хүртлэх нас)	Дунд /Ахлах бүлэг (3 наснаас сургуульд элсэх нас хүртэл)
Хувцас солих өрөө	18 м ² / бүлэгт	18 м ² / бүлэгт
Бүлгийн өрөө	2,5 м ² / нэг хүүхдэд	2,0 м ² / нэг хүүхдэд
Цайны хэсэг	3,0 м ² / бүлэгт	3,0 м ² / бүлэгт
Унтлагын өрөө	1,8 м ² / нэг хүүхдэд	2,0 м ² / нэг хүүхдэд
Ор хураах өрөө	4,0 м ² / бүлэгт	5,0 м ² / бүлэгт
Ариун цэврийн өрөө	12,0 м ² / бүлэгт	16,0 м ² / бүлэгт
<p>Тайлбар – 10 –аас цөөн хүүхэдтэй бүлгийн хувцас солих өрөөний хэмжээг нэг хүүхдэд 1,0 м²талбай ноогдохоор тооцох ба гэхдээ талбайн нийт хэмжээ 6 м² - аас бага байж болохгүй.</p> <ul style="list-style-type: none"> - Унтлагын өрөө төлөвлөхгүй тохиолдолд ор хураах өрөө төлөвлөнө. - Цайны буланд аяга таваг угаах угаалтуур, аяга тавагны шүүгээ төлөвлөнө. - Ариун цэврийн өрөөнд хүүхдийн зориулалттай суултуур, угаалтуур тус бүр 3-4-г тоноглоно. -- Суултуурыг хооронд нь тусгаарлахгүй. 		

Үйлчлэгчдэд зориулсан ариун цэврийн өрөө бүхий хувцас солих өрөө эдгээр өрөөнүүдийн бүтцэд орно.

5.3.6 Цэцэрлэгийн барилгын зураг төсөл зохиох даалгаварт усан бассейн байгуулахаар тусгана. Цэцэрлэгийн барилгын усан бассейны өргөн нь 3-4 метр, урт нь 6-7 метр усны гүн нь 0,6 метрээс 0,8 метр хүртэл байна. Тоног төхөөрөмж нь усанд сэлэлтийн бассейны төхөөрөмжийн шаардлагад нийцсэн байх ёстой ба усны чанар, чанарт тавих хяналт, түүний ашиглалтыг холбогдох норм, дүрмийн шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

Зохих шаардлагад тохирсон өрөө тасалгаа байгаа тохиолдолд сургуулийн өмнөх насны хүүхдийн бичил бүлэгт зориулсан өрөө тасалгааг боловсролын өөр чиглэлийн (сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас гадна) байгууллагад зохион байгуулахыг зөвшөөрнө.

5.3.7 Бага бүлгийн ангид зориулсан блок нь тусгаарлагдсан байх ёстой бөгөөд бусад насны бүлгийн хүүхдүүд дамжин өнгөрхөөргүйгээр төлөвлөгдсөн байвал зохино.

5.3.8 Шинээр барих сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын байгууллагуудын барилгын үндсэн өрөө тасалгааны талбайн хэмжээг 5.2 дугаар хүснэгтэд зааснаар тогтооно.

5.2 дугаар хүснэгт: Боловсролын байгууллагын үндсэн өрөө тасалгааны талбайн хэмжээ

Өрөөний зориулалт, онцлог	Нэг суралцагчид ноогдвол зохих талбайн доод хэмжээ / м ² /
Сургуулийн анги – кабинет:	
Фронталь байрлалтай хичээллэх	2.5
Холимог байрлалтайгаар хичээллэх	3.0
Бүлгийн зохион байгуулалтаар хичээллэх	3.5
Байгалийн шинжлэх ухааны тусгай кабинет болон лаборатори (Их, дээд сургуулиас бусад)	3.0
Лицей сургууль болон гимназийн 75 хүртэл суудалтай лекцийн танхим (аудитори)	1.0
Ерөнхий эрдмийн (ерөнхий боловсролын) хичээлийн лабораторууд	
Мэрэгжлийн дунд боловсролын байгууллагын	2.5
Их, дээд сургуулийн	4.0
Техникийн мэрэгшлийн болон нарийн мэрэгжлийн лаборатори, кабинет:	
Мэрэгжлийн боловсролын байгууллагын	2.4*
Их, дээд сургуулийн	6.0
Мэдээлэл зүй ба цахим техникийн кабинет, компьютерийн анги	4.5
сонсголын кабинет:	
Их, дээд сургуулийн байгууллагаас бусад боловсролын бүх байгууллагын	2.4
Их, дээд сургуулийн	3.0
Шугам зураг, курс, дипломын зураг төсөлд зориулсан:	
Мэрэгжил эзэмшүүлэх боловсролын байгууллагын	2.4
Их, дээд сургуулийн	3.6
лекцийн танхим, аудиторийн суудлын тоо нь:	
12 -оос 15 хүртэл бол	2.5
25...	2.2
30 бол	1.8
Мэрэгжил эзэмшүүлэх боловсролын байгууллагын :	
50 -аас 150 хүртэл	1.2
Их, дээд сургуулийн ба сургалтын комбинат :	
50-аас 75 хүртэл	1.5
76-аас 100 хүртэл	1.3
101-ээс 150 хүртэл	1.2
151-ээс 350 хүртэл	1.1
351 ба түүнээс дээш	1.0

*Хөдөлмөр сургалт, нийгмийн тустай хөдөлмөрийн цех (хөдөлмөрийн сургалт цехээс бусад)	7.5
<i>Мэргэжлийн боловсролын сургуулийн сургалт үйлдвэрлэлийн дадлагын байрны талбайг түүнд тавигдах технологийн тоног төхөөрөмж, явагдах сургалтын процессоос хамааруулан зургийн даалгаварт зааснаар тогтооно. +</i>	
<i>* Лаборторийн өрөөний нийт талбай хэмжээн дээр сургалтын мэргэжлийн онцлогтой холбогдуулан технологийн төхөөрөмж суурьлуулахад шаардлагатай нэмэлт талбайг зайлшгүй тусгана.</i>	
<i>Тайлбар: Энэхүү 5.2* дугаар хүснэгтэд тусгагдаагүй сургалтын өрөөний хэмжээг зураг төсөл боловсруулах даалгавараар тогтооно.</i>	

5.3.9 Боловсролын байгууллагын цахим техникийн өрөө таслгаа төлөвлөхдөө эрүүл ахуйн холбогдох норм, дүрэм, стандартыг удирдлага болгоно. Харин тухайн барилгад суурьлуулсан компьютерийн дотоод сүлжээ нь интернетийн олон нийтийн сүлжээнд холбогдох бололцоогоор хангагдсан байвал зохино.

5.3.10 Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт, БД 31-113-11-тэй нийцүүлэн боловсруулсан ЗТБД–р тодорхойлсон бүтэц, өрөөний талбай бүхий эмнэлэгийн блокийг сургуулийн барилгад төлөвлөнө.

5.3.11 Боловсролын байгууллагын рекреацийн талбайн хэмжээг тодорхойлохдоо нэг суралцагчид оногдвол зохих дараах талбайн (m^2) тооцоонд үндэслэнэ. Харин энэ хэмжээнээс бууруулж болохгүй. Нэг суралцагчид оногдвол зохих талбай (m^2) нь:

Бага ба дунд мэргэжлийн боловсролын байгууллагын сургуулийн хувьд $0.6m^2$;

Их, дээд сургууль, сургалтын комбинатын хувьд..... $0.5 m^2$ байна.

Сургуулийн заалны рекреацийн өрөө төлөвлөхдөө түүний талбайн хэмжээг нэг суралцагчид $2 m^2$ оногдохоор бодож тогтооно.

5.3.12 Үзвэрийн танхим, аудиторийн эзлэхүүнийг нэг үзэгчийн суудалд ноогдвол зохих дараах үзүүлэлтийг (m^3) ашиглан тодорхойлж болно. Харин энэ хэмжээнээс бага байж болохгүй. Энэ нь:

драмын театрын.....	4-5 m^3
кинотеатрын.....	4-6 m^3
клубынхөгжимт драмын театр ба хошин жүжгийн театрын.....	5-7 m^3
дуурь, бүжгийн театрын.....	6-8 m^3
аудиторийн.....	4-5 m^3

тус тус байх бол харин концертын танхимын хувьд энэ үзүүлэлтийг зураг төсөл зохиох даалгавраар зохицуулна.

Тайлбар: Тухайн заал, танхимын төлөвлөлтийн шийдлийг оновчтой болгосноор дээр заасан тоон хэмжээг 20% хүртэл өсгөх болон багасгах, мөн инженерийн оновчтой шийдэл нэвтрүүлэн энэ хэмжээг 20%-иас илүү хувиар өөрчлөхийг зөвшөөрнө.

5.3.13 Боловсролын байгууллагын биеийн тамир спортын ба нийтлэг танхимын байрлал мөн түүнчлэн клубын ажиллагаанд зориулсан өрөөний бүрдлийг ЗТБД-р тогтооно.

5.3.14 Боловсролын байгууллагын биеийн тамир, спортын заал, танхим, өрөөний талбайг тодорхойлохдоо (туслах зориулалттай өрөөний талбайг энд хамааруулахгүй) нэг хичээллэгчид шаардлагатай талбайн дараах хэмжээг (m^2) баримтлана. Энэ

хэмжээг бууруулж болохгүй. Нэг суралцагчид шаардлагатай талбайн доод хэмжээ нь (м²):

Ерөнхий боловсролын байгууллагад1.2 м²;

Мэрэгжлийн боловсролын байгууллагад..... 1.0 м²;

Мэрэгжил дээшлүүлэн дээд боловсрол олгох боловсролын байгууллагад- 0.2м² байна.

Биеийн тамир, спортын заал, түүний туслах өрөөнд байвал зохих тоног төхөөрөмжийг холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн тодорхойлоно.

Ерөнхий боловсролын байгууллагын биеийн тамир, спортын танхим ба биеийн тамир -спортын тоног төхөөрөмжид зориулсан өрөөний бүрэлдүүний жишгийг холбогдох норм ба дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн тодорхойлоно.

Усан сэлэлтийн бассейн ба бусад зориулалтын биен тамир, спортын өрөө зайлшгүй байх шаардлагыг ЗТБД тогтооно.

5.4 Дотуур байр

5.4.1 Сургуулийн дотуур байрны нэг сурагчид ноогдох унтлагын өрөөний талбайг 4 м² -аас, бие даалтын ажлын өрөөний талбайг 2.5 м² –аас багагүй байхаар тус тус төлөвлөнө зохино. Өдөр өнжүүлэх бүлэг бүхий сургуулийн нэг дүгээр ангийн сурагчдын тоглоом –унтлагын хосломол зориулалттай өрөөний нэг сурагчид ноогдох талбай 2.5 м²-аас багагүй байна.

5.4.2 Сургуулийн эмнэлгийн салбар, түүний бүтэц, шаардагдах өрөө, кабинет, талбайн хэмжээг зураг төсөл боловсруулах даалгавараар тодорхойлоно.

5.5 ЗАХИРГАА

5.5.1 Захиргааны үндсэн чиг үүргийн зориулалт бүхий дараах нэр бүхий бүлгийн өрөөг сургуулийн ба бусад байгууллагын барилгад төлөвлөнө. Үүнд:

- а) Удирдах ажилтны кабинет;
- б) үндсэн бүтцийн салбар нэгжийн ажлын өрөө;
- в) Хурал зөвлөгөөний танхим, уулзалтын өрөө;
- г) техникийн номын сан, төслийн кабинет, архив ба медиатекийн^{HT} өрөө зэрэг мэдээлэлийн цахим техникийн зориулалтын өрөө ;
- д) Үүдний танхим, аван-вестибюль^{HT} /түр хүлээх/, хувцасны өлгүүр, нэвтрэн өнгөрүүлэх товчоо, харуул хамгаалалтын өрөө гэх мэт гол орцын хэсгийн бүлэг өрөө
- е) үйлчилгээний ажилтны нийгэм ахуйн өрөө ;
- ж) байгууллагын техникийн үйлчилгээний ажилтны өрөө ;
- и) барилгын инженерийн хангамжийн ажилтны өрөө.

Байгууллагын удирдлагын ажлын өрөө ба зочин хүлээн авахад зориуласан өрөөний талбайг 5.3 дугаар хүснэгтэд зөвлөсний дагуу төлөвлөхийг зөвшөөрнө.

5.3 дугаар хүснэгт: Байгууллагын удирдлага, зочин хүлээн авах кабинетын талбайн хэмжээ

Өрөөний нэр	Тухай байгууллагын албан хаагчдын (хүний) тооноос хамааруулсан талбайн хэмжээ м ²			
	300 хүртэл	300-600	600-1000	1000-аас дээш

Байгууллагын даргын өрөө	27-36	36-45	45-54	54
Байгууллагын 1-р орлогч даргын өрөө	18-24	24-36	24-36	36-45
Байгууллагын орлогч даргын өрөө	12-18	18-24	18-24	18-36
Байгууллагын даргын туслахын өрөө (референт)	12	12	12	12-18
Байгууллагын даргын уулзалтын өрөө	12	18	24	36
Орлогч даргын уулзалтын өрөө	12	12	18	24
<i>Тайлбар: Байгууллагын дарга, орлогч даргын уулзалтын өрөөг тэдгээрийн ажлын өрөөтэй нэгтгэн төлөвлөхийг зөвшөөрнө.</i>				

5.5.2 Байгууллагын, 5.5.1-ийн а-г ба ж -д заасан өрөөний бүтцийг зураг төсөл боловсруулах даалгавараар тогтоох ба харин талбайн хэмжээ, өрөө хоорондын үүргийн уялдааг тухайн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, технологийн шаардлагатай уялдуулан боловсруулсан зураг төсөл зохиох даалгавраар тодорхойлоно. 5.5.1-ын б-д заасан салбар нэгжийн өрөөний талбайн хэмжээ тогтоох норматив байхгүй тохиолдолд түүнийг ажлын нэг байранд 6 м² оногдохоор тооцож гаргана.

Байгууллагын бүтцийн нэгжүүдийн дундын ашиглалтын ажлын өрөө (өрөө тасалгаа, кабинет, офис г. м.), түүний талбайн хэмээг ажлын нэг байранд доор дурьдсан хэмжээ оногдохоор тооцно. Үүнд:

Хэлтсийн дарга, ерөнхий мэрэгжилтэн, ерөнхий нягтлан бодогчид.....9 м²

Хэлтсийн даргын орлогч (нягтлан бодогчийн), ахлах зааварлагчид г.м..7.5 м²

Инженер, эдийн засагч, нягтлан бодогч,зааварлагчид 6.5 м²

Программ хангамжийн мэрэгжилтэн, техникийн үйлчлэгээ, засвар эрхэлсэн ажилтай зааварлагч,бичиг хэргийн ажилтанд..... .6 м² .

Зочинтой ганцаарчлан уулздаг (хуульч, нийгмийн үйлчилгээний албаны ажилтан, захиргааны ажилтан г.м.) албан ажилтаны өрөөний талбай 12 м² -аас багагүй байна.

5.5.3 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон нийт ажилтны тооноос хамааралтай, мөн ажлын орчин үеийн технологийг хангадаг серверийн, олшруулах техник болон бусад техник хэрэгсэлийн өрөөг захиргааны нэгжийн бүтцэд багтаан тооцно.

5.5.4 Уулзахаар ирсэн хүмүүст зориулсан хүлээлгийн өрөөний (энд эмнэлэгийн байгууллагын хүлээлгийн өрөө хамаарахгүй) талбайн хэмжээг тооцохдоо нэг зочинд /хүнд /оногдох талбайн нормативт хэмжээнд үндэслэн тэнд байх нийт хүний тоотой шүтэлцүүлэн дараах байдлаар тогтооно.Үүнд:

Хүний тоо 10 хүртэл бол 2м² ,

Хүний тоо 20 хүртэл бол 1.5м² , харин түүнээс олон болох үед дараачийн хүн тус бүрд 1 м² –аар өсгөн тооцно.

5.5.6 Засаг захиргаа, боловсролын байгууллагын барилгад төрөл бүрийн зориулалттай үйлдвэрлэл эрхлэх болон лабораторын өрөө төлөвлөхөд БНБД 41-01-11 ба холбогдох норм, дүрмийн шаардлагад нийцүүлнэ .

Хувилан олшруулах техникт зориулсан өрөө төлөвлөхөд БНБД 41-01-11 ба эрүүл ахуйн холбогдох норм, дүрэм, стандартыг удирдлага болгоно.

5.6 ЭМНЭЛГИЙН ГАЗАР

5.6.1. Эмнэлэгийн газрын хэвтэн эмчлүүлэх өрөөний багтаажийг орны тоогоор хэмжих ба тэр нь 4-өөс илүү ортой байж болохгүй.

Гэхдээ нярай хүүхдийн, хагалгааны дараах, сэхээн амьдруулах мөн яаралтай эмчилгээний өрөөний /палат/ багтаамж 12 –оос илүү ортой байж болохгүй.

5.6.2 Шинээр барьж байгаа эмнэлэгийн хэвтэн эмчлүүлэх өрөөний талбайг тооцохдоо БД 31-115-12 ба MNS 6392:2013-ыг ашиглана.

5.6.3 Дотор нь ионжуулагч цацрагын үүсгүүр хадгалагддаг туяа эмчилгээний тасгийн өрөө ба кабинет, рентгений тасгийн процедурын кабинет, I ба II ангилалын радиоизотоп оношилогооны лаборторийн ажиллагаа явагддаг өрөөг бие давхар эмэгтэйчүүд болон хүүхэд эмчилдэг тасгийн өрөөний аль ч талд шууд бөөрлүүлэн (хажуу ба дээр, дор талд) байрлуулахыг хориглоно.

5.7 ҮЗВЭРИЙН ба ХУРЛЫН ТАНХИМ

5.7.1 Үзвэрийн танхимын талбайг тодорхойлохдоо нэг суудалд оногдвол зохих талбайн (m^2 /нэг суудал) тооцооны үзүүлэлтийг үндэс болгоно. Энэ үзүүлэлт танхимын онцлогтой хамааралтай бөгөөд хамгийн багадаа дараах хэмжээнээс багагүй байна .Үүнд:

Байнгын ажиллагаатай кино театрт.....	1.0 m^2 ;
Улирлын ажиллагаатай кино театрт.....	0.9 m^2 ;
клубэд	0.65 m^2 ;
театрын, концертийн ба олон зориулалттай танхимд.....	0.7 m^2 ;
бичил театрт	0.9 m^2 .

Тагт, лож, ярус бүхий үзвэрийн танхимын талбайг хашлага хийцийн хүрээнд багтаан тодорхойлох ба ингэхдээ:

Кинотеатрт– эстрадыг оруулж тооцно;

Клуб, театр, концертын болон олон зориулалттай танхимын хувьд тайз, бага тайз, эстрадын нүүрэн талын хөвөө хүртэл буюу хөгжмийн байрны /нүх/ хашлага хүртэлх талбайгаар тооцно.

Тайзны планшет- шалны (авансцен, эстрад) түвшингийн өндөр нь шатлаагүй тэгшхэн шалтай танхимын хувьд бол үзэгчдийн суудлын эхний эгнээний шалны түвшингээс 1.1 м-ээс хэтрэхээргүй байна.

5.7.2 Хурал- зөвлөгөөний танхимын талбайг 5.4 дэх хүснэгтэд заасан, нэг суудалд оногдвол зохих талбайн тооцооны үзүүлэлтээс бууруулахгүйгээр тооцон гаргана.

5.4-р хүснэгт: Хурал-зөвлөгөөний танхимын нэг суудалд ноогдох талбайн тооцооны доод хэмжээ

150 хүртлэх суудалтай танхимын хувьд:	сандал нь пюпитр ^{HT} тэй бол	1.25 m^2
---------------------------------------	--	------------

	сандаг нь пюпитргүй бол	1.1 м ²
150 ба түүнээс олон суудалтай танхимын хувьд:	сандаг нь пюпитртэй бол	1.1 м ²
	сандаг нь пюпитргүй бол	1.0 м ²

5.7.3 Нийтлэг ашиглалттай заалны талбайг (эстрад орохгүй) тодорхойлохдоо нэг суудалд оногдвол зохих талбайн тооцооны дараах үзүүлэлтээс бууруулахгүйгээр тооцон тодорхойлоно. Энэ нь :

Бага дунд ба бүрэн дунд мэрэгжлийн боловсролын байгууллагын сургуулийн нийтлэг заалын талбайн хувьд..... 0.65м²;

Их, дээд сургуулийн нийтлэг заалын талбайн хувьд 0.8 м² -ээс багагүй байна.

5.8 ҮЗВЭРИЙН ТАНХИМ

5.8.1 Фойен талбайг (эстрад орохгүй) тодорхойлохдоо нэг суудалд оногдвол зохих талбайн тооцооны дараах үзүүлэлтийг бууруулахгүйгээр тооцон гаргана.

Энэ нь:

Боловсролын байгууллагын нийтлэг заал мөн спортын үзүүлэх тоглолтын заал, ОНБ доторхи кино танхим, фойен талбайд..... 0.4 м²;

Театр, клуб, концертын танхим, дээд сургуулийн нийтлэг заалын фойен талбайд..... 0.6м²;

кинотеатрын фойен талбайд.....0.55м²;

Олон зориулалт бүхий танхим ба урлаг-спортын заалны фойен талбайд. 0.7м²;

Хүүхдийн кинотеатрын фойен талбайд..... 0.8 м² байна.

5.8.2 Кино гаргах төхөөрөмж бүхий соёл- үзвэрийн газрын үзмэрийн танхим ба кино дэлгэцийн параметруудийг Е хавсралтаас үзнэ.

5.9. АРХИВ, НОМЫН САН, УНШЛАГЫН ТАНХИМ

5.9.1 Нийтийн номын сангийн уншлагын танхимын талбайн нийт хэмжээг нэг уншигчийн суудалд 2.4 м²–аас багагүй талбай оногдохоор тооцно. Энэ тохиолдолд уншлагын танхимын ширээ нэг буюу 2 сандалтай байна.

5.9.2 Архивын хадгаламжийн сангийн талбайн норм 1000 нэгжид 6 м², номын сангийн фондын талбайг байран шүүгээнд далд хадгалах бол 1000 нэгжид 2.5 м²- аас, хөдөлгөөнтэй шүүгээнд хадгалах бол 1000 нэгжид 1.5 м²- аас багагүй талбай байхаар тус тус тооцно.

Үйлчлүүлэгч чөлөөтэй ашиглаж болох задгай фондын бүсийн талбайг 1000 нэгж тутамд 4.5 м²–аас багагүй талбай байхаар жишиж тооцно.

5.10 БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД

5.10.1 Сургалтын байгууллагын номын сангийн нийт талбайг нэг суралцагчид (оюутан) ноогдвол зохих тооцооны талбайг дараах үзүүлэлтээс багагүй байхаар тооцон ялгавартай тогтооно. Энэ хэмжээг бууруулахгүй. Энэ нь (м²) :

Сургуульд 0.6 (м²);

Мэрэгжлийн боловсрол олгох боловсролын байгууллагад. 0.8(м²);

Харин их, дээд сургуульд:

Техникникийн ухааны чиглэлээр бол.....1.1(м²);

Нийгэмийн ба анагаах ухааны чиглэлээр бол.....1.3(м²);

соёл, урлагийн ухааны чиглэлээр бол.....2.3(м²)

тус тус байна.

5.11 ХООЛЛОХ ТАНХИМ

5.11.1 Хооллох / үдийн / танхимын талбайг нэг суудалд ноогдох тооцооны талбайн (зөөгчгүй) хэмжээг (м²) дараах үзүүлэлтээс бууруулахгүйгээр ялгавартай тооцон тодорхойлно . Тухайлбал :

Сургуульд:

суудлын тоо нь 80 хүртэл бол.....0.75(м²);

суудалын тоо нь 80 ба түүнээс дээш бол..... 0.7(м²);

анхан шатны мэрэгжлийн боловсрол олгох боловсролын байгууллагад0.8(м²);

дунд шатны мэрэгжлийн боловсрол олгох боловсролын байгууллагад.1.3(м²);

Их, дээд сургуульд 1.8(м²);

Бусад нэгж байгууллагад :

Хиймэл эрхтэнтэй ба мөн өвчтэй /неврологи / хүмүүст сэргээн засах эмчилгээ үзүүлдэг эмнэлэг, хөгжлийн бэхршээлтэй, тэргэнцэртэй хүмүүсийн халамжийн байгууллагад..... 2.5(м²);

Хэвтэж эмчлүүлэхэмнэлэг ба нийгмийн халамжийн байгууллагад.....1.2(м²);

ресторанд..... 1.8(м²);

эстрад болон бүжгийн талбайтай ресторанд..... 2.0(м²);

нийтийн гуанзанд.....1.8(м²);

пивны бар , кафе, хөнгөн зуушны газарт..... 1.6(м²);

автоматкафе, түргэн үйлчилгээний газар, архи борлуулдаггүй бар, аялал,жуулчланы бааз /хижин^{HT} ба приют^{HT} / зэрэгт..... 1.4(м²);

Хүүхэд чийрэгжүүлэх (зуны) ба ахлах ангийн хүүхэд сувилах зусланд 1.0(м²);

Хүүхэдийн сувилалын зусланд1.4(м²);

Өөрөө өөртөө (зөөх шугамыг оруулсан) үйлчилдэг сувилал, сувилал-диспансер, амралтын (өндөр настны) байр, амралтын бааз, залуучуудын зуслан, жуулчны баазад1.8(м²);

харин энд зөөгч үйлчлүүлэхээр төлөвлөвөл энэ үзүүлэлт1.4(м²) гэж тус тус тооцно.

5.11.2а Хооллох танхимд тэргэнцэртэй багш , хөдөлгөөний бэрхшээлтэй сурагчид хоол идэхэд зориулсан суудал гаргах бол хоолны танхимын талбайн хэмжээг нэг суудалд 1.6 м² -аас багагүй талбай ноогдохоор тогтооно.

5.11.2б Нийтийн хоолны тусгай, төрөлжсөн байгууллагын хооллох танхимын талбайг зураг төсөл боловсруулах даалгаварын дагуу тогтооно.

5:12 СУВИЛЛЫН ГАЗАР, ДОТУУР БАЙРНЫ ХҮН СУУХ ӨРӨӨ

5.12.1 Шинээр барих сувилал, сувилал-диспансер болон амралтын газарт амрагч, сувилуулагч байрлах өрөөний талбайн хэмжээг 5.5 дугаар хүснэгтэд заасан

нэг хүнд ноогдох талбайн доод хэмжээгээр тооцож төлөвлөнө. Харин хүүхдийн зусланд нэг хүнд ноогдох сууцны талбайн хэмжээг Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа Ерөнхий шаардлага MNS 5633:2013 стандартад заасны дагуу тодорхойлоно.

5.5 дугаар хүснэгт

Байгууллага	Нэг хүнд ноогдох сууцны талбайн доод хэмжээ, м ² ,
Сувилал, рашаан -сувилалр ба мөн насанд хүрэгсдийн (хүүхэдтэй гэр бүлийн)амралт эрхэлсэн байгууллагад	9.0
Хүүхэд чийрэгжүүлэх сувилалд	7.0
Докторант болон оюутны байранд	7.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настны асрамжийн газарт	8.0

Сууцны өрөөний талбайн хэмжээ 12 м² –аас багагүй байна.

Харин нийтийн байранд хүн ганцаараа амьдрахад зориулсан өрөө төлөвлөхөд өрөөний талбайн хэмжээ 9 м²-аас багагүй байна.

5.12.2 Зочид буудал,эд зүйлс хадгалах бусад өрөө, тэдгээр өрөөний бүрдэл, талбай, тоноглол, төхөөрөмжийг төлөвлөхдөө тэдгээр өрөөний ангилалын зэргээс нь хамааруулан Зочид буудал.СП 257.1325800. норм ба дүрэм болон холбогдох норм дүрмийг баримтлана.

5.12.3 Мэргэжлийн боловсролын байгууллагын оюутаны байрны сууцны нэг өрөөг төлөвлөхдөө Оюутны дотуур байрны үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5869-2008 стандартыг баримтлана.

Дээд боловсролын байгууллагын оюутан , докторантын сууцны нэг өрөөг хоёроос илүүгүй хүн амьдрахаар төлөвлөнө.

5.13. Үүдний танхим, хувцас өлгүүр

5.13.1 Олон нийтийн барилгын үүдний танхимын талбайн хэмжээг тогтоохдоо зочилохоор тооцоолсон зочин бүрт 0.2- 0.23 м², тэдгээрийн хувцас өлгүүрийн өрөөний талбайг мөн нэг зочинд 0.15 м² гэж тооцон нийт хэмжээг тогтооно. Харин нийт талбайн хэмжээ 18 м² -аас багагүй байна.

Хувцас өлгүүрийн талбайн хэмжээг тогтоохдоо эмнэлгийн байгууллагад БНБД 31-22-21, боловсролын байгууллагад БНБД 31-25-22-ын заалтыг баримтлана. Уг байгууллагын үүдний танхимд мэдээлэл лавлагаа бүхий шалган нэвтрүүлэх системийн алба байх бол түүнд шаардагдах талбайн хэмжээг тусад нь авч үзнэ.

Хувцасны өлгүүр нь хашлага хаалтаасаа цааш 6 м-ээс илүү гүнд байж болохгүй. Хувцасны өлгүүр, хашлага хаалт хоёрын дунд хүн явахад зориулан 1 м-ээс дутуугүй өргөнтэй чөлөөтэй зай үлдэхээр төлөвлөнө.

5.14. Ариун цэврийн өрөө

5.14.1а Олон нийтийн барилгад нэг зэрэг цугларах хүний 50-аас цөөн, эсвэл үйлчилгээний технологийн параметрын дагуу эдгээр хүмүүс 60 минутаас удаан хугацаагаар байхгүй гэж үзсэн тохиолдолд тэдгээрт зориулсан бие засах газар төлөвлөх шаардлагыг ЗТБД-аар тодорхойлоно.

Харин олон хүнд зэрэг үйлчилдэг засаг захиргааны, эрүүлийг хамгаалахын ба нийгмийн үйлчилгээний зэрэг байгууллагуудад эдгээр хүмүүст зориулсан бие засах газар заавал төлөвлөнө.

Бие засах - ариун цэврийн өрөөг эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн зориулалтаар тус тусад нь салангад төлөвлөнө.

Тэгэхдээ зураг төсөл боловсруулах даалгаварт өөрөөр заагүй бөгөөд эрэгтэй ба эмэгтэй хүмүүст зориулсан ариун цэврийн төхөөрөмжийн тооны харьцаа 1:1 байгаа тохиолдолд технологийн онцлог, зураг төсөл боловсруулах даалгаварыг үндэслэн, зочид (үзэгчид гм) ба үйлчилгээний ажилтанд (ажилчид гм) зориулсан бие засах - ариун цэврийн өрөөг бие даасан байдлаар эсвэл нэг дор нь төвлөрүүлж болно.

Үндсэн ажилтны тоо нь 10-аас олонгүй мөн нэг зэрэг үйлчлүүлэх хүмүүсийн тоо 10-аас хэтрэхгүй байх тохиолдолд ариун цэврийн нэг өрөөг төлөвлөхийг зөвшөөрнө.

5.14.16 Шинээр баригдах боловсролын ба эмнэлэгийн байгууллагын ажилтануудад зориулсан ариун цэврийн өрөөг угаалтуур бүхий гонхоор дамжиж орохоор төлөвлөнө.

Тухайн төрлийн ОНББ-д байвал зохих ариун цэвэр –ахуйн зориулалттай өрөө тасалгааны бүрэлдэхүүн ба талбайн хэмжээг холбогдох норматив баримт бичигт заасантай нийцүүлэн боловсруулсан ЗТБД-ын дагуу тогтооно.

5.14.2 Сантехникийн нэг төхөөрөмжид ноогдох тооцны ачаалал ОНБ-ын хэв шинжийн төрлөөс хамаарч дараах байдалтай байна. Үүнд:

Эрэгтэйчүүдэд:

20-30 албан хаагч буюу сурагч эсвэл 50-60 зочны дунд нэг суултуур,

15-18 албан хаагч буюу 30 сурагч, эсвэл 50 - 80 зочны дунд нэг хөтөвч,

дөрвөн суултуур тутамт нэг угаалтуур оногдохоор тооцох ба ариун цэврийн өрөө бүрт угаалтуур заавал байна.

Ерөнхий боловсролын байгууллагад эрэгтэй хүний гурван суултуур тутамд нэг угаагуур харин эмэгтэй хүний хоёр суултуур тутамт нэг угаагуур оногдохоор тооцох ба ариун цэврийн өрөө бүрт угаагуур заавал байна.

Эмэгтэйчүүдэд:

15 албан хаагч буюу 20 сурагч эсвэл 25-30 зочны дунд нэг суултуур,

хоёр суултуур тутамт нэг угаалтуур оногдохоор тооцох ба ариун цэврийн өрөө бүрт угаалтуур заавал байна.

Бие засах өрөө ба ариун цэврийн газарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай бүхээгний эзлэх хувь, тэдгээрийн овор хэмжээг БД 31-112-11-ийн дагуу тогтооно.

Тайлбар:

1 Тухайн байгууллагын онцлогтой уялдуулан дээрхи төхөөрөмжийн тоо хэмжээг нарийн тогтооно.

2 ОНБ-д биеийн хүчний хөдөлмөр эрхлэх өрөө төлөвлөх тохиолдолд түүний ариун цэврийн зэрэглэлийг анхаарах ба сантехникийн төхөөрөмж, тэдгээрийн овор хэмжээг БНБД 31-04-03-ыг ашиглан тооцно.

3 СӨББ, эмчилгээний газар, нийгмийн үйлчилгээний байгууллагууд дахь биен тамир, спортын байгууламжид байвал зохих нэмэлт сантехникийн төхөөрөмжийн багц, тэдгээрийн хүчин чадлыг технологийн даалгавар тогтооно.

5.14.3а Худалдан авагчдад зориулан тоногдсон ариун цэврийн өрөөг дэлгүүрүүдэд төлөвлөхдөө дараах тооцоог үндэс болгоно. Үүнд:

Хүнсний барааны дэлгүүрт 400 м² худалдааны талбай тутамд, аж үйлдвэрийн барааны дэлгүүрт 600 м² худалдааны талбай тутамд нэг суултуур оногдохоор тооцох ба харин ариун цэврийн өрөөн дэх бүхээгийн тоо хоёроос цөөнгүй байна.

Харин 300 м² –аас бага худалдааны танхимтай дэлгүүрт зөвхөн худалдан авагчид зориулсан ариун цэврийн өрөөг тусад нь төлөвлөх шаардлагагүй.

Худалдаа – цэнгээний цогцолбор ба олон зориулалттай төвүүд, үзвэрийн газар, музей, үзэсгэлэнгийн танхим, худалдаа, нийтийн хоолны газрууд, эмнэлгийн байгууллага, захиргааны барилга, төмөр замын буудал ба автовокзал, нисэх онгоцны буудал төлөвлөхдөө 1000 худалдан авагч (үйлчлүүлэгч) тутамд хүүхэд хуурайлах ширээ, суултуур, угаагуураар тоногдсон эх үрсэд зориулсан тусгай өрөө төлөвлөнө. Мөн хүүхдийн тоглоомын төв, хүүхэд саатуулах хэсгийг хоёроос дээшгүй давхарт, аврах гарцаас 20 м-ээс холгүй зайд байршуулна.

5.14.36 Дараах төрлийн олон нийтийн барилгад (мөн өрөөнд) 5.42-тэй уялдуулсан хүүхдийн “тоглоомын төв, хүүхэд саатуулах төв” байршуулахдаа ЗТБД-тай нийцүүлнэ. Тухайлбал: худалдаа – цэнгээний цогцолбор, олон чиг үүрэгт төв, музей, үзэсгэлэнгийн газар, олон нийтийн үзвэрийн объект, эмнэлэгийн, засаг захиргааны, худалдаа-нийтийн хоолны газрууд, нисэх онгоцны, төмөр замын, усан замын ба авто замын буудлуудад

5.14.4 Олон нийтэд үйлчлэх үйлчилгээний газар, клубын цогцолборын албан хаагчид, жүжигчид, үйлчлэгч ба ажилтнуудад зориулсан эмэгтэй хүний ариун цэврийн өрөө, мөн түүнчлэн захиргааны барилга, мэрэгжлийн боловсролын байгууллагын нийтийн байр, сургуулийн дотуур байр, зорчигч тээврийн буудлуудын бүсгүй хүний ариун цэврийн өрөөнд ЗТБД-т заасны дагуу уян хоолой бүхий эрүүл ахуйн шүршүүр, биде буюу эрүүл ахуйн бусад төхөөрөмжийг нэмж тусгаж болно.

5.14.5. Спортын задгай байгууламжаас бусад олон нийтийн барилга, байгууламж дахь бие засах газрыг (олон хүн байнга байдаг хамгийн алслагдсан цэгээс 75 м-ээс үл хэтэрэхээргүй зайд байрлуулна.

Хурдан морьны барианы газар, үндэсний бөхийн задгай стадион, сурын байр, тэшүүр, цанын бааз зэрэг уралдаан тэмцээн, сургалт зохион байгуулдаг хавтгай байгууламжийг (дээвэргүй) түшиглэсэн бие засах газар нь үзэгчдийн суудлаас 150 м-ээс холгүй зайд байна.

Ариутгах татуургын шугам сүлжээгүй газарт байгуулах улирлын чанартай ашиглах олон нийтийн барилга, задгай байгууламж ба түр барилгад био –жорлон байрлуулах тусгай талбай төлөвлөнө.

5.14.6 Эмнэлэг, нийгмийн халамжийн байгууллагын хэвтэн эмчлүүлэх өрөөнд тэргэнцэртэй өвчтөнд зориулсан 4 м² -аас багагүй талбайтай, тусгай тоноглолтой ариун цэврийн тусгай өрөө төлөвлөнө.

Тус ариун цэврийн өрөөний хаалгыг үүдний дамжих тусгай гонх руу / шлюз^{HT}/ нээгддэг байхаар төлөвлөнө.

5.14.7 Олон нийтийн барилгын бие засах газартай зэрэгцүүлэн цэвэрлэгээний багаж, эд зүйлс цэвэрлэх, хатаахад зориулан халуун, хүйтэн усны тоноглол бүхий ариун цэврийн өрөө төлөвлөнө.

Уг өрөөний талбайн хэмжээг тухайн давхрын 100 м² ашигтай талбай тутамд 0.8 м² талбай оногдохоор тооцох ба өрөөний хэмжээ нь 2 м²-аас багагүй байна. Давхарын талбайн хэмжээ 400 м² -аас бага байх тохиолдолд хоёр давхрын дунд дээрх зориулалтын нэг өрөө байхаар төлөвлөж болно.

Харин нийт талбай нь 3000 м²–аас их байвал 100 м² ашигтай талбай тутамд 0.6 м², мөн нийт талбай нь 5000 м²–аас их байвал 100 м² ашигтай талбай тутамд 0.4 м² талбай оногдогдохоор өрөөний хэмжээг тогтооно.

Эрүүлийг хамгаалахын байгууллагын цэвэрлэгээний бараа, багаж хэрэгсэл угаах, хадгалах өрөөг эмнэлэгийн барилгын зураг төсөл боловсруулах норм дүрмийн дагуу тогтооно.

5.14.8 Албаны болон туслах өрөөг төмөр зам, нисэх онгоцны буудлын барилга зэрэг газруудад төлөвлөнө. Тэдгээрийн бүрэлдүүн ба өрөөний талбайн хэмжээг ЗТБД-аар тогтооно.

5.48. Тусгай өрөө тасалгаа

5.48.1 ОНБ–д амьтны хүрээлэн байршуулахаар төлөвлөхгүй.

6 БАРИЛГЫН НАЙДВАРШИЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТАВИХ ШААРДЛАГА

6.1 Барилга нь хүмүүс орох, түүнээс гарах, дотуур, гадуур нь явах, түүнчлэн түүний хөдөлгөөнт эд зүйлс (элементүүд) ба инженерийн тоног төхөөрөмжийг ашиглах үед учирч болзошгүй аюулаас урьдчлан сэргийлэхээр БНБД 20-01-11 ба холбогдох нормитивын шаардлагын дагуу төлөвлөн барьж ,тоноглогдсон байна.

Барилгын найдвартай ажиллагааны үндсэн шалгуур нь эдэлгээний тогтоосон хугацааны туршид тооцоот ачааллын хамгийн зохимжгүй хослолын үйлчлэлд хязгаарын төлвөөс хэтрэхгүй байх нөхцөл юм.

6.2 Барилгын даацын бүтээц нь угсралтын процесс ба ашиглалтын тооцоолсон нөхцөлд дараах болзошгүй тохиолдууд гарахааргүй байхаар төлөвлөгдсөн байвал зохино. Үүнд:

- барилгын ашиглалтыг зайлшгүй зогсооход хүргэх хязгаарын төлвийн I бүлэгт орсоноос бүтээц эвдрэх,
- Хязгаарын төлвийн II бүлэгторсоноос цууралт үүссэн буюу эсвэл хэв гажилт үүссэний улмаас ашиглалт даах үндсэн бүтээц буюу барилгын чанар нь үл зөвшөөрөгдөх хэмжжэнд хүртэл муудах,
- Барилгын тооцооны параметрыг гажуудуулах хүртэл бүтээцэд эвдрэл үүсэх ,.

6.3 ОНБ төлөвлөхдөө эрчим хэмнэх, үр ашгийг нь сайжруулах шаардлагыг баримтлана.

Зураг төслөвлийн шийдлийн бүтээцлэлийн ба ашиглалтын шаардлагыг үзнэ.

6.4 Төлөвлөж байгаа барилга, байгууламжийн техникийн аюулгүй байдлын зохицуулалтыг холбогдох хууль тогтоож болон БНБД 20-01-11-ын дагуу тодорхойлно.

Төлөвлөж байгаа барилга, байгууламжийн техникийн аюулгүй байдлын зохицуулалтын илүү дээшлүүлэх шаардлагатай бол зураг төсөл боловсруулах даалгавраар тодорхойлсон ослын нөхцлийн тооцоо хийвэл зохино. Ослын нөхцөлд тавих тусгай шаардлагыг зураг төсөл боловсруулах даалгавараар тодорхойлно.

Барилгын инженерийн систем нь холбогдох норматив баримтат агуулагдсан аюулгүй ажиллагааны шаардлага болон түүнчлэн тухайн төхөөрөмжийг

үйлдвэрлэсэн газрын зааврыг тусган зураг төслийг боловсруулж түүний дагуу угсрагдсан байвал зохино.

6.5 Коммуникацийн / орц, гарц, хонгил, шат, (эвакуаци) / аюулгүй байдал

Үүдний довжоо, шат

6.5.1 Барилгын үүдний довжоо БД 31-112-11-ийн шаардлагыг хангасан байна.

Довжооны талбай зохих хашлагатай байна. Довжооны тавцангийн түвшин явган замын түвшинээс гурав ба түүнээс олон гишгүүрээр буюу 0.45 м-ээс дээш байх тохиолдолд түүний хашлагын өндөр нь 0.8 м-ээс багагүй байна. Хашлагад өөр төрлийн төхөөрөмж /хана, хаалт/ ашиглахыг зөвшөөрнө.

Барилгын үүдний довжоо гадагш онгойдог хаалганы самбарын өргөнийг 1.5 дахин өсгөнөөс багагүй хэмжээтэй байна.

6.6 Шал, шат, налуу зам,эвакуаци

6.6.1 Барилга, байгууламжийн шалны түвшин өөр өөр байвал өгсөх зориулалттай шат, налуу хавтгай зам / пандусь^{HT}/ буюу бусад төхөөрөмж төлөвлөнө. Өндрийн зөрүү харьцангуй бага байх тохиолдолд хальтрахааргүй өнгөлгөөтэй, 1:8 налуутай налуу хавтгай зам төлөвлөнө,

Барилга дотор хүмүүс давхраас давхар руу өгсөж, уруудах шат төлөвлөнө.

Барилгын газар дээрхи давхар дахь үйлчлүүлэгчид зориулсан шатны маршны налуу дүрэм ёсоор 1:2 байна. Лифттэй барилгад, хүн байнга явахад зориулаагүй, нэмэгдэл хоёр дахь шат төлөвлөсөн бол түүний маршны налууг 1:1-ээс илүүгүй байхаар төлөвлөхийг зөвшөөрнө.

Хаяавчийн, газар доорхи, мөн дээврийн давхар руу ороход зориулсан, үйлчлүүлэгчид зочдод зориулаагүй, шатны маршны налууг 1:1.5 байхаар төлөвлөхийг зөвшөөрнө.

Байшин дотуур зорчих хүмүүсийн замд гурваас цөөн гишгүүртэй шат (нэг гишгүүрийн өндөр 0.12 м-ээс багагүй байна) төлөвлөхийг хориглоно.

6.6.2 Хүмүүс явахад зориулсан налуу замын налуулга дараах хэмжээнээс ихгүй байна. Үүнд:

Барилга дотор бол..... 1:10-аас 1:12 хүртэл;

Эмнэлгийн ба нийгмийн халамжийн байгууллагын гадна талд бол. 1:12 байна.

Налуу замын параметрыг БД 31-112-11 -ийн дагуу тогтооно.

Налуу зам нь хүн хальтрахааргүй өнгөлгөөтэй байна.

6.6.3 Спортын битүү ба задгай байгууламжийн үзэгчдийн суудлын шатны налуу 1:1.6 байвал шатны хашлагын өндөр 0.9 м-ээс, харин шатны налуу 1:1.4 байвал шатны хашлагын өндөр 1.1 м-ээс багагүй байна.

Суудлын өгслийн налуу нь 1:1.4-ээс хэтрэхгүй байна.

Аврах замын зориулалтаар гаргасан нээлхийд /люк^{HT}/ шат болон шатны гишгүүр төлөвлөхийг хориглоно.

6.6.4 Барилгын шатны маршийн өргөн (м) нь хамгийн олон хүнтэй давхар дахь шатны хонгилын хаалганы өргөнөөс бага байж болохгүй бөгөөд үүнийг барилгын төрөл, зориулалттай уялдуулан ялгавартай төлөвлөх ба дараах хэмжээнээс багагүй байна.

Үүнд:

- дараалсан хоёр давхарт 200-аас олон хүн ирдэг барилгад болон мөн үзвэрийн ба эмнэлэгийн байгууллагын шатны маршийн өргөн нь 1.35 м-ээс;

- дээр зааснаас бусад барилга мөн үзвэр үзэгчид ба эмнэлэгийн өвчтөнд зориулаагүй барилга болон цэцэрлэгийн барилгын шатны маршийн өргөн нь 1.2 м-ээс;

- харин өрөөнд зэрэг цуглах хүний тоо тав хүртэл бол тухайн барилгын шатны маршийн өргөн нь 0.9 м-ээс багагүй байна.

Дараалсан давхарууддаа 200-аас цөөнгүй оюутан хичээллэхэд зориулсан лекцийн ба сургалт-лабораторийн анги танхим бүхий Их, дээд сургуулийн барилгын шатны маршийн өргөн 1.5 м-ээс багагүй байна.

Шатны маршийн эргэлтийн тавцангийн өргөн маршийнхаа өргөнөөс багагүй байна. Нэг марштай шатны түр амрах талбайн уртын хэмжээ 1.0 м-ээс багагүй байна.

Шатны маршийн талбайн хэмжээг 6.30 –д заасны дагуу тооцож тогтооно.

Шатны хонгилд, түүний ханын аль ч хэсэгт байрлуулсан халаалтын хэрэгсэлд хүрч үйлчлэх нормативт орон зай төлөвлөнө.

6.6.5 Шатны нэг марш дээрхи гишгүүрийн тоо 3-с цөөнгүй, 16 –с олонгүй байна. Энэ нь дугуй шатанд хамаарахгүй. Харин нэг марштай шатны зөвхөн нэгдүгээр давхрын гишгүүрийн тоо 18-аас хэтрэхээргүй байхыг зөвшөөрнө.

6.6.6 шатны гишгүүрийн өргөн 0.3 м (0.28-0.35 м-ийн хооронд байж болно), гишгүүр хоорондын өндөрийн хэмжээ 0.15 м (0.13 – 0.17 м-ийн хооронд байж болно) байна.

Шатны гишгүүр нь тэгшхэн бөгөөд, барзгардуу гадаргуутай, хурц ирмэггүй байна.

Гишгүүрийн ирмэг нь 0.05 м-ээс илүүгүй радиус бүхий мөлүү байна.

Нэг маршийн дагуух гишгүүрийн өндөр, өргөний хэмжээ олон янз байхыг зөвшөөрөхгүй.

Харин гол шатны хамгийн доод талын эхний 3 гишгүүрийн хэлбэр өөр байж болно.

Тайлбар: Үзвэрийн танхимын суудлуудын эгнээ хоорондын зай болон шаталгааны гишгүүрүүд нь үзэгчид явахад эрсдэлгүй байх боломжийг зураг төслийн шийдэлд тусгасан тохиолдолд хэмжээ нь хоорондоо өөр өөр байхыг зөвшөөрнө.

6.6.7 Уур амьсгалын бүсийг үл харгалзан, гал тэсвэрлэлтийн ямар ч зэрэглэлтэй барилгад эвакуацийн нэмэгдэл гарц болгон тухайн барилгын гадна талд 2:1-аас илүүгүй налуутай, ил, задгай шат (3-р төрлийн шат) төлөвлөхийг зөвшөөрнө.

Цэцэрлэгийн барилгын (хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, мөн дотуур байрт сургуулийн ба эмчилгээний байгууллагын стационарын барилгаас бусад) хоёр дугаар давхрын эвакуацийн зориулалттай 3 дахь хэв шинжийн шатны налууг 1:1-ээс илүүгүй байхаар төлөвлөнө.

Гуравдугаар төрлийн шат нь хоёр талдаа бариултай, талбай болон гишгүүрийн өнгөлгөө нь барзгар гадаргуутай байна. Шатны талбай, гишгүүрийн гадаргууг ус зайлуулахад төвөггүй байхаар төлөвлөнө.

Гуравдугаар төрлийн шатыг галд тэсвэртэй материалаар гүйцэтгэх ба гал тэсвэршилтийн хязгаар нь REI (EI) 30 –ээс доошгүй, галын аюулын анги нь Г1-ээс багагүй үзүүлэлтэй байх ба ханын битүү (гэрлийн цонхгүй) хэсэгт байршуулна. Ийм шат нь эвакуацийн гарцын түвшинд тохирсон талбайтай. 1.2 м-ээс намгүй хашлагатай байх ба түүнийг цонхны гадаргуугаас 1 м-ээс багагүй зайтай байрлуулна.

6.6.8 Гуравдугаар төрлийн шатыг аврах гарцын галын аюулгүйн шаардлагад тохируулан тоноглохыг зөвшөөрнө.

6.6.9 Хэрэв аврах хүмүүсийн тоо, тухайн давхрын байршлын өндөр зэрэг нь эвакуацийн замын гал эсэргүүцэх шаардлагад тохирч байгаа бол боловсролын байгууллагын болон Б бүлэгт багтах (А хавсралт) олон нийтийн барилгын аль ч давхрын эвакуацийн хоёр дахь /нэмэгдэл/ гарцад гуравдугаар төрлийн шат ашиглахыг зөвшөөрнө.

6.6.10 Нэг өрөөний эсвэл тусгаарласан ханагүй зэрэгцээ хоёр өрөөний шалны төвшний зөрүү нь огцом буюу 1 метрээс их байвал түүний зааг дээр, хүн унахаас сэргийлэн, өндөр талын шалны ирмэгийг нь дагуулан 0.9 м-ээс багагүй, харин хүүхэдтэй өрөөнд 1.1 м өндөртэй хашлага төлөвлөнө.

Хэрэв шалны түвшний зөрүү нь 1 м-ээс бага бол хүн унахаас сэргийлсэн өөр төрлийн хаалт төлөвлөхийг зөвшөөрнө.

Тайлбар: үзэгчдийн танхим руу хандсан нүүрэн талд дээрхи шаардлага хамаарахгүй.

6.6.11 Хүнд эрсдэл учруулж болзошгүй, төвшиний огцом өөрчлөлттэй шалны тэр хэсэгт хашлага хийхдээ өндөрийг нь 0.9 м-ээс, харин тагт, ложи, гадна талын галерей, террас ашигладаг дээврийн хашлагын өндөр 1.2 м-ээс; ашигладаггүй дээврийн хашлагын өндөр 0.6 м-ээс (дээвэр нь парапеттэй бол түүний өндрийг хашлагын өндөрт оруулан тооцно) багагүй байна.

Шатны марш, эргэлтийн талбай нь 0.9 м-ээс багагүй өндөр хашлагатай байна.

Шатны бариулын өндөр 0.85-0.92 м-ийн хооронд байна.

Хашлага нь 0.3 кН/м –аас багагүй ачаалал даахаар тооцоологдсон, бариултай, тасралтгүй үргэлжилсэн байна.

Сургуулийн өмнөх насны хүүхэд орохыг зөвшөөрдөг үзвэрийн байгууллага, худалдааны газар, худалдаа- цэнгээний объект, рекреацийн төв зэрэг барилгын задгай шатны босоо элементийн хооронд 0.1 м-ээс хэтэрэхгүй зай (хэвтээ чиглэлийн сул зайг хашлагын элементэд гаргахыг хориглоно) гаргана .

6.6.12 Цэцэрлэг, сургууль ба дотуур байртай сургуулийн хичээлийн байр, түүнчлэн хүүхдийн поликлиник, эмчилгээний өрөө тасалгаа, мөн хүүхдэд зориулсан үзвэрийн газрын барилгын шатны хашлага дараах нийтлэг шаардлагад нийцсэн бөгөөд хоорондоо ялгаатай байна. Үүнд:

Хүүхдэд зориулсан шатны хашлагын өндөр 1.2 м-ээс, сургуулийн өмнөх насны, оюуны сашилттай хүүхдийн байгууллагын барилгад 1.8 м-ээс багагүй ба харин тухайн хашлагыг бүхэлд нь торолох бол энэ хэмжээ нь 1.5 м-ээс тус тус багагүй байна.

Шатнууд нь хоёр талдаа бариултай байх ба тэдгээрийг 0.9 м-ийн өндөрт, нэмэлт бариулыг 0.5 -0.7 м-ийн өндөрт тус тус бэхэлнэ.

6.6.13 Спортын битүү, задгай байгууламжийн үзэгчдийн суудал бүхий хэсгийн хүн явах шат, гарц, люкний тооцоот өргөн 4 м-ээс илүү байх үед тэдгээрийн голд 0.9 м-ээс багагүй өндөртэй тусгаарлах хашлага -бариул суурьлуулна.

Харин тэдгээрийн тооцоот өргөний хэмжээ 2.5 м буюу түүнийс бага байвал тусгаарлах хашлага, бариул шаардлагагүй.

6.6.14 Спортын байгууламжийн үзэгчдийн суудлын дараалсан эгнээний шалны түвшний зөрүү 0.55 м-ээс их байвал үзэгчийн суудлын эгнээ тус бүрийн өмнүүр юм үзэхэд саад болохооргүй 0.8 м-ээс илүүгүй өндөртэй хашлага төлөвлөнө.

Биенийн тамир, үзмэрийн танхимын тагт, ярусны нэг дүгээр эгнээний өмнүүрхи хаалт нь 0.8 м-ээс багагүй өндөртэй байна. Дээрх хашлагад эд зүйл доошоо унахаас сэргийлсэн тоноглолыг хаалтад төлөвлөнө.

6.6.15 Театрын барилгын тайзны үйлчилгээнд зориулсан өрөөнүүдэд байгалийн гэрэлтүүлэгтэй шат, мөн дээврийн давхрын ба дээвэр дээр гарах зориулалтын хоёроос цөөнгүй шат төлөвлөнө. Эдгээр шат нь битүү хонгилтой байна. Мөн ажилчид галерей^{HT} ба колосниковын^{HT} хооронд явах хоёр шат төлөвлөнө. Хэрэв шатны битүү хонгил утаашихгүй гэж үзвэл байгалийн гэрэлтүүлэггүй байж болно.

6.6.16 Театрын Нүүлгэн шилжүүлэх замын хэмжээг тооцоходоо хүмүүс (сурагчид, үзэгчид г.м.) хамгийн олноороо байх магадлалтай гэж үзсэн тухайн давхрын өрөөний тооцооны багтаамжийг /хүний тоо/ үндэс болгоно.

6.6.17 Театрын Барилгын эвакуацийн зам нь барилгад онцгой байдал үүссэн нөхцөлд, уг замаар, хүмүүсийг түргэн хугацаанд, эрсдэлгүй аврах нөхцлийг хангахаар төлөвлөгдсөн байна.

Уужим зайтай танхим^{HT} ба өрөө тасалгаанаас хамгийн хол алслагдсан ба мөн ойр байгаа эвакуацийн гарц хүртэл туулах зам, мөн **эвакуацийн үйл ажиллагаа үргэлжлэл зохих хамгийн оновчтой хугацааг** (алдаж үл болох мөч) тооцно. Уг тооцоонд 6.1 ба 6.2 дугаар хүснэгтийг ашиглана.

6.1 дугаар хүснэгт: Том хэмжээтэй танхим дахь хамгийн алслагдсан цэгээс аврах гарц хүртэлх зай ба аврах хугацаа

Танхимын зориулалт	Хамгийн алслагдсан цэгээс аврах гарц хүртэлх зай/аврах хугацаа, м/мин			Тухайн барилгын бүтээцлэлийн галын аюулын анги
	Өрөөний эзэлхүүн (м ³) нь дараах хэмжээтэй байвал,			
	5000 хүртэл	5001-10000	10001 ба үүнээс их	
1. Үйлчлүүлэгчдийн хүлээлэг, касс, үзэсгэлэн, бүжиг, амралтын гэх мэт танхим	30/2.0	45/3.0	55/3.5	C0
	20/1.5	30/2.0	-	C1
	15/1.0	-	-	C2, C3
2. Ширээнүүдийн хоорондахь гарцын аврах замын талбай хүн нэг бүрт 0.2 м ³ -ээс багагүй байх хооллох ба уншлагын танхим	65/2.0	-	-	C0
	45/1.5	-	-	C1

	30/1.0	-	-	C2, C3
Аврах үндсэн гарцын хэмжээг худалдааны танхимын талбайтай харьцуулахад дараах хувь хэмжээтэй тэнцүү байх худалдааны танхимын хувьд, 25 % буюу түүнээс их байвал:	70/1.5	90/2.0	100/2.5	C0
	50/1.0	60/1.5	-	C1
	35/0.8	-	-	C2, C3
	35/1.5	40/2.0	50/2.5	C0
25 % -иас бага байвал:	20/1.0	30/1.5	-	C1
	15/0.7	-	-	C2, C3

Хүснэгт 6.2. Олон нийтийн барилгаас хүмүүсийг аврах хамгийн бага хугацаа

Танхим	Аврах хамгийн бага хугацаа , мин.				
	Танхимын эзэлхүүн, м ³ , байхад				
	5000 хүртэл	10000	20000	40000	60000
Сам тайзтай тайз бүхий театр, клуб, соёлын ордон ба бусад үзэгчдийн танхим	1,5	2	2.5	2.5	-
Сам тайзгүй тайз бүхий үзэгчдийн, концертийн, лекцийн, хурлын үзэсгэлэнгийн (кинотеатр, спортын битүү байгууламж, цирк, гуанз гм.) гм. бусад танхим,	2	3	3.5	4	4.5
<p>* Эзэлхүүн нь завсарын байх тохиолдолд аврах хамгийн бага хугацааг интерполяцийн аргаар тооцно.</p> <p>Тайлбар:</p> <p>1 Өрөөний өндрийн хагасаас дээш түвшинд байгаа тагт ба индрээс хүмүүсийг аврах, нүүлгэн шилжүүлэхэд шаардлагатай хугацааг тус хүснэгтэд бичсэн өгөгдлөөс хоёр дахин бууруулж тооцно.</p> <p>2 Их танхимд үйлчилдэг бага танхим, утвар танхим, хонгилоос хүмүүсийг аврах нүүлгэн шилжүүлэхэд шаардагдах хугацааг тооцохдоо тус хүснэгтэд бичсэн өгөгдлийг нэг минутаар өсгөж тооцно. Ингэхдээ танхим, утвар танхим, хонгилоос хүмүүсийг аврах үйл ажиллагааг нэгэн зэрэг эхлэхээр тооцно.</p> <p>3 Барилгын бүтээцлэлийн галын аюулын C1 ангиллын барилгын өрөөнөөс хүмүүсийг гадагш гаргах шаардлагатай хугацааг хүснэгтэд бичсэн өгөгдлийг 30%, харин C2 ба C3 ангиллын барилгын өрөөнөөс 50% тус тус бууруулан тооцно.</p>					

6.2 дугаар хүснэгт

Танхим	Эвакуацийн хувьд хэтэрүүлж үл болох хамгийн бага хугацаа , мин,
	Өрөөний эзэлхүүн*, м ³ , байхад

	5000 Хүртэл	10000	20000	40000	60000
Колосников бүхий тайзтай театр, клуб, соёлын ордон ба бусад үзэгчдийн танхим	1.5	2	2.5	2.5	-
Колосниковгүй тайзтай үзэгчдийн, концертийн, лекцийн, хурлын үзэсгэлэнгийн (кинотеатр, спортынбитүү байгууламж, цирк, гуанз гм.) гм бусад танхим,	2	3	3.5	4	4.5
* Эзэлхүүн нь завсарын байх тохиолдолд эвакуацийн хувьд хэтэрүүлж үл болох хамгийн бага хугацааг интерполяцийн аргаар тооцно.					
Тайлбар:					
1 Өрөөний өндөрийн тэн хагасаас дээш түвшинд байгаа тагт ба индэрээс хүмүүсийг гадагш гаргах эвакуацийн хамгийн оновчтой хугацааг тус хүснэгтэд бичсэн өгөгдлөөс хоёр дахин бууруулж тооцно.					
2 Танхим, фойе, хонгилоос хүмүүс, танхимын үйлчлэгчдийг гадагш гаргах эвакуацийн хамгийн оновчтой хугацааг тус хүснэгтэд бичсэн өгөгдөлийг нэг минутаар өсгөн тооцно.					
Гэхдээ танхим, фойе, хонгилоос хүмүүсийг гаргах эвакуацийн үйл ажиллагааг нэгэн зэрэг эхлэхээр тооцно.					
3 Бүтээцлэлийн галын аюулын С1 ангийн барилгын өрөөнөөс хүмүүсийг гадагш гаргах эвакуацийн хамгийн оновчтой хугацааг хүснэгтэд бичсэн өгөгдөлийг 30% бууруулан, харин					
С2 ба С3 ангийн барилгын өрөөнөөс бол 50% тус тус бууруулан тооцно.					

6.2 дугаар хүснэгтэд заасан танхим бүхий, бүтээцлэлийн галын аюулын С0, С1 ангитай барилгын дэргэдээс хүмүүсийг холдуулах эвакуацийн хамгийн оновчтой хугацааг доор бичсэнээр тогтооно. Үүнд:

17 м хүртэл өндөртэй барилгад -5 мин;

17-оос 28 м хүртэл өндөртэй барилгад -10 мин байна.

Эдгээр танхим ба түүний ойролцоо цэгээс үзэгчдийг гадагш гаргах эвакуацийн маршрутыг (явах замын чиглэл) Д хавсралтад заасан өгөгдөлүүдтэй нийцүүлэн төлөвлөнө .

Утаашдаггүй шатны хонгилоор дамжих эвакуацийн үйл ажиллагаанд хугацааны норм тогтоохгүй.

6.6.18 Олон нийтийн барилгын (хамгийн алслагдсан өрөөний бие засах газар, угаалга, шүршүүр ба бусад үйлчилгээний өрөө орохгүй) хаалганаас, харин СӨНХБ-ын барилгын хувьд бүлгийн ангийн хаалганаас гадагшаа гарах шатны хонгил буюу гурав дугаар шат хүртэл туулах эвакуацийн замын нийт урт 6.3дүгээр хүснэгтэд заасанаас холгүй байна. Мухар хонгил буюу холл руу гардаг хаалгатай өрөөний багтаамж 80 хүнээс хэтэрхээргүй байна.

6.3 дүгээр хүснэгтэд

Тухайн барилгын галын аюулын бүтээцлэлийн анги	Эвакуацийн үед хүмүүсийн урсгал хөдөлгөөний нягтрал*, хүн./м ² , байх тохиодолд дахь зай хэмжээ, м,				
	2 хүртэл	2 -оос 3 хүртэл	3-аас 4 хүртэл	4-өөс до 5 хүртэл	5-аас их

1	2	3	4	5	6
Шатны хонгилуудын ба (буюу) гадна хаалгануудын дундах өрөөнөөс					
C0*	60	50	40	35	20
C1	40	35	30	25	15
C2, C3	30	25	20	15	10
Мухар хонгил буюу холл руу гардаг хаалгатай өрөөнөөс **					
C0*	30	25	20	15	10
C1	20	15	15	10	7
C2, C3	15	10	10	5	5
*Хүмүүсийн урсгалын нягтрал гэж өрөөнөөс аварч байгаа хүмүүсийн тоог эвакуацийн замын талбайд харьцуулсан харьцааг ойлгоно.					

6.3 дүгээр хүснэгтэд заасан зай хэмжээний үзүүлэлтийг ашиглахдаа:

- Сургуулийн өмнөх насны хүүхдийн барилгад 6 дугаар баганын дагуу,
- Сургууль, мэрэгжлийн боловсролын байгууллагын барилгад 3дугаар баганын дагуу,
- Эмчилгээний барилгад 5дугаар баганын дагуу, зочид буудлын барилгад 4дугаар баганын дагуу тус тус байхаар тооцно.

Олон нийтийн бусад барилгын хонгил дахь хүмүүсийн урсгалын нягтралыг зураг төслөөр тодорхойлоно.

6.6.19 Том хэмжээтэй танхимын аль ч цэгээс эвакуацийн хамгийн ойрын гарц хүртлэх хамгийн алслагдсан зай нь 6.4 дугаар хүснэгтэд зааснаас холгүй байна.

Эвакуацийн үндсэн гарцад зориулсан гарах замын орон зайн хэсгүүдийг /проходы^{HT}/ хооронд нь нэгтгэн нэг ерөнхий нэгдмэл гарах замын орон зайн /проход / болгох тохиолдолд түүний өргөн нь гарах замуудын нийлүүлсэн орон зайн өргөний нийлбэрээс багагүй байна.

6.4 дугаар хүснэгт

танхим	хамгийн ойрын гарц хүртлэх зайн доод хэмжээ,м, (үүнээс хол байж болохгүй)		Тухайн барилгын галын аюулын бүтэцлэлийн анги
	Өрөөний эзэлхүүн... байхад,м ³ ,		
	5000 хүртэл	5001-ээс 10000 хүртэл	
Үзэсгэлэнгийн, хэвлэлийн бага хурлын, гимнастикийн гм.	30 20 15	45 30 -	C0 C1 C2 C3
Ширээнүүдийн дундуурх гарцын аврах замын талбай хүн нэг бүрт 0,2 м ² –ээс багагүй байх хооллох ба уншлагын танхим	65 45 30	-	C0 C1 C2 C3

6.6.20 Танхимтай төстэй боловч үзэгчдийн суудалгүй өрөөний хаалганы цэвэр өргөнийг танхимд нэг дор цуглах тооцоолсон хүний тоонд тулгуурлан 6.5 дугаар хүснэгтийн дагуу тодорхойлоно. Гэхдээ өрөөний хүмүүсийн тоо 50-аас олон байвал хаалганы өргөн 1,2 метрээс багагүй байна.

6.6.21 Нийтлэг зориулалттай коммуникацийн замын өргөн /м/ доор зааснаас бага байгүй байна. Үүнд:

Спортын битүү хучилттай болон задгай байгууламжийн шат, налуу зам, дагуу чиглэлийн гарц 1.2; үзэгчдийн шаталсан суудлын гарцын люк-1.8 байна.

6.6.22 Засаг захиргааны зориулалттай болон хонгилын төлөвлөлтэй бусад байгууллагын барилгын хонгилын өргөн нь тухайн барилгын хонгилын уртаас хамааран доор зааснаас багагүй хэмжээтэй (м) байхаар төлөвлөнө. Үүнд:

- хонгилын урт 10 метр бол 1.2 м,
- хонгилын урт 10 м-ээс илүү бол 1.5 м-ээс багагүй,
- Харин хонгилыг кулуар буюу хүлээлгийн байрны зориулалтаар ашиглах бол өргөн нь 2.4 м-ээс тус багагүй байна.

6.6.23 Худалдааны танхим дахь лангуу, тавиурын хоорондуур худалдан авагчид явахад зориулсан зайны өргөн 1.2 м-ээс багагүй байх ба танхимын хэмжээнээс хамааруулан доор зааснаас бууруулахгүйгээр төлөвлөнө.

Үүнд:

- Худалдааны талбай нь 100 м^2 хүртэл бол 1.4;
- Худалдааны талбай нь $101 \text{ м}^2 - 150 \text{ м}^2$ хүртэл бол 1.6;
- Худалдааны талбай нь $151 \text{ м}^2 - 400 \text{ м}^2$ хүртэл бол 1.8;
- Худалдааны талбай нь 401 м^2 ба түүнээс их бол 2.2;

Хэрэв худалдааны танхимын 6.28-д заасан зай нь эвакуацийн давхар үүрэгтэй байвал түүний параметрийг гал түймэрийн аюулаас хамгаалах шаардлагад нийцүүлэн авна.

6.6.24 Худалдааны лангуу тавиурын дагуух галерейн өргөнийг БНБД 21-02-02 -д зааснаар авна.

6.6.25 Өрөө тасалгаа, хонгилоос шатны хонгил хүрэх эвакуацийн гарц замын өргөнийг галын аюулаас аврах шаардлагын дагуу 1 метр өргөнтэй гарцын тооцоонд үндэслэсэн тухайн гарцаар (0.8 м-ээс багагүй) гарах авруулагсдын тооноос хамааруулан тогтооно.

Насанд хүрсэн хүний хараа хяналтаас хөндий байгаа хүүхэдтэй өрөөний цонхонд түүнийг онгойлгох, түүнээс тохиолдлоор унахаас сэргийлэн холбогдох норм, дүрэмд заасан аюулгүй ажиллагааг хангах систем тусгана.

6.6.26 Хонгилоос шат хүрэх гарц замын өргөн, түүнчлэн шатны маршийн өргөнийг, тухайн барилгын галын аюулын ангиас хамааруулан барилгын уг барилгад байгаа хүний тоо, 1 м өргөнтэй гарцаар гарах хамгийн олон хүний тоог үндэслэн тооцож тогтооно.

1 м өргөнтэй гарцаар гарах хамгийн олон хүний тоо, барилгын галын аюулын анги С нь байвал:

C0	165 –аас олонгүй хүн;
C1	115 –аас олонгүй хүн;
C2, C3	80 –аас олонгүй хүн;

6.6.27 Спорт-үзвэрийн болон олон талын зориулалттай танхимын үзэгчдийн суудлыг Д хавсралтад заасан ёсоор секцүүдэд хуваах ба секц тус бүрт нэг хаалга буюу нэг нээлхий байхаар хуваарилна.

Спортын задгай байгууламжийн үзэгчдийн суудал бүхий шаталсан суудлаас хүмүүсийг аюулгүй гаргах 1 м өргөнтэй замаар гарч болох хамгийн олон хүний тоог хүснэгт 6.6-ын дагуу авч тооцно.

Ослын үед спортын задгай байгууламжийн үзэгчдийн шаталсан суудлаас хүмүүсийг аюулгүй гаргах “1 метр өргөнтэй замаар” гадагш гаргах хүний тоог 6.6 дугаар хүснэгтээс авна.

6.6 дугаар хүснэгт

1метр өргөнтэй гарцаар гарах хүний тоо.				Тухайн барилгын галын аюулын бүтээцлэлийн анги
Суудал хоорондын гарцын шатаар		Суудал хоорондын гарцын люкээр		
доошоо	дээшээ	доошоо	дээшээ	
600	825	620	1230	C0
420	580	435	860	C1
300	415	310	615	C2, C3

Эвакуацийн нэг люкэд оногдох үзэгчдийн нийт тоо доор зааснаас хэтэрэхгүй байна. Үүнд:

Үзэгчдийн суудлын доорхи хучилтын гал тэсвэрлэлтийн хязгаар REI 60 байвал хүн;

- Үзэгчдийн суудлын доорхи хучилтын гал тэсвэрлэлтийн хязгаар нь REI 45 байвал хүн ;

- гал тэсвэрлэлтийн хязгаарын өөр үзүүлэлттэй хучилт бүхий үзэгчдийн суудал дахь хүний тоо 750 хүн тус тус байна.

6.6.28 Спортын битүү байгууламжийн танхимын гарц (хаалга,люк,) нэг бүрт оногдох хүний тоог 600-аас хэтрэхгүй байхаар тооцно.

Спортын тэмцээний талбай дээр суудал засах тохиолдолд уг талбайгаас гарах гарц 2-оос цөөнгүй байх ба эдгээрийн хоорондын зай танхимынхаа уртын талаас багагүй байна.

6.6.29 Өрөөний хаалганы өргөний зайн цэвэр хэмжээг тэнд байхаар тооцолсон хүний тооноос хамааруулан доор үзүүлснээр тогтооно. Үүнд:

15 хүртэл хүн байх бол	Өрөөний зориулалттай уялдуулан тогтооно;
15-25 хүртэл хүн байх бол	0.9 м-ээс багагүй;
25-аас олон хүн байх бол	1.2 м тус тус өргөнтэй байна.

Нэг дор цугларах 50-аас олонгүй хүнтэй өрөөнөөс, мөн хамгийн алслагдсан өрөөнөөс ослын гарц (хаалга) хүртлэх зай нь 25 м-ээс холгүй байршилтай амфитеар болон үзэгчдийн танхимын тагтаас гарах гарцыг нэг байхаар төлөвлөж болно.

Орох хаалны нээлхийн өргөн нь үзэгчдийн танхим руу орох бол 1.2 м-ээс, хурлын танхим руу орох бол 1.6 м-ээс багагүй байх ёстой ба харин ложи руу орох хаалны өргөнийг 0.9 м байхыг зөвшөөрнө. Харин үүдний танхим, фойен хаалганы өргөн 2.4 м-ээс багагүй байна.

6.7 Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа

6.7.1 Үзэгчдийн танхим дахь дарааслан 2 эгнээ суудлын эхний эгнээний араас дараагийн эгнээний ар хүртэлх зай 0.9 м-ээс багагүй байна .

Нэг эгнээнд шууд нийлүүлж тавьсан сандлын тоо нь: хэрэв тус эгнээснээс гарах гарц нэг байвал 26 -аас , хоёр бол 50-аас хэтэрэхгүй байна.

6.7.2 Үзэгчдийн танхимын байнгын суудал (12 хүртэл суудалтай тагт, ложи энд хамаарагдахгүй) шаланд бэхлэх тоноглолтой байна.

Үзэгчдийн байрлалыг шилжүүлэн өөрчилж болдог танхим төлөвлөх тохиолдолд сандал нь унах, гулсахаас сэргийлсэн төхөөрөмжтэй байна.

6.7.3 Сургууль, цэцэрэг, амралтын газрын ба хүүхэдтэй гэр бүл сувилалын газрын барилгын шилэн хаалганд шалнаас дээш 1.2 м-ээс багагүй өндөртэй хамгаалалтын тор бэхлэнэ. Гэхдээ шилний ангилал нь А3 ба түүнээс дээш байх бол торгүй байхыг зөвшөөрнө.

6.7.4 Сургуулийн барилгын рекреацийн байр болгон ашигладаг хонгил нь БНБД 23-02-08 -т заасны дагуу байгалийн гэрэлтүүлэгтэй байна.

6.8 Инженерийн систем

6.8.1 Хүн гараар хүрч болзошгүй халаах хэрэгсэл болон халаалтын өгөх шугамын гадаргуугийн температур 70°C -ээс хэтрэх ёсгүй. Харин халаах хэрэгсэлд хүн шууд хүрэхээс хамгаалсан тохиолдолд 90°C , харин сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагад 75°C хүртэл температуртай байхыг зөвшөөрнө. Бусад системийн хувьд хоолойн гадаргуугийн температур 40°C -ээс хэтэрч болохгүй.

Агаарын халаалтын системийн агаар өгөх нүхнээс 0.1м зайд агаарын температур 70°C -ээс ихгүй байна.

Хэрэгцээний халуун ус хангамжийн усны температур 60°C -ээс ихгүй байна.

6.8.2 Олон нийтийн барилгад камин төлөвлөхдөө холбогдох норм, дүрэм стандартын шаардлагад нийцүүлнэ.Тэдгэрийн байршил нь галын аюулгүйн шаардлагатай нийцсэн байвал зохино.

6.8.3 Газар хөдлөлийн бүс дэх барилга доторхи тоног төхөөрөмжийн хөдөлгөөнөөс гал түймэр, тэсрэлт дэлбэрэлт үүсч болзошгүй учир тэдгээр нь сайн бэхлэгдсэн байна.

6.8.4 Сургуулийн өмнөх насны хүүхэд байнга байрлах өрөө, тасалгааны халаах хэрэгсэл нь хүүхдийг гэмтээхгүй байхаар, эрүүл ахуйн аюулгүй байдал алдагдахаас хамгаалсан байна.

Сургуулийн өмнөх боловсролын бүх байгууллагад бүлгийн өрөөний цонхны тавцан доор суурилуулсан халаах хэрэгслийн доод ирмэгээс шалны гадаргуу хүртэлх зай 0.05 м байхыг зөвшөөрнө.

6.8.5 Газрын гадаргуугаас мансардан дээврийн гадаргуугийн огцом нугачаа хүртэлх барилгын өндөр нь 10 м ба түүнээс их байвал дээвэрт нь 0.15 м-ийн өндөртэй цас тогтооч бүхий хайс төлөвлөнө.

Есөн давхар ба түүнээс өндөр барилгад түүний нүүрэн талыг /фасад/ цэвэрлэх, засварлах аюулгүй ажиллагааны нөхцөл хангахын тулд /цахилгаан дамжуулах утас бүхий/ барилгын люльканы^{HT} /дүүжин өргүүр/ бэхэлгээ төлөвлөнө. Үүнээс цөөн давхар барилгад люлька шаардлагатай эсэхийг зураг төсөл боловсруулах даалгавараар шийднэ.

6.8.6 Арван метрээс илүү өндөр барилгын дээврийн хайсыг БД 31-117-15 -ын шаардлагын дагуу төлөвлөнө.

6.9 Ажиллагсад, үйлчлүүлэгчдийг болон барилгыг хамгаалах арга хэмжээ

6.9.1 Хууль бус үйл ажиллагаа гарсан үед иргэд, барилга,байгууламжид учирч болзошгүй хохирлыг бууруулахад чиглэгдсэн барилга,байгууламжийг гэмт халдлагаас хамгаалах норм дүрэмд нийцсэн, эрүүгийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны цогц арга хэмжээг / системийг / олон нийтийн барилгын зураг төсөлд тусгана. Энэ арга хэмжээг зураг төсөл боловсруулах даалгавараар тогтоох ба түүнийг СП 132.13330 / Барилга байгууламжийн гэмт халдлагаас хамгаалах арга хэмжээ. Зураг төслийн ерөнхий шаардлага /–ийн дагуу боловсруулна.

6.9.2 Бусад төрлийн олон нийтийн барилгыг хамгаалах арга хэмжээг түүний ач холбогдол, хамгаалах түвшинтэй нь уялдуулсан зураг төсөл боловсруулах даалгавар ба тэдгээрийн өвөрмөц төрөлтэй холбогдох бусад баримт бичигтэй [2] нийцүүлэн тодорхойлоно.

6.9.3 Үнэт зүйл, мэдээлэл хамгаалалтын ба бусад зориулалт бүхий тусгай өрөөнд бат бөх хаалт хамгаалалт, орц, гарц, хаалга төлөвлөнө.

6.9.4 Ач холбогдол ба тоо хэмжээ нь зураг төсөл боловсруулах даалгавараар тодорхойлогдсон яриа, хэлцэлийн нууцыг хамгаалах зориулалт бүхий тухайн өрөө, тасалгааны хана, хаалгыг тусгай материалаар өнгөлөх, доторлох ба давхар хаалгатай байхаар төлөвлөнө.

6.9.5 Боловсролын байгууллага, тэдгээрийн суралцагчидыг гэмт халдлагаас болон тэдгээрийн аюулгүй ажиллагаа, гэмт халдлагаас хамгаалах цогц байдлыг хангах зорилгоор уг барилгын нэгдүгээр давхарт тэдгээрийг хамгаалах албаны

ажилтанд зориулсан видео ажиглалт, гал, түймэрийн аюул, аюултай үзэгдлийн мэдээлэлийг орон нутгийн засаг захиргаа ба МУ-ын бусад холбогдох байгууллагад дамжуулах тоног төхөөрөмж бүхий өрөө төлвөлөнө.

Олон нийтийнн барилга доторхи хамгаалалтын үйл ажиллагаанд зориулалттай бүх өрөөнд радио холбооны дамжуулах салбар байршуулахаар төлөвлөнө.

6.10 Давхаржуулалтад тавих шаардлага

6.10.1 Гурван зуун м² (300 м²) –аас илүү талбайтай, мөн 15-аас олон хүн цуглардаг хаяавчийн ба газар доорхи давхар нь эвакуацийн хоёроос цөөнгүй гарцтай байна.

Нэг дор 6-15 хүртэл хүн цугларахад зориулсан хаяавчийн ба газар доорхи давхрын өрөөний хоёр гарцын нэгийг / 4,5 м-с доошгүй шалны түвшинтэй өрөөнөөс /0.75x1.5 м-ээс багагүй цонхоор буюу хаалгаар түүнчлэн 0.6x0.8 м-ээс багагүй хэмжээтэй люкээр /таг бүхий онгорхой нүх/ дамжин шууд гадагш гарахаар төлөвлөхийг зөвшөөрнө.

Гэхдээ прямокоор^{HT} дамжин гарах бол тэр нь шатттай байх ёстой бөгөөд харин өрөөний люк – шатаар /люк - лестница / гарахаар тооцоход тус шатны налууд норм тогтоохгүй. Зураг төслийн шийдэлд эвакуацийн гарцын дээрхи хувилбарын алийг тусгахыг холбогдох байгууллагатай зөвшилцсөн зураг төсөл боловсруулах даалгавыг үндэс болгоно.

6.10.2 Хүүхдийн эмнэлгийн эмчилгээний тасгийг таваас доош давхарт, асрах хүнгүй, долоо хүртлэх насны хүүхдийн эмчилгээний тасаг, сэтгэл мэдрэлийн өвчтэй хүүхдийн тасаг, мөн түүнчлэн хосписын салбарын эмчилгээний тасаг, сувилагчийн асаргааны салбар болон хөгжлийн бэрхшээлтэй өндөр настны дотуур байрны сууцны хэсгийг хоёроос дээш давхарт төлөвлөхийг хориглоно.

6.11 Сургууль

6.11.1 Бүх төрлийн СӨНХБ-ын барилгын гал тэсвэршилтийн зэрэг, мөн галын аюулын бүтээцлэлийн анги ба давхрын тооны дээд хязгаарыг барилгад цугларах хамгийн олон хүүхдийн тооноос хамааруулан 6.8. дугаар хүснэгтэд зааснаар сонгоно.

6.8. дугаар хүснэгт

гал тэсвэршилтийн зэрэг	галын аюулын бүтээцлэлийн анги нь энд зааснаас доошгүй байна	Барилгын давхаршилтын зөвшөөрөгдөх тоо	Барилгын хүчин чадал (суудлынтгоо)
I	C0, C1	3	350 хүртэл
II	C0		
III	C1	2	150 хүртэл
	C0		
нормчлохгүй.	C1	1	100 хүртэл
	нормчлохгүй.		

а/ СӨНХБ-ын тусгай барилгын давтан сургалтын ангийн өрөөнүүдийг хоёроос дээш давхарт байршуулахгүй.

б/ СӨНХБ дахь харааны доголдолтой хүүхдийн сургалтын өрөөг нэг дүгээр давхарт байршуулахаар төлөвлөнө.

Эдгээр барилга нь гал тэсвэршилтийн II зэрэглэлтэй, галын аюулын бүтээцлэлийн анги нь С0-оос доошгүй байна.

6.11.2 СӨНХБ-ын гурван давхар барилга дахь яслийн насны хүүхдийн бага бүлгийн ангийг нэг дүгээр давхарт байршуулна.

Харин барилгын гуравдугаар давхарт ахлах бүлгийн анги, хөгжмийн өрөө, биеийн тамирын танхим, хүүхэд зугаацуулах задгай саравч (веранд), ахуй үйлчилгээний зориулалтын өрөө байршуулахаар төлөвлөж болно.

6.11.3 Хоёр ба гурав дугаар давхар дахь бүлэг нь тус бүртээ шатны хонгилтой, мөн тус тусад нь байрлуулсан эвакуацийн хоёр гарцтай байна. Тэдгээр бүлэг рүү хонгилоор дамжин орохоор төлөвлөнө.

Хоёр дугаар давхарын эдгээр гарцны нэгийг 3-р төрлийн задгай шат байхаар төлөвлөхийг зөвшөөрнө.

Эвакуацийн хоёр гарц төлөвлөхдөө нэг бүлгийг нэг өрөө гэж тооцно.

6.12 Эмнэлэг, сувилал

6.12.1 Хүүхдийн эмнэлгийн эмчилгээний тасгийг таваас дээш давхарт, асрах хүнгүй, долоо хүртлэх насны хүүхдийн эмчилгээний тасаг, сэтгэл мэдрэлийн өвчтэй хүүхдийн тасаг, мөн түүнчлэн хосписын салбарын эмчилгээний тасаг, сувилагчийн асаргааны салбар болон хөгжлийн бэрхшээлтэй өндөр настны дотуур байрны сууцны хэсгийг хоёроос дээш давхарт төлөвлөхийг хориглоно.

6.12.3 Хүүхэд мөн ахлах ангийн хүүхэд эрүүлжүүлэх зуслангийн зуны байр ба жуулчны түр бааз (хижины)-ын барилгыг хоёр давхараас олонгүй, хүүхэд эрүүлжүүлэх байнгын ажиллагаатай зуслангийн барилгыг гурваас илүүгүй давхартай байхаар төлөвлөнө.

Сургуулийн өмнөх насны ба бага ангийн хүүхдийн өрөөг зөвхөн нэг дүгээрт давхарт байрлуулахаар төлөвлөнө.

6.12.3 Хүүхэд эрүүлжүүлэх зуслангийн барилгад унтлагын өрөөнүүдийг нэгтгэн, шат бүхий хонгилоор дамжин гардаг бие даасан гарцтай, 40 хүртэл ортой тусгай бүлгүүд болгон төлөвлөнө.

Хүүхэд эрүүлжүүлэх зуслангийн тусгай байр (блок) буюу галын тусгаар хэсгүүдэд хамаарагдах унтлагын өрнөөнүүдийн орны нийт тоог 160-аас хэтэрэхгүй байхаар тооцно.

6.12.4 Шатаар явах чадваргүй, хэвтэрийн өвчтөн эмчлэх эмчилгээ – сувилал ба нийгмийн халамжийн байгууллагын (эмнэлэг, төрөх газар гм) эмнэлгийн барилгад авах эвакуацийн арга хэмжээг аврах ангийнхан ирэх хүртэл хүлээхийн тулд ойролцоо байгаа галын тусгаарлах хэсгүүд буюу аюулгүйн бүсэд тэднийг шилжүүлэх боломжийг тусгана.

Аюулгүй бүсийн хэмжээг дагуу чиглэлийн зөөврийн хэрэгсэлд (дугуйт ор, түрдэг тэргэнцэр) ноогдох хэвтрийн өвчтний тооцоонд үндэслэн тодорхойлоно.

Өрөөнд тавих шаардлагыг БД 31-115-12-ээс үзнэ.

Дээрхи аюулгүй бүс нь утаажихгүй ба бусад өрөөнүүдээс утаажихгүй гонхоор (шлюз) тусгаарлахаар төлөвлөнө. Гал гарсан үед аюулгүй бүс буюу гонхонд 20-40 Па-ын илүүдэл даралт үүсдэг байхаар тооцно.

Аюулгүй бүсэд аврах шат эсвэл барилга байгууламжийн гал сөнөөгчдийн лифт шаардлагад нийцсэн байна.

6.12.5. Зуны ажиллаагаатай хүүхдийн амралтын газар ба жуулчны баазын барилга хоёроос илүүгүй, ахлах ангийн хүүхдэд зориулсан байнгын ажиллаагаатай амралтын газарт гурваас илүүгүй давхартай барилга төлөвлөнө. Сургуулийн өмнөх насны ба бага ангийн хүүхдийг зөвхөн нэгдүгээр давхарт байрлуулна. Хүүхдийн амралтын барилга төлөвлөхөд СанПиН 2.4.4.3155-н шаардлагыг бармтлана.

6.12.6. Зорчигч тээврийн буудлын (авто замын, төмөр замын, нисэхийн гм) барилга дотор зочид буудал төлөвлөхдөө бие даасан шат, гол хонгил руу орох болон мөн түүнчлэн гадна талын задгай гүүрэн гарц (эстакад^{HT}), гадаах тавцан (платформ^{HT}) -д шууд очих зам, зорчин явагчдын хүлээлгийн нэгдсэн танхимд орох бие даасан аврах зам төлөвлөнө. Энд заасан шат, хонгилуудын 50 -аас доошгүй хувийг дээр нэрлэсэн танхимтай нарийн уялдуулан төлөвлөвөл зохино.

6.12.7 Урьдчлан сэргийлэх ба нийгмийн хамгааллын хэвтэн эмчлүүлэх эмнэлэгт эмчлүүлж байгаа, шатаар явах чадваргүй хэвтэрийн хүмүүст зориулсан хэвтээ чиглэлийн аврах гарцыг галын зэргэлдээх таславч буюу авран хамлаалагчид ирэх хүртэл түр байлгах аюулгүйн бүс төлөвлөнө. Аюулгүй бүсийн хэмжээг хэвтээ чиглэлийн зөөврийн хэрэгсэлээр (дугуйт ор) хэвтэрийн хүмүүс зөөх тооцоонд үндэслэн тодорхойлоно. Өрөөнд тавигдах шаардлагыг СП 59.13330 –аас лавлана.

Барилгын аюулгүй бүс нь утаа үл орохоор байх ба бусад өрөөнөөс утаагүй шлюзээр тусгаарлагдсан байна. Гал гарсан үед өрөө ба шлюзэд 20 - 40 хүртэл Па илүүдэл даралт үүссэн байна.

Барилгын аюулгүй бүс рүү аврах шат буюу ГОСТ Р 52382, ГОСТ Р 53296-н шаардлагад нийцсэн тус норм, дүрмийн 4.13-т заасан үзүүлэлт бүхий лифтээр хүргэнэ.

6.12.8 Гал тэсвэршлийн V зэрэглэлийн барилга бүхий зуны амралтын газар, мөн гал тэсвэршлийн IV ба V зэрэглэлийн барилгатай хүүхдийн амралт сувиллын барилга нэг давхар байхаар төлөвлөнө.

6.12.9 Төмөр замын буудал дотор байгаа зочид буудал нь шатны хонгил, гол хонгил /коридор/ болон гадагшаа шууд гарах хаалга бүхий ерөнхий заал тийш хөтөлсөн аврах гарцтай байна.

Энд тэмдэглэсэн шатны хонгил буюу гол хонгилын нийт хэмжээний 50–аас доошгүй хувийг ерөнхий зааланд зориулан төлөвлөнө.

6. 12.10 Олон нийтийн барилга дотор байгаа сууцны зориулалттай өрөөний галын аюулгүй байдлыг хангахын тулд БНБД 31-01-10, БД 31-118-15-д заасан галын аюулаас сэргийлэх арга хэмжээг нарийн тусгана.

6.12.11 Аудитори, нийтлэг өрөө, хэвлэлийн бага хурлын мөн биеийн тамир-спортын, хурлын танхим зэргийг хүний суудлын тооноос нь хамааралтайгаар 6.9 дүгээр хүснэгтэд зааснаас дээш давхарт байрлуулахгүй байхаар зураг төсөлд тусгана.

6.8 дүгээр хүснэгт

Лекцийн ба хурал- үзвэрийн танхим дахь суудлын тоо	Лекцийн (аудитори) өрөө ба танхим	Тухайн барилгын
--	--------------------------------------	-----------------

	байрлуулахыг зөвшөөрөх давхрын дээд хязгаар	галын аюулын бүтээцлэлийн ангилал энд зааснаас доошгүй байна
300 хүртэл	16	C0
301- 600	5	
601 ба түүнээс олон	3	
300 хүртэл	3	C0
600 хүртэл	2	C1
600 хүртэл	1	C2
100 хүртэл	1	C1-C3

6.12.12 Үзэгчдийн ба нийтлэг заал, спортын танхимын тагтад /балкон/ суусан үзэгчид нь танхимаар дамжихгүйгээр гардаг байхаар төлөвлөнө.

6. 12.13 Театр, кинотеатр концертын танхим, клуб, цирк, асар бүхий спортын байгууламж, номын сан зэрэг газрууд дахь тусгай өрөөнд суух зочдод зориулсан, тодорхой тооны хүндэтгэлийн суудал болон мөн үзэгчдийн суудлын тоо , тэдгээрийг аль давхарт (хэд дэх давхарт) байрлуулахыг барилгын галд тэсвэршилтийн зэрэг ба галын аюулын бүтээцлэлийн ангийг харгалзан 6.9 дугаар хүснэгтэд зааснаар тогтооно .

6.9 дугаар хүснэгт

Заалан дахь суудлын хамгийн дээд тоо	Барилга дотор ба түүний галын бүслэвчийн хэсэгт төлөвлөх танхимыг байршуулахыг зөвшөөрөх давхрын дээд хязгаар	Тухайн барилгын галын аюулын бүтээцлэлийн анги нь энд зааснаас доошгүй байна	Барилгын галд тэсвэршилтийн зэрэг нь энд зааснаас доош байж болохгүй
Норм тогтоохгүй	Норм тогтоохгүй	C0 C1	I
600	3 2	C0 C1	II
600 400	2 2	C0 C1	III
300 150	2 1	C0, C1 C2, C3	IV
150	1	Хязгаар тогтоохгүй	V

6.12.14 Галын харуул-диспетчерийн өрөөг тайзны шалны төвшинд буюу эсвэл доод давхарт нь байрлуулан, байгалийн гэрэлтүүлэгтэй, шат буюу гадна оронд ойрхон байхаар төлөвлөнө.

Гал унтраалгын ба аж ахуйн усны шахуургын өрөөг галын харуул-диспетчерийн өрөөтэй цуг, хооронд нь явахад саадгүй байхаар буюу эсвэл түүний дор байршуулна.

6.13.Театр,үзэгчдийн танхим

6.13.1 Тайз (эстрад), ажлын галерей , колосниковын тавцан, трюм, хөгжмийн байр ба чимэглэл хадгалах агуулахын байрнаас гадагш гарах хоёроос цөөнгүй аврах гарцыг тус бүрд нь төлөвлөнө.

6.13.2 Зохих журмын дагуу зөвшөөрөгдсөн, нэг дор байх 50-с олон хүнд зориулсан өрөөг дамжин гарахаар кино театр , клуб болон проекцоор кино үзүүлдэг танхимын ослын гарц төлөвлөхийг хориглоно.

Улирлын ажиллагаатай, үзэгчдийн танхим нь фойегүй кино театрт хоёроос доошгүй ослын гарц төлөвлөнө. Тэдгээрийн нэгийг үзэгчдийн танхимд орох хаалга байхаар төлөөлүүлж болно.

6.13.3 Задгай театрт тоглолт үзэх үзэгчдэд зориулан хоёр дугаар зэргэлэлийн хоёр аврах шат төлөвлөхийг зөвшөөрнө. Гэхдээ бусад шат нь битүү хонгилтой байна..

6.13.4. Галын аюулын бүтээцлэлийн анги нь С1-ээс бага спортын битүү байгууламжийн барилгын дээд давхарт нь туслах чанарын өрөө төлөвлөх шаардлага тохиолдолдсон үед уг барилгын давхрын тоо тав хүртэл байж болно.

Үзэгчдийн суудал ба спортын тэмцээний гол талбарын /арена/ гал тусгаарлах ханан дахь хаалгыг битүүмжлэл сайтай гонхтой бөгөөд өөрөө хаагддаг байхаар төлөвлөнө. Эдгээр хаалгыг модоор хийхийг зөвшөөрнө.

6.14.Номын сан, архив

6.14.1. Номын сан есөн давхар, архивын барилгын давхаршилт нь 5 давхраас хэтрэхгүй байна.

6.14.2. Тэдгээрийн ном хадгаламжийн зориулалт бүхий хэсгийг галд тэсвэртэй ханаар зааглагдсан 600 м² хүртэл талбай бүхий өрөө байхаар төлөвлөнө.

6.15.Худалдаа

6.15.1 Ном худалдааны газрын барилгын давхрын тоо, давхрын талбайн хэмжээг барилгын галын аюулын бүтээцлэлийн ангиас хамааруулан 6.10дүгээр хүснэгтэд зааснаар тогтооно.

6.10дүгээр хүснэгт.

Давхаржилтын дээд хязгаар	Тухайн барилгын хувьд давхрын талбайн дээд хэмжээний дээд хязгаар , м ²			Галын аюулын бүтээцлэлийн анги нь энд зааснаас доошгүй бол
	Дан барилга	2 давхар барилга	3-5 давхар барилга	
5	3500*	3000*	2500*	C0
2	2000**	1000	-	C1
1	500	-	-	C2, C3

* Автомат гал унтраагч суурьлуулсан тохиолдолд талбайн хэмжээг 2 дахинаас хэтэрүүлэхгүйгээр нэмэгдүүлж болно.

**** Хүнсний дэлгүүрийн дан барилгын худалдааны танхимыг бусад өрөөнүүдээс галд тэсвэртэй ханаар тусгаарласан тохиолдолд давхарын талбайн хэмжээг 2 дахин өсгөж болно.**

6.15.2 Шатамхай бүтээгдэхүүн ба шатамхай боодолтой бүтээгдэхүүний агуулахыг 250 м² ба түүнээс их талбайтай худалдааны танхимаас галд тэсвэршилтийн 1-р хэв шинжтэй ханаар тусгаарлахын хамт гадна талын ханыг түшиглүүлэн байршуулна.

6.15.3 Биеэ даасан дан барилгатай болон өөр зориулалтын барилга дотор төлөвлөсөн, зарим хэсэг нь уг барилга дотроо, нөгөө хэсгийг нь залгаж төлөвлөсөн эсвэл уг барилгатай бүхэлд нь залган төлөвлөсөн 150 м² хүртэл худалдааны талбайтай дэлгүүрт хоёр гарц төлөвлөнө. Гэхдээ нэг гарцыг нь худалдааны танхимаас шууд гарахад, нөгөө гарцыг агуулахын өрөө, худалдааны бус зориулалтай өрөөгөөр дамжин гарахаар төлөвлөхийг зөвшөөрнө.

6.15.6. Худалдааны газрын 250 м² хүртэл талбайтай худалдааны танхимд түүнтэй зэрэгцээ байгаа агуулахаас нь бараа оруулах зориулалттай нэмэлт чөлөөт орон зай нээхийг төлөвлөхийг зөвшөөрнө.

6.15.7. Хэрэв галын аюулын бүтээцлэлийн C0 ангитай барилгын дээд давхарт жижиглэн худалдааны байгууллагын агуулах, туслах ажилтан, ахуйн, техникийн зориулалттай өрөө байршуулах бол уг барилгын давхарын тоог нэгээр нэмэгдүүлж болно.

6.16.Зорчигч тээвэр

6.16.1. Зорчигч тээврийн буудлын барилгын (авто замын, төмөр замын, нисэхийн гм) хонгил буюу шатны хонгилоос гарах нийт гарцын (орон зайн) 50 хувь нь гадагшаа буюу эсвэл гадна талын задгай тавцан (платформ) руугаа шууд гарах гарц бүхий зорчигчдын нэгдсэн танхимтай холбогдохоор төлөвлөхийг зөвшөөрнө.

6.17.Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээ

6.17.1 Нийтийн аж ахуй ба ахуйн үйлчилгээний газруудын харъяа үйлчилгээний зориулалттай салбарын барилгад тохирох давхрын тоо, давхрын талбайн зохистой хэмжээг тухайн барилгын галын аюулын бүтээцлэлийн ангиас хамааруулан хүснэгт 6.11-т зааснаар тогтооно.

6.11 дугаар хүснэгт.

Давхаржилтын хязгаар	Тухайн барилгын давхарын талбайн* дээд хэмжээ, м ²	барилгын галын аюулын бүтээцлэлийн анги
5	3500	C0
4	2500	C1
3	2000	C0
2	1000	C1
1	500	C1-C3

* Автомат гал унтраагч суурьлуулсан бол талбайн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж болно.

6.17.2 Ахуйн үйлчилгээний газрын барилгын тооцоот талбай 200 м² –аас их байвал үйлчилгээний ажилтны орц, шат нь үйлчлүүлэгдийн орц, шатнаас тусдаа байна.

6.17.2 Өөр зориулалтын барилгад ажиллуулах сауны өрөө нь арваас илүүгүй суудалтай байна.

6.17.3 Сауныг аливаа барилгын суурийн давхар, үзвэрийн газрын суудлын дор болон мөн хүүхэд эрүүлжүүлэх байр, цэцэрлэг, дотуур байрт сургуулийн үндсэн барилга дотор болон хэвтэн эмчлүүлэх барилга дотор түүчлэн 100-аас дээш хүнтэй өрөөнүүдийн доод давхарт төлөвлөхийг хориглоно

6.18.Сургууль

6.18.1 Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамир, спортын танхимыг хоёроос дээшгүй давхарт байрлуулна. Эдгээр танхимын харалдаа доод давхрын өрөөнд сургалтын үйл ажиллагаа болон эсвэл өрөөндөө дүүжин таазтай гуанз ажиллуулж болохгүй.

Дуу чимээний даралт, доргионы нормативын шаардлага хангасан биеийн тамирын сургалтын өрөөг хоёр ба түүнээс дээш давхарт байршуулж болно.

6.18.2 Ерөнхий боловсролын ба боловсрол нөхөн олгох боловсролын байгууллагын барилгын давхаршилт, хүчин чадлын (багтаамж) хэмжээг тогтооход тухайн барилгын галын аюулын бүтээцлэлийн анги, гал тэсвэршилтийн зэрэг буюу галын бүслэвчийн онцлогтой уялдууслан заалт бүхий 6.12 дүгээр хүснэгтийг ашиглана.

6.12 дүгээр хүснэгт

Гал тэсвэршилтийн зэрэг	Тухайн барилгын галын аюулын бүтээцлэлийн анги нь энд зааснаас доошгүй байна.	Тухайн барилгад зөвшөөрөх давхрын тоо	Тооцоот сурагчдын нийт тоо,хүн,
I	C0	4	нормчлохгүй
	C1	3	1600 хүртэл
II	C0	2	600 хүртэл
	C1		350 хүртэл
III	C0	1	270 хүртэл
	C1		
Нормчлохгүй.	Нормчлохгүй.		

Ерөнхий боловсролын сургуулийн нийтлэг танхимыг хоёроос дээш давхарт байршуулахыг хориглоно.

Нийтлэг танхим ба лекцийн өрөө, танхимын доорхихучилтын гал тэсвэршилтийн хязгаар “REI 60”-тэй тэнцүү буюу үүнээс дээш байна.

6.18.3. Сургууль, дотуур байртай сургуулийн цогцолбор нь (биеийн ба оюуны хөгжлийн хомсдолтой хүүхдийн) гурван давхраас олонгүй байна.

6.18.4. Ерөнхий боловсролын байгууллага дахь хүүхэдийн унтрагын өрөөг бусад өрөөнүүдээс гал тусгаарлах хана буюу эсвэл I төрлөөс доошгүй галд тэсвэртэй хамар ханаар тусгаарласан блок буюу эсвэл барилгын тодорхой хэсэгт төлөвлөнө.

6.18.5. Ерөнхий боловсролын байгууллагын хүүхэд унтуулах байрын давхаршилт болон хүчин чадлыг тогтооход уг барилгын галын аюулын бүтээцлэлийн анги болон мөн гал тэсвэршилтийн зэрэгтэй уялдуулсан хүснэгт 6.14- г ашиглана.

6.14 дүгээр хүснэгт

Гал тэсвэршилтийн зэрэг	Тухайн барилгын галын аюулын бүтээцлэлийн анги нь энд зааснаас доошгүй байна	Тухайн барилгад зөвшөөрөх давхрын тоо	Барилгад байж болох унтах байрны тоо
I, II	C0	4	Нормчлохгүй.
III		2	280 хүртэл
IV	C1	1	200 хүртэл
	C0		140 хүртэл
Нормчлохгүй.	C1-C3		60 хүртэл
	Нормчлохгүй.		

6. 18.6. Дараах нөхцөл хангагдсан тохиолдолд том ба асар том хотод ерөнхий боловсролын байгууллагын 5 давхар хичээлийн байр, дотуур байртай сургууль барихыг зөвшөөрнө. Үүнд:

а–аврах, болон гал унтраах нөхцөл хангагдсан,

б – байгууллагын ажилчид ба дохиолол өгөх байгууллагын оролцоогүйгээр гал түймэрээс хамгаалах салбарын пульт /удирдлага/ дээр дохиоллыг хослуулсан, в –Олон нийт - бизнесийн бүс (төв) ба орон сууцны хороолол шинээр төлөвлөх болон шинэчлэн өөрчлөх зураг төслийн баримт бичиг боловсруулахдаа холбогдох норм ба дүрэм, стандартын шаардлагыг чанд мөрдсөн,

Тайлбар: Газар хөдлөлийн 6 ба түүнээс дээш баллын чичирхийлэлтэй мужид гурваас дээш давхартай ерөнхий боловсролын сургууль, "дотуур байртай сургуулийн" цогцолбор барихыг зөвшөөрөхгүй.

6. 18.7. Ерөнхий боловсролын сургууль, "дотуур байрт сургууль" цогцолборын хичээлийн байрны дөрөв ба тав дугаар давхарт 7-12-р ангийн сургалтын ба захиргааны, үйлчилгээний өрөө төлөвлөж болно.

6. 18.9. Зөвшөөрөгдөх давхарын тооны хүрээнд багтаан ерөнхий боловсролын сургуулийн барилгыг мансардын давхараар өрөгтгөж болно.

6.18.10 Дан модон ба мод, төмөр материалыг хослуулан эдлэл боловсруулдаг мужааны ба төмрийн дарханы сургалтын цехийг ерөнхий боловсролын сургуулийн барилгын нэгдүгээрт байршуулна.

Эдгээр цехүүдэд дулаалгатай гонх буюу эсвэл анги, кабинет, лаборотороос хонгилоор шууд гадагш гарах нэмэлт тусгай гарц төлөвлөх шаардлагатай.

6.18.11. Дээд боловсролын байгууллагын хичээлийн байрны давхрын тоо есөөс олон байж болохгүй. Энд зааснаас олон давхар болгох шаардлага гарсан тохиолдолд түүнийг хот байгуулалтын шаардлагатай уялдуулсан тусгай даалгаварыг үндэс болгон төлөвлөнө.

6.18.12. Давтан мэрэгшүүлэх боловсролын байгууллагын хичээлийн байрны давхрын тоо нь хот төлөвлөлтийн шаардлагаар нотлогдсон тохиолдолд есөн давхраас олон байж болно.

6.18.13 Галын аюулын хувьд тодорхой нэг ангилалтай барилгад галын зориулалтын аюулын өөр өөр ангилалтай барилгын галын бүслэвчийг зориулалтын хамт байршуулж болно. Энэ тохиолдолд уг барилга олон чиг үүрэгтэй барилгад тооцогдоно.

Гал тэсвэршилтийн I-р төрлийн хучилтаар тусгаарлагдсан барилгын тухайн давхрыг нэг “галын бүслэвч” гэж үзнэ.

Хэрэв давхрыг нэг ч болов гал тэсвэршилтийн I-р төрлийн бус хана буюу хучилтаар тусгаарласан бол уг хэсгийг (давхрыг) үндсэн барилгын (галын бүслэвчийн) бүтцэд байгаа бусад өрөөнүүдийн адил зориулалтын галын аюулын ангилалтай гэж үзнэ.

Олон чиг үүрэгтэй барилгад галын бүслэвчийн зөвшөөрөгдөх хэмжээг өсгөхгүйгээр, зориулалтын галын аюулын ангилалыг [БНБД 21-01-02-ын 5,21] өөрчлөлгүйгээр, мөн бие даасан галын таславч болгон хувиарлалгүйгээр дараах зориулалтын галын аюулын ангилалын давхар ба бүлэг өрөө байршуулахыг зөвшөөрнө. Үүнд:

Ф1.2-Зочид буудлын;

Ф2.1 ба Ф2.2 -Үзвэрийн, соёл – гэгээрлийн, соёл – чөлөөт цаг өнгөрөөх газрын;

Ф3 - Хүн амын үйлчилгээний байгууллагууд;

Ф4.1 - Зөвхөн сургуулийн гадуурх сургалтын байгууллага;

Ф5.1 - Зөвхөн тухайн барилгад үйлчлэх засвар үйлчилгээний газрууд
Ф5.2 – ном хадгаламж, архив, агуулах ба агуулахын өрөө ба зөвхөн тухайн байгууллагын үйлчилгээний авто зогсоол / БНБД 21-05-10- ын шаардлагыг хангасан байх /

7. ЭРҮҮЛ АХУЙ-ТАРХВАР ЗҮЙН ШААРДЛАГА

7.1 Олон нийтийн барилгад байгалийн болон зохиомол гэрэлтүүлгийг төлөвлөхдөө БНБД 23-02-08-ыг баримтална.

7.2 Байгалийн гэрэлтүүлэггүй байх нэмэлт шаардлага тавигдаагүй л бол олон нийтийн барилгын байнга хүн ажиллах бүх өрөө тасалгаанд байгалийн гэрэлтүүлэг төлөвлөнө.

Гэрэл нэвтрүүлэх тунгалаг хийцийн талбайг БНБД 23-02-09-д зааснаар түүний дулаан дамжуулалтын хөрвүүлсэн эсэргүүцэл $0.56 (m^2 \cdot ^\circ C) / Wt$ –аас их үед нэмэгдүүлж болно.

7.3 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын анги бүлэг түүнчлэн бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын өрөө тасалгаанд гэрэлтүүлгийн (хажуугаас, дээрээс эсвэл хосолсон) байдлаас үл хамааран зүүн гар талаас гэрэл тусахаар төлөвлөнө.

7.4 Дээд талаас тусах байгалийн гэрэлтүүлэг (дээрээс-ташуу)-ийг бүлгийн хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө, насанд хүрэгчид болон хүүхдийн сэтгэлзүйн өрөө (гэрийн булан), жижүүрийн өрөө, хөгжмийн танхим, биеийн тамирын танхим, бассейны өрөө, хүүхдийн дугуйлан, секцийн өрөө, амрах талбайд төлөвлөхийг зөвшөөрнө.

Байгалийн гэрэлтүүлэг бүхий хонгилын гэрэлтүүлгийг Олон айлын сууцны барилгын нормыг баримтлан төлөвлөнө.

7.5 Уур амьсгалын II-IV бүсэд баригдах сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлгийн болон унтлагын өрөөг зэрэгцээ өрөө, хонгил эсвэл өрөөний булангаас агааржуулахаар төлөвлөнө.

7.6 Дараах өрөө, тасалгааг зөвхөн гэрлийн хоёрдогч тусгалаар гэрэлтүүлэхээр төлөвлөнө. Үүнд:

- байгалийн гэрэлтүүлэггүй байхыг зөвшөөрдөг өрөө (агуулах, дэлгүүрийн худалдааны танхим, номын агуулахаас бусад) ;

- уур амьсгалын I, II, III бүсэд баригдах сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүлээлгийн ба гал тогооны хэрэгсэл угаах өрөө;

- хувцас солих өрөө ба банын хүлээлгийн өрөө, эрүүлжүүлэх-усан сангийн цогцолбор;

7.7 Олон нийтийн барилгын дор дурдсан өрөө, тасалгааг байгалийн гэрэлтүүлэггүй төлөвлөхийг зөвшөөрнө. Үүнд:

- зоорины давхарт байрлахыг зөвшөөрдөг өрөө тасалгаа;

- сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ариун цэврийн болон хувцас солих өрөө, буфет;

- спорт-үзүүлбэр ба спорт-урлагийн заал;

- мөсөн бүрхүүл бүхий спортын заал;

- спортын байгууламжид байрлах багш, дасгалжуулагчийн өрөө;

- эмнэлгийн байгууллагын өрөө, технологийн шаардлагаар сүүдэрлэх хэрэгтэй эсвэл байгалийн гэрэлтүүлэг шаардлагагүй өрөө тасалгаа;

- ахуйн үйлчилгээний газрын үйлчлүүлэгч хүлээн авах салон (үсчин, гоо сайхнаас бусад);

- үйлчилгээний ажилчдын өрөө;

- сантехникийн зангилаа;

- ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө, шүршүүрийн өрөө, хуурай сауны өрөө, бялдаржуулах танхим ба өрөө

Байгалийн гэрэлтүүлэггүй хонгил төлөвлөхдөө галын аюулгүй байдлын шаардлагыг харгалзан төлөвлөнө.

7.8 Нарны шууд тусгалын эрүүл ахуйн шаардлага, бичил уур амьсгал

7.8 Сургууль

7.8.1 Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, мэргэжлийн боловсролын байгууллага, эрүүл мэндийн ба нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын өрөө, тасалгаанд нарны тусгалыг эмнэлгийн байгууллагын өрөө, тасалгаанд тавигддаг шаардлагад нийцэхээр төлөвлөнө.

7.8.2 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын төлөвлөлтийн талбайд, сургуулийн биеийн тамир спортын болон амралтын бүсэд, эмнэлэг, нийгмийн үйлчилгээний байгууллагын амралтын бүсэд тусах нарны тусгалын үргэлжлэх хугацааг БНБД 23-04-07-г баримтлан тодорхойлно.

7.8.3 Долоодугаар сарын дундаж температур нь 21⁰С ба түүнээс дээш байдаг орон нутагт төлөвлөгдөж буй барилгын байнга хүн байрлах болон эрүүл ахуй, технологийн шаардлагаар нарны цацраг нэвтрэхийг эсвэл хэт халахыг хориглодог өрөө тасалгааны хувьд 130-315⁰ хязгаарт байрлах гэрэлтүүлгийн нээлхий нь нарны гэрэл нэвтрүүлэхээс эсвэл хэт халалт үүсгэхээс хамгаалагдсан байх ёстой.

7.8.4 Өрөө тасалгааны дотор агаарын бичил уур, амьсгалын үзүүлэлтийг сонгохдоо энэхүү норм ба дүрмийн заалтыг баримтална.

Үүнд жилийн хүйтний улиралд дотор агаарын үзүүлэлтийн хамгийн оновчтой утгаар, дулааны улиралд зөвшөөрөгдөх утгаар тооцно.

7.8.5 Үйлдвэрлэл-техникийн зориулалттай (мастерын өрөө, лаборатори, агуулах, хэвлэх-олшруулах г.м) өрөө тасалгааны бичил орчны үзүүлэлтийг тооцохдоо MNS 4990 ба MNS 5078-ын шаардлагыг харгалзсан байна.

7.8.6 Өрөө тасалгааны дотор агаарын тооцооны температурыг хашлага бүтээцийн дулаан хамгаалалтын тооцоонд температурын горимын шаардлагат үзүүлэлтээр, байхгүй бол 18°C -ээр эсвэл технологийн шаардлагаар сонгоно.

Олон нийтийн барилгын халаалтын системийн тооцоонд дотор агаарын тооцооны температурыг тухайн барилгын төлөвлөлтийн норм ба дүрэм болон MNS 5825 стандартад тодорхойлсон зөвшөөрөгдөх хамгийн бага утгаар тооцно.

Ажлын цаг эхлэхэд хэвийн нөхцөлийг хангах боломжтой бол олон нийтийн барилгын өрөө тасалгааны бичил орчны үзүүлэлтүүдийг ажлын бус цагаар бууруулахыг зөвшөөрнө. Ажлын бус цагаар өрөөний температур нормт утгаас гэхдээ 12°C -аас багагүй байж болно.

Зөвхөн техникийн заавар эсвэл журамд өөрөөр заагаагүй тохиолдолд л ажлын бус цагаар температур бууруулахыг зөвшөөрнө.

7.8.7 Агаарын болон агаарын дулааны хөшгийг дараах тохиолдолд төлөвлөнө. Үүнд:

- өрөөний гадна ханын байнга онгойдог нээлхий түүнчлэн гадна агаарын тооцооны температур хасах 15°C түүнээс бага байдаг (Б үзүүлэлтээр) орон нутагт тамбургүйболон нэг ээлжид 40 минутад тав ба түүнээс олон удаа онгойх хаалга, нээлхийн дэргэд;

- олон нийтийн барилгын үүдний танхимын гадна хаалганы хувьд гадна агаарын тооцооны температур болон 1 цагт хаалгаар орж, гарах хүний тооноос хамааруулж доорх тохиолдлуудад төлөвлөнө. Энд:

- тооцооны температур хасах 15°C -ээс хасах 25°C хүртэл үед хүний тоо 400 түүнээс дээш бол,

- хасах 26°C -ээс хасах 40°C үед хүний тоо 250 түүнээс дээш бол,

- хасах 40°C -аас бага үед хүний тоо 100 түүнээс дээш бол;

- кондиционерийн систем бүхий өрөөний гадна хаалга, үүд, нээлхийн дэргэд;

Үечилсэн ажиллагаатай агаарын хөшигнөөс өгөгдөх дулааныг тухайн өрөөний агаарын болон дулааны тэнцэлд оруулж тооцохгүй.

7.8.8 Гадна хаалга, үүд, нээлхийн дэргэд байрлах агаарын болон агаарын дулааны хөшгийг төлөвлөхдөө салхины даралтыг тооцох шаардлагатай. Агаарын зарцуулалтыг тодорхойлохдоо гадна агаарын тооцооны температур болон салхины хурдыг Б үзүүлэлтээр сонгох ба хурд нь 5м/с -ээс ихгүй байх ёстой. Хэрэв Б үзүүлэлтээр салхины хурд А-аас бага бол агаар халаагуурын шалгах тооцоог А үзүүлэлтийн утгаар гүйцэтгэнэ. Агаарын хөшигний нүхнээс гарах агаарын урсгалын

хурд гадна хаалганд 8м/с-ээс, технологийн хаалга, нээлхийд 25м/с-ээс ихгүй байх ёстой.

7.8.9 Олон нийтийн барилгын өрөө тасалгаанд гадна хаалга, үүд, нээлхийнээс шууд агаар дамжин ордог бол үүдний танхим дах агаарын хольцын тооцооны температурыг 12⁰С-ээс багагүй байхаар тооцно.

7.8.10 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын дотор агаарын тооцооны температур, агаар солилцооны давтамж MNS 6558 болон холбогдох бусад норм, дүрмийн шаардлагад нийцэж байх ёстой.

7.8.11 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын унтлагын өрөөнөөс агаарыг зайлуулахдаа булангаас болон бүлгийн өрөөгөөр дамжуулан гүйцэтгэхийг зөвшөөрнө.

Хоолны газрын агаар зайлуулах шугам хоолой бүлгийн болон унтлагын өрөөгөөр дамжихыг хориглоно.

7.8.12 Сургуулийн барилгын дотор агаарын тооцооны температур, агаар солилцооны давтамжийг Хүснэгт 7.1-ээс сонгож болно. Өдөр өнжүүлэх бүлгийн унтлагын өрөөний температур ашиглалтын горимд тооцооны утгаас $\pm 1^{\circ}\text{C}$ хэмжээгээр л хэлбэлзэж болно.

Хүснэгт 7.1

Үндсэн өрөө, тасалгаа	Агаарын тооцооны температур, ⁰ С	1 цагт солилцуулах агаар солилцооны давтамж, багагүй
Хичээлийн анги, танхим, лаборатори, хурал, лекцийн танхим, дуу хөгжим, клубийн өрөө	18	2 , гэхдээ оруулах агаар нэг суудалд 20м3/цагаас багагүй
Сургалтын дадлагын өрөө	18	
Дугуйлангийн өрөө	18	1.5, гэхдээ оруулах агаар нэг суудалд 20м3/цагаас багагүй
Сургуулийн дотуур байр өдөр өнжүүлэхийн унтлагын өрөө	20	

7.8.13 Агаарын халаалттай бол сургууль, сургуулийн өдөр өнжүүлэх танхимд өгөх агаарын температур ажлын цагаар 40⁰С-ээс ихгүй байна.

7.14 Сургуулийн цайны газрын солилцуулах агаарын хэмжээг тодорхойлохдоо гал тогооны тоног төхөөрөмжөөс ялгарах дулааны хэмжээг тооцсон байх шаардлагатай. Хооллох танхимаар дамжуулан хоол бэлтгэлийн өрөөнд агаар оруулахыг хориглоно.

Гаднаас оруулах агаарын хэмжээ хооллох танхимын нэг суудалд 20м3/цагаас багагүй байна.

7.15 Мэргэжлийн анхан шатны боловсрол олгох сургалтын байгууллагад дотор агаарын тооцооны температур, агаар солилцооны давтамжийг Хүснэгт 7.1-ийн дагуу, харин мэргэжлийн дунд болон дээд боловсрол олгох сургуульд Хүснэгт 7.2-ын дагуу сонгохыг зөвлөж байна.

Хүснэгт 7.2

Өрөө, тасалгаа	Агаарын тооцооны температур, °C	1 цагт солилцуулах агаар солилцооны давтамж, багагүй	
		оруулах	зайлуулах
Хичээлийн анги, танхим, хорт бодисын ялгаруулалтгүй лаборатори (тааламжгүй үнэр), курсийн болон дипломын төсөл гүйцэтгэх өрөө, уншлагын танхим, хурал, лекцийн танхим, оффисын өрөө	18	2, гэхдээ оруулах агаар нэг суудалд 20м ³ /цагаас багагүй	
Угаалтуур сорох шүүгээ бүхий лаборатори, хортой болон цацраг идэвхт бодис ялгаруулах бусад өрөө, тасалгаа	18	Технологийн даалгаврын дагуу	
Өндөр нарийвчлалтай багаж хэрэгсэл бүхий лаборатори	20		
Сорох шүүгээгүй лабораторийн өрөөний сав угаах өрөө	18	4	6

7.8.16 Уур амьсгалын III ба IV бүсэд байрлах дээд боловсролын байгууллагын 150 ба түүнээс дээш суудалтай хурлын болон хичээлийн анги танхим, өрөөнд хэрэв техник, эдийн засгийн үндэслэл байгаа бол агаарын орчны үзүүлэлтүүдийг хамгийн оновчтой утгаар харин бусад бүсэд БНБД 41-01-11-д тодорхойлсон зөвшөөрөгдөх утгаар сонгоно.

7.8.17 Хооллох танхим болон хүлээн авалтын бусад өрөөнүүдийн агаар сэлгэлтийн систем нийтийн хоолны газрын хоол бэлтгэлийн өрөөний системээс маш сайн тусгаарлагдсан байх ёстой.

7.8.18 Эрүүл ахуйн шаардлага хангасан тохиолдолд томоохон анги танхимд гадна агаартай дотор агаарыг хэсэгчлэн холих (рециркуляцитай) систем төлөвлөж болно.

7.8.19 Кинотеатр, клуб, театрын үзвэрийн танхимд үзэгчид суух бүсэд агаарын шаардлагат үзүүлэлтийг хангахын тулд агаар сэлгэлт эсвэл кондиционерийн системийг Хүснэгт 7.3-д заасан шаардлагатай уялдуулан төлөвлөнө.

Хүснэгт 7.3

Өрөө, тасалгаа	Агаарын тооцооны температур, °C	1 цагт солилцуулах агаар солилцооны давтамж, багагүй	Нэмэлт шаардлага
эстрадтай 800 ба түүнээс дээш суудалтай, тайзтай 600 ба түүнээс дээш суудалтай үзвэрийн танхим	19	тооцоогоор, гэхдээ оруулах агаар нэг үзэгчид 20м ³ /цагаас багагүй	гадна агаарын тооцооны температурын Б параметрийн үед жилийн хүйтний улиралд кинотеатрт* : 14°C; харьцангуй чийглэг 40-45%, дулааны улиралд харьцангуй чийглэг 50-55%,
эстрадтай 800 хүртэл суудалтай, тайзтай	19		жилийн хүйтний улиралд кинотеатрт : 14°C;

600 хүртэл суудалтай үзвэрийн танхим			дулааны улиралд гадна агаарын А параметрийн утгаас 3°C-аас ихгүй өндөр (уур амьсгалын IV бүсэд 200 ба түүнээс дээш суудалтай болон 600 түүнээс дээш суудалтай үзэгчийн танхимыг адил тооцно)
Тайз, тайзны ар, тайзны хажуугийн өрөө	20	-	-
*- үзэгчдийн гадуур хувцсыг өлгөхгүй тохиолдолд.			

7.8.20 200 мянга ба түүнээс дээш номын фонд бүхий номын сангийн уншлагын болон лекцийн танхим, ном хадгалах агуулах, архивын өрөөнд агаарыг эргүүлэн ашиглах холилттой систем төлөвлөж болно.

Гаднаас оруулах агаарын зарцуулалтыг тооцоогоор тодорхойлно. Энэ нь ном хадгалах өрөөний хувьд оруулах агаарын нийт зарцуулалтын 10 хувиас хэтрэхгүй байна. Уншлагын болон хурлын танхимд нэг хүнд өгөх гадна агаарын зарцуулалт 20м³/цагаас багагүй байна.

7.8.21 Номын сангийн ном хадгалах өрөө агаар эргүүлэн ашиглах холилттой системтэй үед гаднаас оруулах агаар болон эргүүлэн ашиглаж буй агаар дах тоос, бичил биетийн агууламжийг эрүүл ахуйн нормоор тогтоосон зөвшөөрөгдөх хязгаарт хүртэл шүүж цэвэрлэсэн байна.

7.8.22 250м² хүртэл талбайтай худалдааны танхимд ердийн агаар сэлгэлтийн систем төлөвлөж болно.

7.8.23 Худалдааны төвийн өрөө, тасалгааны дотор агаарын тооцооны температурыг технологийн даалгаврын дагуу сонгоно. Харин солилцуулах агаарын давтамж нь 1 цагт 1-ээс багагүй байх ёстой.

7.8.24 Спортын болон фитнес, чийрэгжүүлэлтийн танхимд агаарын хөдөлгөөний хурд дараах хэмжээнээс хэтрэхгүй байх ёстой. Үүнд:

-усан бассейны заал (эрүүл мэндийн болон сэлэлтийн анхан шатны сургалтын заал)-д 0.2 м/с-ээс;

-бөхийн, ширээний теннисний, мөсөн гулгуурын ба сэлүүртэй завиар хичээллэх бассейн зэрэг спортын зааланд 0.3 м/с-ээс;

-дээрхээс бусад спортын заал, фитнес-чийрэгжүүлэлтийн болон бассейны бэлтгэлийн зааланд 0.5 м/с-ээс.

7.8.25 Харьцангуй чийглэгийг дараах байдлаар тооцно. Үүнд:

- үзэгчийн суудалгүй спортын заал, фитнес-чийрэгжүүлэлтийн танхим ба бассейны сургалтын зааланд 30-60%;

- бассейны зааланд (мөн сэлүүрт завины) 50-60%;

Харьцангуй чийглэгийн хамгийн бага утгыг Хүснэгт 7.4-д зааснаар жилийн хүйтний улирлын температураар тооцно.

Бассейны заалны хашлага бүтээцийн дулаан техникийн тооцоонд харьцангуй чийглэгийг 67%, температурыг -27°C гэж тооцно.

Барилгад модон бүтээц ашигласан бол тэдгээрийг хэрэглэсэн хэсэгт харьцангуй чийглэг 45%-аас багагүй, температур 35°C –аас ихгүй байх ёстой.

7.9 Агаар солилцоо

7.9.1 Биеийн тамир-спортын заалны дотор агаарын тооцооны температур, солилцуулах агаарын давтамжийг Хүснэгт 7.4-д зааснаар сонгоно.

Хүснэгт 7.4

Өрөө, тасалгаа	Агаарын тооцооны температур ба харьцангуй чийглэг	1 цагт солилцуулах агаар солилцооны давтамж, багагүй
800-аас дээш үзэгчийн суудалтай спортын танхим, үзэгчдэд зориулсан индэр бүхий мөсөн гулгуурын танхим	Гадна агаарын тооцооны температур Б параметрээр үед хүйтний улиралд температур 18°C , харьцангуй чийглэг 30-45%; дулааны улиралд 26°C -аас, харьцангуй чийглэг 60%-иас ихгүй (мөсөн гулгуурын танхимд температур 25°C -аас, харьцангуй чийглэг 55%-иас ихгүй)	тооцоогоор , гэхдээ оруулах агаарын зарцуулалт нэг тамирчинд 80 м ³ /цагаас, нэг үзэгчид 20м ³ /цагаас багагүй
800 ба түүнээс бага үзэгчийн суудалтай индэр бүхий спортын танхим	хүйтний улиралд 18°C	
Үзэгчийн суудалтай болон суудалгүй бассейны танхим (чийрэгжүүлэх болон анхан шатны сэлэлтийн)	Бассейны усны температураас $1-2^{\circ}\text{C}$ өндөр	
Үзэгчийн суудалгүй спортын танхим	$+15^{\circ}\text{C}$	тооцоогоор , гэхдээ оруулах агаарын зарцуулалт нэг тамирчинд 80 м ³ /цагаас, нэг үзэгчид 20м ³ /цагаас багагүй
Усан бассейн, усны бүжгийн сургуулилтын танхим, биеийн тамир чийрэгжүүлэлтийн танхим	$+19^{\circ}\text{C}$	

Спортын заал нь агаар сэлгэлт, кондиционерийн системтэй хосолсон агаарын халаалтын системтэй бол гаднаас оруулах агаарын шаардлагат зарцуулалтыг хангахын тулд агаарыг эргүүлэн ашиглах холилтоо систем хэрэглэхийг зөвшөөрнө. Системийн үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд гаднаас оруулах агаарыг тооцоот хэмжээгээр өгөх зорилгоор агаарыг эргүүлэн ашиглаж болно.

7.9.2 Үзэгчдийн суудал, мөсөн талбайтай нийтийн заалны солилцуулах агаарын тооцоог ашиглалтын үеийн дараах горимуудыг харгалзан гүйцэтгэнэ. Үүнд:

- үзэгчидтэй мөсөн гулгуурын талбай дээрх тэмцээн уралдаан;

- үзэгчидтэй мөс ашиглаагүй тэмцээн уралдаан, үзүүлбэр;
- мөсөн дээрх дасгал сургуулилт, үзэгчидгүй;

Мөсөн талбайгүй спортын ба усан бассейн заал үзэгчдийн суудалтай бол солилцуулах агаарын тооцоог үзэгчидтэй ба үзэгчидгүй гэсэн хоёр горимоор гүйцэтгэнэ.

7.9.3 Ажиллагсдын тоо 300-гаас цөөн захиргаа-оффисын 1-3 давхар барилгын өрөө тасалгаанд агаар сэлгэлтийн ердийн сорох систем төлөвлөхийг зөвшөөрнө.

7.9.4 Жилийн турш тасралтгүй ажилладаг амралт, аялал жуулчлалын барилга, байгууламжид түүнчлэн зун үйл ажиллагаа явуулдаг дор дурдсан барилгад халаалтын систем төлөвлөнө. Үүнд:

- IV бүсээс бусад уур амьсгалын бүсэд байрлах эмнэлгийн болон тусгаарлах өрөө, -хүүхдийн зуслангийн чийрэгжүүлэх өрөөнд

I ба II бүсэд баригдах зун үйл ажиллагаа явуулдаг амралт, аялал жуулчлал, нийтийн байрны сууцны өрөө, хооллох зааланд зураг төслийн даалгаварт тусгагдсан бол халаалтын систем төлөвлөж болно.

7.9.5 Өндөр зэрэглэлийн зочид буудлын (“таван одтой”, “ дөрвөн одтой”) хооллох заал, дулаан ялгаруулалт ихтэй хоол бэлтгэлийн өрөөнд уур амьсгалын бүсээс үл хамааран кондиционерийн систем заавал бусад өрөөнүүдэд агаар сэлгэлтийн оруулах-зайлуулах систем төлөвлөнө.

7.9.6 Эмнэлгийн барилгын өрөө, тасалгааны дотор агаарын температур, цэвэр байдалд тавигдах шаардлага нь эрүүл мэндийн байгууллагын төлөвлөлтийн нормоор тодорхойлогдоно. Эмнэлгийн агаар сэлгэлтийн системийг төлөвлөхдөө агаарын чанарын өндөр шаардлага тавигддаг өрөөнд бага шаардлага тавигддаг өрөөнөөс агаар дамжин орохгүй байх нөхцөлийг хангасан байх ёстой.

Агаарын чанарын өндөр шаардлага тавигддаг мөс засал, эрчимт эмчилгээ, түлэнхийн тасагт гаднаас оруулах агаарын тооцооны зарцуулалт дээр нэмэлтээр агаарыг эргүүлэн ашиглахыг зөвшөөрнө.

Агаарын хөдөлгөөний хурд өвчтөний хэвтэн эмчлүүлэх тасаг, үзлэг оношилгооны өрөөнд 0.15м/с-ээс ихгүй, нэг чиглэлийн агаарын урсгалтай бүсэд 0.24-0.30 м/с байна.

7.9.7 Хөдөөгийн сум, суурин газрын эмнэлгийн өвчтөн хэвтэн эмчлүүлэх тасагт оруулах агаарыг чийгшүүлэхгүй байж болно.

7.9.8 Вокзалын хүлээлгийн танхим, тасалбар зарах өрөөнд агаарын температур, харьцангуй чийглэгийн шаардлагат үзүүлэлтийг хангах зорилгоор агаар сэлгэлтийн ба кондиционерийн систем төлөвлөнө. Энэ тохиолдолд:

- эргүүлэн ашиглаж буй агаарын хэмжээ өрөөнд оруулж буй агаарын 30%-иас ихгүй байх;
- харьцангуй чийглэг 30%-60% хооронд байх;
- агаар оруулах механик системтэй үед нэг хүнд өгөх оруулах агаарын зарцуулалт 30м³/цагаас багагүй байх ёстой.

7.9.9 Агаар оруулах механик системгүй өрөө, тасалгаанд агаар оруулах тохируулгатай гэгээвч эсвэл агаарын хавхалгыг шалнаас 2.0м-ээс багагүй өндөрт суурилуулсан байна.

7.9.10 Хорт бодис ялгардаг өрөө, тасалгаанд агаарыг шууд оруулах бөгөөд агаарын зарцуулалтыг тооцохдоо зайлуулагдаж буй агаарын 90%-ийг тухайн өрөөнөөс, 10%-ийг хонгил, үүдний өрөөнөөс зайлуулагдсан гэж тооцно.

7.9.11 35м²-аас бага талбайтай ажлын байрнаас агаарыг зайлуулахдаа хонгилоор дамжихаар төлөвлөж болно.

7.9.12 Соёл урлаг, үзвэрийн газрын барилга, албан байгууллага, номын сан, архив, спортын байгууламжийн дотор гал унтраах усыг түгээхэд тавигдах шаардлагыг БНБД 21-04-05 болон гадна ба дотор гал унтраах ус хангамжийн системийн галын аюулгүй байдлын нормдзаасан.

7.9.13 Тоос, тоосонцор ялгардаг урлангийн болон бусад өрөө тасалгаанаас сорох шүүгээгээр зайлуулагдах агаарын зарцуулалтыг Хүснэгт 7.5-ийн дагуу сорох шүүгээний тооцоот эзлэхүүн дэх агаарын хөдөлгөөний хурднаас хамааруулан тодорхойлно.

Хүснэгт 7.5

Ажлын бүс дэх хорт бодисын аюулын зэрэг	Сорох шүүгээний тооцоот эзлэхүүн дэх агаарын хөдөлгөөний хурд м/с, багагүй
IV	0.5
III	0.7
I ба II	1.0

Агаарт тэсрэх аюултай бодис ялгаруулдаг ажил гүйцэтгэх үед сорох шүүгээний тооцоот эзлэхүүн дэх агаарын хөдөлгөөний хурдыг 1м/с-ээр тооцно.

7.10 Хог зайлуулах суваг

7.10.1 Хог хаягдал зайлуулах байгууламж нь түүнийг угаах, цэвэрлэх, халдваргүйжүүлэх, усаар шүрших төхөөрөмжөөр тоногдсон байх ёстой.

Хог дамжуулах хоолойгоос барилгын хийц рүү дуу чимээ ба агаар нэвтрүүлдэггүй байх ёстой. Түүнийг байнга хүн байрлах албан өрөө тасалгаагаар дайрч гарахаар төлөвлөж болохгүй.

Хог цуглуулах камерыг байнга хүн байрлах өрөө тасалгааны доор болон зэрэгцээ байрлуулахыг зөвшөөрөхгүй.

7.10.2 Эмнэлгийн болон хоол хүнс, ахуйн хог хаягдлыг цуглуулах боловсруулах системийг эрүүл ахуй, ариун цэврийн холбогдох норм, дүрмийн дагуу төлөвлөнө.

7.10.3 Барилгад хэрэглэж буй материал, эдлэлүүд нь эрүүл ахуй- шаардлага хангасан, холбогдох байгууллагуудаас гаргасан дүгнэлттэй байх ёстой.

8. ИНЖЕНЕРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

8.1 Халаалтын улирлын дулааны эрчим хүчний тооцоот зарцуулалт 1000 ГДж ба түүнээс дээш байдаг барилгад халаалтын дулааны ачааллыг гадна (нар, салхи)

дотор (дулаан ялгаруулалт) орчны нөлөөлөл ижил технологийн бүс болон жигүүрүүдээр тохируулах боломжийг хангах зорилгоор дулааны оруулгын зангилаанд автомат бие даасан дулаан хуваарилах төв (БдДХТ) төлөвлөнө.

Халаалт, агаар сэлгэлт ба хэрэгцээний халуун ус хангамжийн системийн дулаан хангамж нь дулаан хуваарилах төвөөс тусдаа хоолойгоор хангагдах ёстой.

8.2 Зөвхөн тухайн барилгад үйлчлэх БдДХТ-ийг БНБД 41-02-13-ын заалтыг баримтлан төлөвлөнө. БдДХТ-д агаар сэлгэлт, кондиционерийн системийн тоног төхөөрөмж суурилуулахыг зөвшөөрнө. БдДХТ-ийн өрөөг шууд эсвэл 12 м-ээс ихгүй урттай хонгилоор дамжин гадагш гарах боломжтойгоор барилгын гадна ханан талд байрлуулна.

БдДХТ-ийн өрөөний өндөр шалнаас хучилтын доод ирмэг хүртэл 2.2 м-ээс багагүй байна.

Барилгын инженерийн системд өрөөний агаарын температурыг автоматаар эсвэл гараар тохируулах боломжтой төлөвлөгдөнө.

Төвлөрсөн халуун, хүйтэн ус, дулаан, хий, цахилгаан хангамжийн систем бүхий барилгад өөр өөр байгууллага эсвэл өмчлөгчид байгаа бол хэрэглэгчид тус бүрд ус, дулааны тусдаа тоолуур суурилуулж болно.

Барилгын эсвэл бүлэг өрөө, тасалгааны дулаан хангамжийг БНБД 41-01-11 ба галын аюулгүй байдлын шаардлагыг баримтлан төвлөрсөн, бие даасан эсвэл ганцаарчилсан байдлаар төлөвлөж болно.

8.3 Усан халаалтын системийн таслах хаалт, тоноглол бүхий салбар шугамыг дараах өрөөнүүдэд төлөвлөнө:

- хурлын танхим, үйлдвэрлэлийн өрөө бүхий хоолны танхим (400 хүртэл суудалтай хурлын танхимын ба 160 хүртэл суудалтай хоолны танхим нэг дор байрлах бол тусдаа салбар шугам шаардлагагүй), эстрад бүхий үзвэрийн танхим, тайз, вестибюль, фойе, кулуар, бүжгийн танхим, театр, клубийн барилга дах тайз бүхий жижиг танхим;

- 200.0 мянга түүнээс дээш номын фондтой номын сан (уншлагын болон лекцийн танхим, ном хадгалах өрөө);

- жижиглэн худалдааны танхим (ачаа буулгах өрөө, 400м² түүнээс дээш талбайтай худалдааны танхим);

- олон нийтийн барилга сууцны өрөө, тасалгаа;

8.4 1-р давхарт байрлах бүх төрлийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын биеийн тамирын болон хөгжмийн заал, бүлгийн (тоглох) өрөөнд, түүнчлэн тулгуур эрхтний гэмтэлтэй хүүхдийн нийгмийн халамжийн болон эмнэлгийн барилгын унтлагын ба хувцасны өрөөнд шалны халаалт төлөвлөнө. Энд өрөөний дотор агаарын дундаж температурыг 22⁰С байхаар тооцно.

8.5 Театр, клубийн тайзны халаалтын халаах хэрэгслээр радиатор сонгох нь тохиромжтой. Энэ тохиолдолд халаах хэрэгслийг тайзны арын хана эсвэл шатны хэсэгт 0.5 м-ээс ихгүй өндөрт суурилуулна.

8.6 Сургуулийн хичээлийн анги, танхимаас агаарыг зайлуулахдаа амралтын болон ариун цэврийн өрөөгөөр дамжуулан түүнчлэн БНБД 41-01-11-ийг баримтлан гадна шилтэй хэсгээр шүүрэлтээр зайлуулахаар тооцно.

Хичээлийн танхим төвлөрсөн бус оролттой, механик агаар оруулах системтэй үед агаар зайлуулах ердийн системийг 1 цагт нэг ба түүнээс давтамжтайгаар агаарыг сэлгэхээр төлөвлөнө.

Агаарын халаалтын системтэй бол хичээлийн танхимд агаар зайлуулах суваг төлөвлөхгүй.

8.7 Сургуулийн барилгад агаар сэлгэлтийн системтэй хослуулан агаарын халаалт төлөвлөсөн бол өрөө, тасалгаанд ажлын цагаар температурыг тооцооны утгад, харьцангуй чийглэгийг 40-60% хязгаарт, шөнийн цагт температурыг 15⁰С-ээс багагүй байлгах нөхцөлийг хангах автомат удирдлага, хяналтын систем төлөвлөнө.

8.8 200 хүртэлх хүүхэдтэй сургуулийн барилгад механик агаар оруулах систем төлөвлөхгүй байж болно.

8.9 Үзвэрийн танхим, клуб

8.9.1 Агаар оруулах, зайлуулах системийг үзвэрийн танхим, клуб, тайзны өрөө (эстрадтай), захиргаа- аж ахуйн өрөө, урлан болон агуулахад тусад нь төлөвлөнө.

Тасралтгүй ажиллагаатай кино театр, 375 хүртэл хүний багтаамжтай клуб ба цэнгээний газарт дээрхтэй адил тусдаа систем төлөвлөх шаардлагагүй.

8.9.2 Ховор ном, гар бичмэл хадгалах танхим, түүнчлэн 1 сая ба түүнээс их номын фонд бүхий номын сангийн архив, мөн I ангиллын номын сангийн архивд кондиционерийн систем төлөвлөнө.

8.9.3 Үнэтэй, ховор бичиг баримт хадгалах зориулалт бүхий архивын өрөөнд 3-р зэргийн кондиционерийн систем төлөвлөнө.

8.9.4 Уншлагын болон лекцийн танхим, 200.0 мянга ба түүнээс дээш эрдэм шинжилгээний номын фонд бүхий ном хадгалах өрөөнд агаар оруулах эсвэл кондиционерийн системтэй хослуулан агаарын халаалтын систем төлөвлөж болно.

8.9.5 300.0 мянга ба түүнээс дээш ном хадгалах өрөө, архивд агаар оруулах эсвэл кондиционерийн системтэй хослуулан агаарын халаалтын бусад өрөө, тасалгаанд усан халаалтын систем төлөвлөнө.

8.9.6 200.0 мянга ба түүнээс дээш номын фондтой номын сангийн ном хадгалах өрөө, уншлагын болон лекцийн танхимд агаар оруулах тусдаа систем төлөвлөнө.

8.9.7 50.0 мянга хүртэл номын фондтой, уншлагын танхим номын фонд, уншигчдад үйлчлэх хэсэг нэг дор хамт байрладаг нийтийн номын санд, 300.0 мянга хүртэл ном хадгалах багтаамжтай архивд нэгээс багагүй давтамжтайгаар агаар солилцуулах ердийн агаар сэлгэлтийн систем төлөвлөнө.

8.9.8 Уншлагын болон лекцийн танхим, ном хадгалах өрөөнд ердийн агаар зайлуулах систем төлөвлөж болно.

8.9.9 Хурлын болон нийтийн хоолны танхим, киноаппарат, аккумуляторын өрөөнөөс бусад өрөөнд нэг нэгдсэн агаар оруулах систем төлөвлөж болно.

8.9.10 Механик агаар оруулах системгүй өрөөнд тохируулгатай салхивч, эсвэл шалнаас 2 м-ээс багагүй өндөрт байрлах агаарын хавхлахын тусламжтай өрөөнд агаар оруулахаар төлөвлөнө.

8.9.11 Агаар зайлуулах бие даасан системийг дараах өрөөнүүдэд төлөвлөнө:

- ариун цэврийн болон тамхи татах өрөө;

- нийтийн хоолны газрын өрөөнүүд;
- үйлдвэрлэл, техникийн зориулалттай өрөө болон агуулахад;
- лаборатори, хичээлийн болон бусад танхимд БНБД 41-01-11 шаардлагыг баримтлан төлөвлөнө.

Нийтийн хоолны байгууллагын байгууламж ба тоног төхөөрөмж, сорох системээс хаягдах агаар нь орон сууц, түүнчлэн бусад зориулалтын өрөө, байранд байгаа хүний орчин нөхцөлд нөлөөлөхгүй байх ёстой. Энэ тохиолдолд агааржуулах системийг тусад нь төлөвлөнө.

8.9.12 Амралт, сувиллын газрын унтлагын өрөөнд агаар зайлуулах ердийн систем төлөвлөнө.

Уур амьсгалын IV бүсэд баригдах амралтын газрын сууцны өрөөнд механик агаар зайлуулах систем төлөвлөнө.

8.10 Ус хангамж, ариутгах татуурга

8.10.1 Ариун цэврийн өрөө бүхий сууцны болон зочны өрөөнөөс агаар зайлуулах сараалжийг ариун цэврийн өрөөний доод хэсэгт байрлуулна.

8.10.2 Ариун цэврийн төхөөрөмжид ирэх усны зөвшөөрөгдөх даралт, ус болон цахилгаан энергийн үр ашигтай хэрэглээг хангах зорилгоор:

- хувьсах зарцуулалтын насос;
- бүсчлээгүй ус хангамжийн системд давхар бүрд даралт тохируулагч төлөвлөнө.

8.10.3 Унд-ахуй болон ахуй-галын ус хангамжийн системийн хамгийн доод түвшинд байрлах ариун цэврийн төхөөрөмж дээрх гидростатик даралт 4 атм-ээс ихгүй байх ёстой. Гал унтраах үед ахуй-галын ус хангамжийн системийн хамгийн доод төвшинд байрлах ариун цэврийн төхөөрөмж дээрх гидростатик даралтыг 6 атм хүртэл нэмэгдүүлэхийг зөвшөөрнө.

8.10.4 Салангид гал унтраах системийн хамгийн доод түвшинд байрлах галын кран дээрх гидростатик даралт, мөн түүнчлэн гал унтраах үед дээд давхрын унд-ахуйн усны зарцуулалт /дээгүүр түгээлттэй бүдүүвч/ дайран өнгөрөх галын босоо шугамд 9 атм-ээс ихгүй байх ёстой.

8.10.5 Үзвэр, соёлын газар, номын сан, архив, спортын зориулалттай барилгын дотор гал унтраах ус түгээгүүрт БНБД 21-04-05 болонгадна ба дотор гал унтраах ус хангамжийн системийн галын аюулгүй байдлын норматив шаардлагууд тавигдана.

8.10.6 Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа объект, суудлын тоо харгалзахгүйгээр бүх төрлийн нийтийн хоолны газарт тос баригч төлөвлөнө .

8.10.6 а. Олон нийтийн барилга, байгууламжид саарал усыг ашиглах системийг зургийн даалгаврын дагуу төлөвлөнө.

8.11 Хог хаягдал

8.11.1 Олон нийтийн барилгад хог хаягдал цэвэрлэх, тоос сорох систем, хог хаягдлыг түр хадгалах, түүнийг ачуулах боломжийг заавал хангасан байна.

Олон нийтийн барилга болон цогцолборт хог хаягдал зайлуулах хийн тээврийн системийг ашиглалтын үеийн техник эдийн засгийн нөхцөлтэй уялдуулан зургийн даалгаврын дагуу төлөвлөнө.

Барилгаас хог хаягдал зайлуулах хэрэгсэл нь барилга баригдах суурин газрын хог хаягдал зайлуулах системтэй уялдаж байх ёстой.

8.11.2 Барилгын хог, хаягдал дамжуулах хоолойг дор дурдсан барилгуудад төлөвлөнө. (хог хаягдал тээвэрлэх хийн системгүй) Үүнд:

- 3 ба түүнээс дээш давхар их, дээд сургууль, зочид буудал, 100 ба түүнээс дээш ортой дэн буудал (машинтай аялагчид зориулсан буудал);

- Дээрхээс бусад зориулалтын 5 ба түүнээс дээш давхартай барилгууд;

Олон нийтийн барилгаас гарах ахуйн хог хаягдлыг хадгалах, цуглуулах, дахин боловсруулах болон эргүүлэн ашиглах зорилгоор ялгах, мөн эх үүсвэр дээр нь боловсруулахад MNS BS 5906-г баримтална.

Дээр зааснаас бусад олон нийтийн барилгуудад хог хаягдал зайлуулах системийг зургийн даалгаврын дагуу шийднэ.

Одоо байгаа барилгад нэмэлтээр мансард хийвэл хог хаягдал зайлуулах системийг өөрчлөхгүй байхыг зөвшөөрнө.

Хог хаягдал хадгалах камерт хог тээвэрлэх машин нэвтрэх боломжтойгоор төлөвлөнө. Хэрвээ хог тээвэрлэх машин камерт нэвтрэх боломжгүй бол хог хаягдал хадгалах талбай төлөвлөж өгнө.

Хог хаягдал дамжуулах хоолой төлөвлөгдөөгүй барилгад хог хаягдал хадгалах камер буюу талбай төлөвлөнө.

8.12 Хог , тоос зайлуулалт

8.12.1 Дор дурдсан барилгуудад төвлөрсөн буюу хосолмол хийн тоос сорох систем тавина. Үүнд:

Театр, концертын заал, музей;

Уншлагын болон лекцийн танхим, 200 мянга ба түүнээс дээш тооны ном хадгалахномын сан;

худалдааны 6500 м²ба түүнээс дээш талбайтай дэлгүүр ;

500 ба түүнээс дээш ортой зочид буудал, сувиллын газар, амралт ба аялал жуулчлалын газар, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага;

эрүүл ахуйн шаардлага өндөр тавигддаг тусгай зориулалтын барилга(эмнэлгийн байгууллагын зураг төсөл боловсруулах даалгавар).

Бусад барилгуудад төвлөрсөн буюу хосолмол хийн тоос сорох систем төлөвлөх талаар зураг төсөл боловсруулах даалгаварт тусгана.

8.12.2 Хосолмол хийн тоос сорох системийн нэг хавхлахын үйлчлэх радиус 50 м-ээс ихгүй байна.

8.12.3 Төвлөрсөн буюу хосолмол хийн тоос сорох системд тоосыг цэвэрлэх шүүлтүүрийн камерыг зураг төслийн даалгаврын дагуу хийнэ.

8.12.4 Байгууламжуудын хийцэл нь (дулаан тусгаарлагч, агааржуулалтын хоолой, хөндий хоосон газрууд, барилгын хийцээр нэвтрэх хоолойн битүүмжлэл гэх мэт) мэрэгч амьтнаас хамгаалагдсан байна.

9. Эдэлгээний хугацаа болон засвар үйлчилгээ

9.1 Ашиглалтын дүрмийн дагуу техникийн үзлэг, үйлчилгээг системтэйгээр гүйцэтгэх нөхцөлд барилгын даацын бүтээцүүд нь төлөвлөлтийн үед тодорхойлсон ашиглалтын хугацааны туршид бат бөх, тогтвортой байдлаа хадгалж байх ёстойг зураг төсөлд заавал тооцсон байна.

9.2 Барилгын бүтээц, эдлэхүүн, материалууд нь БНБД 20-02-11-д зааснаар орчны чийг, нам болон өндөр температур, идэмхий үйлчлэл болон бусад сөрөг хүчин зүйлүүдийн нөлөөлөлд тэсвэртэй материалаар хийгдсэн эсвэл хамгаалагдсан байх ёстой.

9.3 Барилгын даацын болон хашлага бүтээцийн гүнд бороо, цас, хөрсний ус нэвтрэх, түүнчлэн хашлага бүтээцэд чийг үүсэхээс хамгаалах арга хэмжээ эсвэл агаарын үе, битүү орон зайн агаар солилцуулах төхөөрөмжийг заавал төлөвлөсөн байна.

Холбогдох норм, дүрмийн дагуу шаардлагатай хамгаалах хийц, бүрээсийг хэрэглэх ёстой.

9.4 Барилгын угсармал хийцүүдийн уулзвар зангилаа болон олон үет бүтээцүүд температурын хэв гажилт, буурь суурийн жигд бус суулт, ашиглалтын үеийн бусад үйлчлэлээс үүсэх хүчдэлд хэвийн ажиллахаар тооцоологдсон байвал зохино.

Уулзвар холбооснуудад хийгдсэн нягтруулагч, битүүмжлэгч материалууд нь чийг болон хасах хэмийн үйлчлэлийн үед уян хатан, барьцалдах чанараа хадгалахын зэрэгцээ хэт ягаан туяанд тогтвортой байх ёстой. Битүүмжлэгч материал нь тэдгээрийг хэрэглэсэн хэсэгт хийгдсэн хамгаалалтын болон хамгаалалт-гоёл чимэглэлийн бүрээсний материалтай зохицож байх ёстой.

9.5 Барилгын инженерийн системийн тоног төхөөрөмж, тоноглол, хэрэгсэл тэдгээрийн холболтод болон барилгын даацын бүтээцэд үзлэг, засвар үйлчилгээ хийх боломжийг хангасан байх ёстой .

А Хавсралт (лавлагаа)

Олон нийтийн зориулалттай барилга, байгууламж , өрөө, тэдгээрийн үүрэг, зориулалт болон хэв шинжийн үндсэн бүлгийн жагсаалт

<p>А* Хүн амд үйлчилгээ үзүүлэх зориулалттай объектын барилга, байгууламж</p>
<p>1 Сургалт, хүмүүжлийн зориулалттай барилга, өрөө, тасалгаа</p>
<p>1. 1.1 Боловсрол олгох ба, хүний нөөцийн байгууллага :</p> <p>1.1.1 сургуулийн өмнөх боловсролын байгууллага</p> <p>1.1.2 Ерөнхий боловсролын байгууллага</p> <p>1.1.3 Мэрэгжлийн боловсролын байгууллага: дунд, дээд, давтан сургалтын</p> <p>1.2 Сургалтын бус байгууллага (сурагч, залууст зориулсан)</p> <p>1.3.Тусгай газар (аэроклуб, автосургууль, батлан хамгаалахын сургуульгм.)</p> <p>1.4 Дасан зохицох (адаптивный) спортын төв ба спорт-дасан зохицолтын сургууль</p>
<p>2 Хүн амын эрүүлийг хамгаалах ба нийгмийн үйлчилгээний газрын барилга, өрөө тасалгаа</p>
<p>2.1* Эрүүл мэндийн байгууллага:</p> <p>2.1.1 Хэвтүүлж эмчлэх эмчилгээний байгууллага ба, эрүүл мэндийн төв гм.</p> <p>2.1.2* Амбулатори-поликлиникийн байгууллага</p> <p>2.1.3 Эмийн сан</p> <p>2.1.4 Нөхөн сэргээх, сэргээн засах эмчилгээний байгууллага, түүний дотор хүүхдэд зориулсан</p> <p>2.1.5 Цус сэлбэх ба, түргэн тусламжийн станц гм.</p> <p>2.1.6 Сувилал , рашаан сувилалын байгууллага</p> <p>2.2 Хүн амын нийгмийн үйлчилгээний газар:</p> <p>2.2.1 Гэрийн нөхцөлд эмнэлэгийн тусламж үзүүлэх газар</p> <p>2.2.2 Хэвтүүлж асарч сувилах буюу байнга байрлуулан асрах <i>нийгмийн үйлчилгээний газар</i>, /түүний дотор өндөр настан ба хөгжлийн бэрхшээлтэй том хүн ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд/</p>
<p>3 Хүн амын сервисийн үйлчилгээний барилга, өрөө тасалгаа</p>
<p>3.1 Жижиглэн болон бөөний худалдааны , түүнчлэн худалдаа -цэнгээний газар</p> <p>3.2 Хоолны газар (задгай ба дотор үйлчилдэг сүлжээ)</p> <p>3.3 Хүн амд ахуйн ба нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх үйлдвэрлэлийн бус газрууд:</p> <p>3.3.1 Хүн амын ахуйн үйлчилгээний газар</p> <p>3.3.2 Хүн амд шууд үйлчилгээ үзүүлдэг нийтийн аж ахуйн байгууллага</p> <p>3.3.3 Иргэний ёс заншил, зан үйлийн үйл ажиллагаагаа тэмдэглэхэд үйлчлэх байгууллага</p> <p>3.4 Хүн амд үйлчилгээ шууд үзүүлэхэд чиглэгдсэн холбооны байгууллага</p> <p>3.5 Хүн амд үйлчилгээ шууд үзүүлэхэд чиглэгдсэн тээврийн байгууллага:</p> <p>3.5.1 Бүх төрлийн тээврийн буудал</p> <p>3.5.2 Зорчин явагчдад үйлчилгээ үзүүлэх тээвэр, аялал жуулчлалын агентлагууд</p> <p>3.6 Ариун цэвэр, ахуйн зориулалттай байгууламж, барилга, өрөө тасалгаа</p>
<p>4Хүн амын соёл-амралтын ба шашны ёс заншлын үйл ажиллагаанд зориулсан байгууламж, барилга, өрөө тасалгаа</p>
<p>4.1Биеийн тамир, спорт,ба биеийн тамир-чөлөөт цагийг хослуулан ашиглахад зориулсан объектууд :</p> <p>4.1.1 Задгай байгууламж</p> <p>4.1.2 Спортын зориулалттай битүү байгууламж (заал, манежь, бассейн г.м.)</p>

<p>4.1.3 Морин спортын цогцолбор,биеийн тамир-чөлөөт цагийг хослуулан ашиглахад зориулсан цогцолбор болон усан парк / аквапарк /</p> <p>4.2 Соёл, гэгээрлийн ба шашны байгууллагад зориулсан барилга, өрөө тасалгаа:</p> <p>4.2.1 Номын сан, уншлагын заал, медиатек^{HT}</p> <p>4.2.2 Музей,үзэсгэлэн, океанариум^{HT} г.м.</p> <p>4.2.3 Шашны байгууллага, сүм хийд</p> <p>4.3 Үзвэрийн ба чөлөөт цаг- хөгжөөн цэнгээний газар:</p> <p>4.3.1 Үзвэрийн газар (театр, кинотеатр, концертийн заал, цирк, дельфинари^{HT} г.м..)</p> <p>4.3.2 Клуб, зугаа цэнгээний газрууд, үүний дотор ялангуяа бүжгийн цогцолбор</p>
<p>5 Түр байрлахад зориулсан барилга, өрөө тасалгаа</p>
<p>5.1 Зочид буудал, , мотель, апартамент^{HT} г.м.</p> <p>5.2 Аялал жуулчлал, амралтын газар (өндөр настаны/ пансионат, жуулчны бааз, байнгын ба улирлын ажиллагаатай зуслан , ялангуяа хүүхэд залуучуудад зориулсан г.м.)</p> <p>5.3 Сургалтын газрын нийтийн байр, ба дотуур байрны унтлагын хэсэг /корпус</p>
<p>Б Төрийн ба олон нийтийн газраас үйлчилгээ үзүүлэх газрын барилга</p>
<p>1* Засаг захиргааны барилга</p>
<p>1.1* Олон нийтэд үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллагын барилга (нийгмийн даатгалын орон нутгийн байгууллага, нэг цэгээс олон төрөл үйлчилгээ үзүүлэх төв)</p> <p>1.2* “Пүүс албан газар, аж ахуйн нэгж болон пүүсийн салбар, агентлагийн г.м. - ийн удирдах байгууллага</p> <p>1.3* Архив, үнэт зүйлс хадгамжийн газар / депозитари^{HT} /</p>
<p>2 Бусад албан газрын барилга</p>
<p>2.1 Зээл- санхүү, даатгал, банк</p> <p>2.2 Шүүх, прокурор, шүүх-нотратын байгууллага</p> <p>2.4 Хүн амын нийгмийн хамгаалын байгууллага (хамгаалалтын алба / нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн байгууллага, хөдөлмөрийн бирж г.м.)</p>
<p>3 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн байгууллагын барилга</p>
<p>3.1 Эрдэм шинжилгээ,судалгааны байгууллага (тусгай том байгууламж шаардаггүй)</p> <p>3.2 зураг төсөл, зохион бүтээх байгууллага</p> <p>3.3 Хэвлэлийн редакци , мэдээллийн байгууллага (хэвлэх үйлдвэр энд орохгүй)</p>
<p>Тайлбар:</p> <p>1 Энэхүү хавсралт нь энд заасан төрлийн байгууллагаас гадна энд дурдаагүй ижил төстэй үүрэг зориулалтын шинээр барих барилга, өрөө тасалгаанд нэгэн адил хамаатай.</p> <p>2 Энд нэрлэсэн төрөл бүрийн зориулалттай өрөөний бүлгүүд нь орон сууц, үйлдвэрлэл ба бусад төрлийн түүнчлэн олон чиг үүрэгтэй цогцолборын бүрэлдүүнд орж болно.</p>

Б Хавсралт (заавал мөрдөнө)

Олон нийтийн барилга байгууламжийн нийт, ашигтай ба тооцооны талбай, барилгын эзэлхүүн, барилгажих талбай, барилгын давхарын тоо тооцох дүрэм.

Барилгын нийт, ашигтай, тооцооны талбай

Б.1.1 Тухайн барилгын бүхий л давхруудын талбайн нийлбэрээр уг **барилгын нийт** (техникийн, мансардын, хаяавчийн болон газар доорхи давхруудын талбайг оруулсан) **талбайг** тогтооно.

Нийт талбайн дүнд антресоль^{HT}; галерей^{HT}; үзмэрийн ба бусад заалуудын тагт; веранд^{HT}; гадна талаас нь шиллэсэн лоож; мөн бусад барилга руу орох хүзүүвчийн талбай нэгэн адил хамрагдана. Бас таазны өндрөөс шалтгаалахгүйгээр бүхий л өрөөнүүдийн (тухайлбал техникийн өрөөний) талбай энд хамрагдана.

Олон давхрын өрөөг нэгтгэн нэгэн өндөр таазтай (многосветный^{HT}) болгосон өрөө, танхимын талбай, түүнчлэн 1,5 метрээс илүү өргөнтэй шатны маршуудын дундах орон зай ба хучилтад гаргасан 15 м²-ээс том нээлхий зайнууд -(проемы^{HT}) мөн лифтийн хийгээд бусад зориулалтын сувгийн (шахт^{HT}) талбайг зөвхөн нэг л давхарын хүрээнд тооцон барилгын нийт талбайд оруулна.

Үүнээс гадна галалгаагүй өрөө тасалгаа (ашигладаг дээвэр, гадна талын задгай галерей, задгай лоож, гадна талын үүдний гонх зэргийг багтаасан) талбайг барилгын нийт талбайд багтаах ба гэхдээ энэ талбайн хэмжээг тусгай мөрөнд бичин зааж өгсөн байна.

Харин хаяавчийн давхар дахь хийцийн элементүүдийн дунд газарт булагдсан орон зайг барилгын нийт талбайд оруулахгүй.

Б.1.2 Барилгын давхрын талбайг гадна хануудын дотор талын өнгөлгөөтэй гадаргуугийн (шалны хөвөөгүй) хоорондын зайг шалны түвшинд хэмжиж тогтооно.

Налуу ханатай давхарын талбайг шалны түвшинд хэмжиж гаргана.

Мансардын давхарын талбайг гадна хана ба мансардын ханын хоорондох хэмжээсээр Г.5-д заасантай нийцүүлэн тооцоолно.

Б.2 Барилгын ашигтай талбайг шатны хонгил, лифтний хонгил, барилга доторхи ил шат, пандус^{HT}, болон инженерийн шугам сүлжээний өрнөөний талбайгаас бусад тухайн барилгын дотор байгаа бүхий л өрөөнүүд, түүнчлэн тагт, заалны антресол, фойе зэргийн талбайн нийлбэрээр тодорхойлоно.

Б.3 Тооцооны талбай нь бүх өрөөний талбайн нийлбэрээс доор заасан өрөөний талбайг хассантай тэнцүү байна. Хасах талбай :

Хонгил гонх, дамжих хүзүүвч нэг блокоос нөгөө блокруу орох шатны хонгил, доторхи ил шат, пандусны талбай;

Лифтний хонгил;

Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж байрлуулахад зориулсан өрөө тасалгаа орон зай;

түүнчлэн 1,5 метрээс бага өндөртэй налуу бүрхүүл доорхи орон зайг тооцооны талбайд хамааруулахгүй.

Б.4 Барилгын нийт болон ашигтай талбай хэмжээнд мөнх цэвдэгтэй хөрсөнд барьсан барилгын нэгдүгээр давхарын шалан доогуур салхи оруулах хөндий зай, бүтээцийн доошоо ил гарсан хэсгээс шал хүртэл 1,8 метрээс бага өндөртэй техникийн давхрын мөн дээвэр дээрх техникийн өрөө, гадна талын тагтны, гадна

задгай шатны, налуу замын талбай, хаявчийн давхрын хийцийн дунд шороонд булагдсан орон зайг энд оруулахгүй.

Б.5 Өрөөний талбайг тодорхойлохдоо хамар хана, хашлага бүтээцийн гадаргуугийн хоорондын зайг шалны /хөвөөг оруулаагүй/ түвшинд хэмжин тодорхойлно. Адрын давхрын өрөөний талбайг таазны налуутай нь уялдуулан, хэрэв налуугийн өнцөг нь 30° бол өндөрийг нь 1.5 м, харин 45° бол өндөрийг нь 1.1 м, мөн 60° ба түүнээс дээш бол 0.5 метр тус тус байхаар тооцох бөгөөд гэхдээ 0.7 гэсэн бууруулах итгэлцүүр /коэффициент /ашиглан тогтооно.

Барилгын эзэлхүүн

Б.6 Барилгын нийт эзэлхүүнийг барилгын 0.00 түвшнээс /тэмдэгт/ дээшхи газар дээрхи хэсгийн болон энэ түвшнээс доошхи (газар доорхи хэсэг) хэсгийн хамгийн эцсийн давхрын эзэлхүүний нийлбэрээр тогтооно.

Харин барилгын газраас дээшхи хэсгийн эзэлхүүнийг барилгын гадна ханын гадна талаар тооцсон талбайг барилгын дээврийн налуугийн дундаж түвшин хүртлэх өндрөөр үржүүлж бодно. Мөн газраас доошхи хэсгийн эзэлхүүнийг тооцохдоо зоорийн давхрын гадна ханын гадна талаар тооцсон талбайг зоорийн хамгийн доод давхрын шалны түвшин хүртэлх өндрөөр үржүүлж тооцох ба ингэхдээ барилга доогуурхи салхижуулалтын үүрэг гүйцэтгэх хөндий, шалан дорх сувгийг оруулж тооцохгүй.

Барилгын газар дээрхи болон газар доорхи хэсгийн эзэлхүүнийг гэрэлтүүлгийн фонарь-, купол зэргийн хашлага бүтээцийг оролцуулсан гадна ханын гадаргуугийн хязгаарын хүрээнд барилгын газар дээрхи ба доорхи хэсгийг цэвэр шалны түвшингээс эхлэн тодорхойлоно. Харин барилгын их биеэс гадагш илүү гарсан тагт, саравч, террас, архитектурын гоёл чимэглэл ба багана дам нуруу зэрэг хийцийн элемент, барилгын доогуур автомашин явж өнгөрөх арк, барилгын багана - тулаасан дээр өргөгдсөн орон зайг оруулж тооцохгүй.

Харин энэ тооцоонд тагт, саравч, террас, архитектурын чимэглэл тагт зэрэг барилгын их биеээс гадагш илүү гарсан деталь хэсэг, гарц замын эзэлхүүн, газраас хөндийлж тулгуур дээр барьсан барилгын доорхи ба түүнчлэн мөнх цэвдэгтэй хөрсөнд барьсан барилгын нэг дүгээр давхарын шалны доогуур салхи оруулах хөндий зай, шалан доорхи сувгийн орон зай хамаарагдахгүй.

Орон сууцны барилгын газар доорхи хэсгийн эзэлхүүнийг түүний хамгийн доод давхарын цэвэр шалны түвшин хүртлэх хэмжээгээр тодорхойлно.

Барилгажих талбай.

Б.7 Тухайн барилгад олгогдсон газрын барилгажуулах талбайн хэмжээг тогтоохдоо уг барилгын их биеээс илүү гарсан хэсгийг (үүдний талбай ба шат, веранд, террас^{HT}, приямок) дайруулан хаявчийн давхрын түвшингээр хийсэн хөндлөн огтлолоор үүссэн хэвтээ проекцийн план (байгуулалтын) зургийн гадна хүрээгээр хэмжин тодорхойлно.

Тулгуур дээр барьсан барилгын доор үүссэн хөндийн зай (талбай), байшинг нэвт гарсан гарц, 4,5 метрээс доош өндөрт барилгын ханын гадаргуугаас гадагш консолоор гарсан барилгын хэсгийн талбайг энд оруулна. Харин өндрийн хэмжээ 4,5 метрээс дээш байгаа тохиолдолд түүний талбайг барилгажуулах талбайн хэмжээнд хамааруулахгүй.

Барилгажих талбайн нийт хэмжээнд барилгын проекцийн гадна захын зураас /абрис/-аас давж гарсан газар доорхи хэсгийн талбайг оруулан тооцно.

Давхаржилтын тоо

Б.8 Барилгын давхарын тоог тогтоохдоо газар дээрхи бүх давхар, түүний дотор техникийн , мансардын давхар болон мөн түүнчлэн хучилтын дээд ирмэг нь газрын төлөвлөлтийн дундаж түвшнээс дээш 2 метрээс багагүй өндөр байгаа суурийн давхрыг оруулан тооцно

Газар дээрхи давхрын тоонд шалны доорхи техникийн хөндий зайг түүний өндрөөс үл хамааруулан, мөн 1,8 метрээс намхан давхар хоорондын ба дээвэр дэх техникийн хөндий зэргийг оруулахгүй.

Барилгын давхарын тоо тодорхойлоход газар дээрх, хаяавчийн, газар доорхи болон техникийн , мөн мансардын зэрэг бүх давхрыг хамааруулна.

Тайлбар: Барилгын дээвэр дээрхи шатны хонгилоос гарах гарц, цахилгаан шатны машины өрөө, салхивчийн өрөө зэргийг давхрын тоонд оруулахгүй.

Барилга нь өөр өөр давхартай хэсгүүдээс бүрдсэн , эсвэл түүнийг налуу газар байрлуулснаас давхрын тоо нь өөр өөр /шаталсан/ байх тохиолдолд тэдгээрийн давхрын тоог хэсэг нэг бүрээр тооцно.

Барилгыг хэвгий газар байрлуулснаас түүний давхрын тоог Б* Хавсралтын дагуу тогтоох боломжгүй байвал тухайн хэсэгт хамаарагдах төлөвлөлтийн бүс нэг бүрээр давхарын тоог тодорхойлоно. Үүний тулд тухайн давхар ба өрөөний төлөвлөлтийн схем ба өрөөний гадна ханын байршил хаяавчтайгаа хэрхэн нийлж байгаа болон өрөөний байгалийн гэрэлтүүлгийн параметрийг нягтлан үзэсний үндсэн дээр тодорхойлоно.

Бүтээцлэлийн болон бусад чиг үүргийн зориулалтын тооцоонд зориулан давхрын тоог тогтоохдоо холбогдох норматив баримт бичгээр тогтоосон техникийн давхар нь эдгээр тооцооноос онцлогтой эсэхийг харгалзан үзнэ.

Лифт

Лифтний тоо тооцохдоо дээд давхарт байрласан адар дахь техникийн хөндий үл харгалзана. Барилгын дунд хэсэгт байрласан техникийн давхарыг лифтийн өгсөх өндөрт тооцно.

Налуу газар байрласан барилгын газрын төлөвлөлтийн хамгийн намхан түвшинээс дээш шалны түвшин нь байгаа давхрыг түүнийг **газар дээрхи эхний давхар гэж үзнэ.**

Газрын төлөвлөлтийн түвшин нь гадна ханатай нийлсэн цэвэр шалны^{HT} түвшингээс дээр байвал тэдгээр өрөө тасалгааг доошоо суусан гэж нэрлэнэ.

Барилгын газар доорх хэсэг аль хир гүнд суусныг баганан ба туузан суурийн буюу суурийн хавтангийн ул, гадсан суурийн үзүүр хүртэлх түвшин ба газрын төлөвлөлтийн түвшний хоорондын зөрүүгээр тодорхойлно.

Барилгыг налуу газарт байрлуулснаас болон суурийг шатлуулж, өөр өөр түвшинд төлөвлөсөн үед дээр тэмдэглэсэн доошоо суусан түвшинг гадна хана, газрын түвшинтэй харьцсан хэсэг дэхь тэмдэгтийн хамгийн их зөрүүгээр тодорхойлно.

Б 9 Дэлгүүрийн худалдааны талбайг (дэлгүүр- агуулахаас бусад) худалдааны заалаас гадна захиалга авах, болон цайлах өрөө, худалдан авагчдад бусад нэмэлт үйлчилгээ үзүүлэх хэсгийн талбайн нийлбэрээр тооцож тодорхойлно.

В Хавсралт. ОНБ доторхи үйл ажиллагааг хаяавчийн ба газар доорхи давхарт болон барилгын стилобаттай хэсэгт явуулж болох өрөөний жагсаалт

В.1 Газар доорхи давхарт

Д.1.1 Бойлер, цэвэр, бохир усны насос, салхивчийн камер, агаар сэлгэлт, кондиционерийн системийн төхөөрөмжийн камер; түүний удирдлагын узель, барилгын техникийн тоног төхөөрөмж ба инженерийн удирдлагын өрөө, лифтийн машины, өрөө, гал унтраах системийн тоног төхөөрөмж суурилуулах өрөө.

Д.1.2 Авто зогсоол, / БНБД 21-05 ба MNS 5342:2007 - ын шаардлагад нийцүүлсэн /

В.2 Газар доорхи эхний буюу түүнээс доошхи давхарт. Бүх төрлийн барилгад хамаарна.

В.2.1 Газар доорхи давхарт байрлуулахыг зөвшөөрөх / холбогдох норматив баримт бичгийн дагуу/ бүх өрөөнүүд:

В.2.2 Үүдний танхим ба хувцасны өлгүүр, насанд хүрэгсдийн ариун цэврийн, угаагуурын ,тамхи татах , хувцас солих, шүршүүрийн өрөөд болон шарлагын өрөө.

Тайлбар: СӨББ, хүүхдэд нэмэлт боловсрол олгох байгууллагын үүдний өрөө, хувцасны өлгүүр төлөвлөлт энэ заалтад хамаарахгүй.

В.2.3 Үйлчилгээний ажилчид, дасгалжуулагч, зааварлагчийн тасалгаа, амралтын ба хооллох өрөө гм

В.2.4 300 хүртэл суудалт лекцийн, үзмэрийн, нийтлэг үйл ажиллагааны заал, конференц-заал.

Тайлбар: СӨББ, хүүхдэд нэмэлт боловсрол олгох байгууллагын өрөө төлөвлөлт энэ заалтад хамаарахгүй

В.2.5 Номын хадгаламж, архивын хадгаламж, эмнэлэгийн архив гм.

В.2.6 СП 4.13130- (Гал түймрээс хамгаалах систем.Хамгаалах объектын гал тэсвэршилтийг хангахнь,)- д шаардлагатай нийцсэн агуулахын ба эд зүйлс, хогшил хадгалах өрөө тасалгаа,

В.2.7 Ачих, буулгах, савлах өрөө, төрөл бүрийн байгууллага, төрөл бүрийн албан газрын байгууллагын экспедиц (төрөл бүрийн үйлчилгээнд эд зүйл илгээх, буцаан олгох цэг. ж-нь: шуудан, илгээмж, угаалга, хими цэвэрлэгээ, засвар үйлчилгээ г.м.) , ба ачаа бараа ялгах, ачих хадгалах өрөө, бүх төрлийн хадгаламжийн өрөө. Хаягдал цаас боох, савлах өрөө.

В.2.8 Инженерийн ба техникийн өрөө (дулааны пункт, галын усны ба бусад зорилалтын насосны өрөө, компрессор, агаар сэлгэлтийн камер, дистилляцийн өрөө, барилгын ашиглалтын албаны өрөө, серверийн өрөө гм).

Барилгын төрөлтэй уялдсан нэмэлт өрөө, тасалгаа

Боловсролын байгууллагад

В.2.9 СӨББ, ЕБС –н барилгад: туслах нэмэлт өрөө (тухайлбал: аж ахуйн болон хүнсний агуулах, цэцэрлэгжилтийн багаж хэрэгсэл хадгалах өрөө гм).

В.2.10 Их, дээд, дунд, тусгайболовсролын байгууллагын барилгад болон насанд хүрэгсдийн сургалт, уран бүтээлийн төвд: Тусгай судлагдахуун эзэмшүүлэх нэмэлт тоног төхөөрөмжтэй лаборатори ба аудитори; хөдөлмөр хамгааллын кабинет, эрүүл ахуйн ба галын аюулгүйн нормоор хориглоогүй дадлагын байр, урлан, засварын газрууд.

В.2.11. Эмнэлгийн байгууллагад:

а) Ажилтанууд, бүртгэлийн ажилтны өрөө (эмнэлэгийн ажилтны ба явуулын бригадын ажлын өрөө), жижүүрийн ажилтны байр;

б) Туслах албаны салбарын өрөө , термостатын өрөө, хэвлэл мэдээллийн бэлтгэлийн өрөө, цагаан хэрэглэлийн төв, халдваргүйжүүлэх уусмал бэлтгэх ажилчдын өрөө, өвчтөний бусад зориулалтын угаалгын өрөө, төвлөрсөн ариутгал, халдвартгүйжүүлэлтийн тасаг, нас барагчийн цогцос хувцаслах, хадгалах албаны өрөө, салах ёс гүйцэтгэх заал, эмнэлэгийн хог хаягдалын асуудал хариуцсан салбарын өрөө , эрүүл ахуй, ариун цэврийн хяналтын өрөө, ариун цэврийн өрөө, өвчтний эд зүйлс хадгалах өрөө, тоног төхөөрөмж засварлах салбарын өрөө, аптека;

в) Туяа эмчилгээний процедур, туяа ба радионуклид (цацраг идэвхит) оношил зүй тасаг (рентген, соронзон-үелзүүрт), удирдлагын ба үйл ажиллагааны нягт уялдаатай бусад албадын өрөө таслгаа, цацраг идэвхит эм бэлдмэлийн хангамжийн блок;

г) Сэргээн засах эмчилгээний өрөө, кабинет (биеийн тамирын эмчилгээний заал, эмчилгээний бассей., усан эмчилгээ, бариа заслын кабинет).

В2.12 Хүнсний бүтээгдэхүүний дэлгүүрийн өрөө, аж үйлдвэрийн барааны 400 м² хүртэл худалдааны талбайтай дэлгүүр (СП 4.13130 –н 2,6 -д заасантай адил шатамхай шингэн, амархан асдаг бараа худалдаалах тасаг буюу дэлгүүрээс бусад) шилэн сав хүлээн авах өрөө .

В.2.13 Сургуулийн өмнөх ба ерөнхий боловсролын байгууллагаас бусад газрын хоол хүнсний ба, хүнс үйлдвэрлэл аж ахуйн нэгжийн (бие даасан ба бусад байгууллагын), өрөө

В.2.14 Ахуй үйлчилгээний газрын зочидод зориулсан салон (үсчин , гоо сайханы кабинетаас бусад.). Ахуй үйлчилгээний захилга хүлээн авалтын цогц төв; үзүүлэнгийн заал , зураг авалтын өрөө, лаборатори бүхий фото зургийн салбар; прокатын үйлчилгээний өрөө; гэр бүлээрээ баяраа тэмдэглэх заал; эрүүл ахуй, галын аюулгүйн нормоор байршил нь зөвшөөрөгдөх үйлдвэрлэлийн цэг салбар.

В.2.15 Радиоузел; кино-фотолаборатори; телевизийн хаалттай системийн өрөө гм.

В.2.16 Спорт-үзүүлэн ба спорт-үзвэрийн заал; мөсөн талбайтай спорт заал; буудлагын /сумаар/ газар, спортын заал ба дасгал хийх, биен тамир- эрүүлжүүлэх хичээлийн өрөө (үзэгчдийн суудалгүй); цана хадгалах өрөө; бильярдны өрөө; ширээний теннис, боулинг тоглох заал.

В.2.17 Нэгэн зэрэг 300 хүртэл үзэгчдэд үйлчлэх үзэсгэлэнгийн заал; насанд хүрэгсдийн дугуйлангийн өрөө, фойе.

В.2.18 Хэсэг бүртээ нэгэн зэрэг 100 –гаас олонгүй хүмүүст үйлчлэх сургуулилтын заал; ширээний теннисний өрөө, , интернет-заал, видеокафе; 50 хүртэлхи хүн бүжиглэх дискотекийн өрөө. (Гэхдээ хана аазны өнгөлгөөг ГҮ бүлгийн материалаар хийсэн байна).

В.2.19 Тайзны трюм^{HT}, эстрад^{HT} ба арен^{HT}, хөгжмийн байр, хөгжимчдийн өрөө.

В.3 Хаяавчийн давхар

В.3.1 Хаяавчийн давхарт байршуулж болохыг зөвшөөрөх бүхий л өрөө.

В.3.2 Захиргааны, албан ажлын ба сургуулийн өмнөх мөн эмнэлэгийн байгууллагын албаны , ахуйн өрнөөнүүд.

В.3.3 . СӨББ-ын бассейн, насанд хүрэгсдийн эмчилгээний бассейн; ус-шавар эмчилгээний өрөө; байгалийн гэрлээр хангагдсан эмчилгээний биеийн тамирын өрөө, усан эмчилгээний хүхэрт устөрөгчийн ус бэлтгэх лабортори.

В.3.4 ЕБС -н үүдний танхим ба хувцасны өлгүүр (гадагшаа шууд гарах гарц, орцны өмнөх талбай, үүдний довжоо ба явган хүний замын түвшингийн зөрүү 1,5 м-ээс ихгүй байх тохиолдолд), сургуулийн хоолны газар, спорт заалны хувцас солих өрөө, багш, ажилчдын ариун цэврийн өрөө, агуулахын өрөө ба нөөцийн төв.

В.3.5 Нэвтрэх үнэмлэх олгох товчоо, лавлах, бүртгэлийн цэг, агаарын тээвэр, төмөр замаар болон бусад тээврийн хэрэгслээр зорчих тасалбар худалдах тооцооны хэсэг, зам тээврийн агентууд.

В.3.6 Банкны байгууллагын касс, арилжааны ба кассын танхим, валют арилжааны цэг, АТМ.

В.3.7 Эдгэрсэн хүнийг үдэн гаргах өрөө; цагаан хэрэгслэлийн агуулах

В.3.8 Хувилан олшруулах тасгийн өрөө..

В.3.9 Бүртгэлийн/ заал.

В.3.10. Хоол үйлдвэрлэлийн байр, түүнчлэн эмнэлгийн гал тогоо (галын үүргийн аюулын Ф1.3. ангиас бусад барилгад)

В.3.11 Спортын бассейн.

В.3.12 Хуурай уурын бани.

В.3.13 Мужааны цех.

Тайлбар:

1. Хаяавчийн давхарт, шалны түвшин нь гадна явган зам талбайн болон манаасын төлөвлөлтийн түвшнээс 0.5 метрээс доошгүй байх нөхцөлд сургуулийн өмнөх насны хүүхэд цугладаг өрөө, ерөнхий боловсролын ба анхан шатны мэрэгжлийн боловсролын байгууллагын ерөнхий эрдмийн хичээл заах сургалтын танхим, хэвтүүлэн эмчлэх тасаг, цахилгаан гэрэл эмчилгээний кабинет, төрөх, мэс заслын ба эмчийн үзлэгийн кабинет, сууцны өрөөнөөс бусад бүх өрөөг байршуулж болно.

2. Орон сууцны барилгын хаяавчийн ба газар доорхи давхарт байрлуулахыг зөвшөөрөх олон нийтийн өрөөний жагсаалтыг БД 31-118-15 -аас үзнэ.

3. Тухайн байгууллагын онцлогтой холбогдсон тусгай зориулалтын өрөөг / ж-нь: шүүхийн барилгад сэжигтнийг хорих, банкны үнэт зүйлсийн хадгаламж гм/ газар доорхи

давхарт байрлуулах боломжийг холбогдох нормативын баримт бичгийн дагуу тогтооно.

В.4. Стилобатын хэсэг (Орон сууц, зочид буудал, оффисын барилгын доод давхрууд)

В.4.1. Олон айлын орон сууцны барилгад СП 54.13330-ийн дагуу төлөвлөж болох олон нийтийн зориулалттай албан газар, аж ахуйн нэгж, үйлчилгээний байгууллагуудын өрөө тасалгааг стилобатын хэсэгт төлөвлөж болно. Стилобатын хэсэг 5 давхраас дээшгүй байх бөгөөд 2 буюу хэд хэдэн ОАОС- ны барилгыг нэгтгэсэн байж болно.

Тайлбар: СП 252.1325800.2016-ийн 7.1.8-р заалтыг хангасан нөхцөлд СӨББ-ын өрөөг дотор нь оруулан төлөвлөж болно.

В.4.2. Хүн амын сервисийн үйлчилгээний өрөө тасалгаа: 3500 м² хүртэл талбайтай аж үйлдвэрийн бараа жижиглэн худалдах дэлгүүр; мөн 3500 м² хүртэл талбайтай хүнсний бараа худалдах дэлгүүр; нийтийн хоолны байгууллагууд, түүнчлэн антресольтой хооллох танхим; технологийн болон инженерийн тоног төхөөрөмж байрлуулах шаардлагаар өрөө тасалгааны өндөр нь 3,3 м ба түүнээс илүү өндөр байх ахуй үйлчилгээний байгууллагууд.

В.4.3. Биеийн тамир, спорт, чөлөөт цаг- спортоор хичээллэх зориулалтын өрөө: олон төрлийн зориулалттай спортын танхимууд (үзэгчдийн суудалгүй, танхимын акустик болон барилгын хийц бүтээцийг цохилтын болон агаарын долгионы дуу чимээнээс тусгаарлалт нь СП 51.13330-ийн шаардлага хангасан байх), бассейн.

В.4.4. Оршин суугчид соёлжих, чөлөөт цагаа өнгөрөөхөд зориулагдсан өрөө тасалгаа: номын сан, музей, үзэсгэлэнгийн танхим ба түр үзэсгэлэн гаргах уран зургийн галлерей (сан хөмрөг хадгалах өрөөгүй), клубүүд болон чөлөөт цагаа өнгөрөөх газрууд.

В.4.5. Түр байрлахад зориулсан өрөө тасалгаа: 30 хүртэл өрөөтэй зочид буудал.

В4.6. Нийгэм ба төрд үйлчлэх объектын өрөө тасалгаа.

В4.7. Оршин суугчдад богино хугацаагаар түрээслүүлэх 75-200 м² талбайтай заал,танхим.

Тайлбар:

Барилгын стилобатын хэсгийн давхрын өндрийг энэхүү норм, дүрмийн 4.5. дэд бүлэгт заасны шаардлагатай нийцүүлсэн зураг төслийн даалгаврын дагуу, тусдаа барилга мэт авч үзэж тодорхойлно.


Барилгын стилобатын хэсгийн хаяавчийн болон газар доорх давхарт төлөвлөх өрөө тасалгааг В хавсралтын В1-В3-т заасны дагуу төлөвлөнө.

Байгууллага, аж ахуйн нэгжийн багтаамж ,хүчин чадлыг зургийн даалгавраар тогтооно.

Г Хавсралт. Үзэгчдийн танхимын параметрт тавих шаардлага

Г.1. Уламжлалт аргаар кино үзүүлэхэд зориулсан кинодэлгэц ба үзэгчдийн танхимын параметрийн үзүүлэлт

Уламжлалт аргаар кино үзүүлдэг заалны үзэгчдийн суудлыг Е.1 дүгээр зурагт тэмдэглэсэн бүсийн хязгаарт байршуулах нь зохистой ба түүний дэлгэцийн параметрийн үсгэн тэмдэглээг мөн дээрх зурагт хамтатган харуулав. Харин түүний гол параметрийг Е.1 хүснэгтээс үзнэ.



Зураг Г.1. - Кино театрын заал ба нийтлэг зориулалттай зааланд уламжлалт аргаар кино үзүүлэх дэлгэц ба үзэгчдийн заалны параметрийг харуулсан тойм зураг. Таних тэмдэг: I - заалны хөндлөн огтлол, II - заалны байгуулалт. / зурагт нэр үсэг засварлана/

Суудлын эгнээ ба дэлгэцийн гол параметрийг харуулах Г1. хүснэгт.

Дэлгэцийн төрөл	Дэлгэцийн өндөр (Н) өргөний (А) харьцаа , Н : А	Дэлгэцийн өргөн (А), үзэгчдийн заалын урт (L) -с хамаарах хамаарал*	Дэлгэцээс нүүрний эгнээний суудлын арын түшлэг хүртлэх зай I, дэлгэцийн өргөн А -с хамаарах хамаарал
Өргөн форматын дэлгэц	1 : 2.2	$A = 0,6 L (0,54 L)$	$I \geq 0,6 D_{\text{өр}}$
Өргөн дэлгэц	1 : 2.35	$A = 0,43 L (0,39 L)$	$I \geq 0,84 A$
Кашетэлсэн дэлгэц (дээрээ ба доороо хар хүрээтэй, кашеттэй)	1 : 1.66	$A = 0,34 L_{\text{н}} (0,3 L)$	
Энгийн дэлгэц	1 : 1.37	$A = 0,25 L (0,22 L)$	$I \geq 1,44 A$
<i>Тайлбар: * - Хаалтанд бичсэн тоонууд нь театр, клуб болон улирлын чанартай ажилладаг кинотеатрт хамаарна.</i>			

Үсгэн тэмдэглээний тайлбар:

Суудлын байрлал. Энэ нь :

L – кино дэлгэцээс хамгийн арын эгнээний суудлын түшлэг хүртлэх заалны тэгшхэмийн тэнхлэг дагуу хэмжин байрлуулах зай;

l - кино дэлгэцээс хамгийн нүүрний эгнээний суудлын түшлэг хүртлэх заалны тэгшхэмийн тэнхлэг дагуу хэмжин байрлуулах дундаж зай бөгөөд үүнийг;

$l = 0.36 L$ –тэй тэнцүү гэж бодно. Гэхдээ энэ “*l*” хэмжээ дэлгэцийн төрлөөс хамаарч өөр өөр байх тул тухайн тохиолдолд хүснэгт Г.1-г ашиглана

Кино дэлгэцийн параметрийн дэлгэрэнгүй үзүүлэлт (Е.1-р зургийг харна уу) .

Энд ашигласан үсгэн тэмдэглэгээний тайлбар:

A - нь дэлгэцийн ажлын талбайн өргөн (хордын / хөвчийн / дагуух муруй шугам);

H - нь дэлгэцийн ажлын талбайн өндөр.

H ба A –ийн хоорондын харьцаа дэлгэцийн төрлөөс (өргөн форматын_ф, өргөн_ш, кашетэлсэн_к, ердийн_о) хамаарч өөр өөр байх тул дараах байдлаар авна. Үүнд:

$$H_{\text{ф}}^{1*}) : A_{\text{ф}} = 1 : 2.2$$

$$H_{\text{ш}} : A_{\text{ш}} = 1 : 2.35$$

$$H_{\text{к}} : A_{\text{к}} = 1 : 1.66$$

$$H_{\text{о}} : A_{\text{о}} = 1 : 1.37 \text{ тус тус тэнцүү байна.}$$

Тайлбар:

^{1*)} **A** , **H** , **I** параметрийн индексүүд нь дэлгэцийн төрлийг заана. Тухайлбал:

Ф – нь өргөн форматын дэлгэц,

ш - нь өргөн дэлгэц,

*к – нь кашетэлсэн дэлгэц
о – нь ердийн дэлгэцтэй холбоотой гэж ойлгоно.*

Дэлгэцийн өргөн ($D_{\text{өр}}$) түүний төрөл болон үзэгчдийн заалны уртын хэмжээнээс (D) хамааруулан дараах байдлаар авч болно. Үүнд:

$$A_{\text{ф}} = 0,6L(0,54L)^{2**};$$

$$A_{\text{ш}} = 0,43L(0,39L);$$

$$A_{\text{к}} = 0,34L(0,3L);$$

$$A_{\text{о}} = 0,25L(0,22L).$$

Тайлбар: ^{2**}) Хаалтанд бичсэн тоонууд нь – улирлын чанартай ажилдаг кинотеатр, театр, клубтэй холбоотой болно

Кино дэлгэцээс хамгийн **нүүрний эгнээний суудлын түшлэг хүртлэх зай** (I) нь дэлгэцийн өргөнөөс ($Ш$) хамааралтай тул түүнийг дараах байдлаар авч болно. Үүнд:

$$I_{\text{ф}} \geq 0,6 A_{\text{ф}};$$

$$I_{\text{ш}} \geq 0,84 A_{\text{ш}};$$

$$I_{\text{о}} \geq 1,44 A_{\text{о}}. \text{ байна гэж тус тустооцно.}$$

Кино дэлгэцийн дугуйрах радиусын хэмжээг арын суудал хүртлэх зай буюу өмнө нэрлэсэн D хэмжээнээс багагүй байхаар авна.

Кинопроекцийн тоног төхөөрөмж суурьлуулалт ба үзмэрийн заалны параметрийг Е.1 зургаас үзнэ. Энд бичсэн:

П нь – проекцийн зай ^{3***} $0.85D$ –ээс багагүй; ^{3***}) ОХУ –ын кинопроекцоор тоноглогсон бол - 34,5 м-ээс багагүй байна.

Ф нь - кино дэлгэцийн төвийн нормалаас проекцийн харааны тэнхлэг хазайх өнцөг:

$\varphi_{\text{г}}^{4****-7^0}$ – с ихгүй;

$\varphi_{\text{в}}$ - 8^0 - с ихгүй;

$\varphi_{\text{н}}$ – 3^0 - с ихгүй; *Тайлбар:* ^{4****}) Клуб ба театрт 9° -аас ихгүй байж болно.

Г нь – проекцийн дээд цацрагт ойрхон байгаа таазны гадаргуу хүртлэх зай бөгөөд энэ нь 0,6 метрээс багагүй байна;

Г нь - проекцийн доод цацрагаас үзэгчдийн суудлын шал хүртлэх зай; $L \geq 1,9\text{м}$;

Т нь – дэлгэцийн арын орон зайн гүний хэмжээ бөгөөд энэ нь:

- Дуугаа нэг сувгаар өсгөдөг буюу эсвэл дэлгэцийн 2 талд чанга яригч байрлуулах тохиолдолд 0,1-0,3м байна.
- Өргөн дэлгэцтэй байвал – 0.9м,

- Өргөн форматын дэлгэцтэй байвал – 1.5 м байна.

Р? нь – дэлгэцийн захаас хана хүртлэх зай. Энэ нь:

- ❖ Өргөн дэлгэцтэй бол - 0,985 м-с багагүй;
- ❖ Дугуйрсан дэлгэцтэй бол – дэлгэцийн өргөн, Ш-н 0,1-с багагүй байна.

Дэлгэц дээрх зураг, дүрс харагдах тооцоолсон цэг (кино театрын барилгад бол кино дэлгэцийн доод хөвөө) дэх үзэгдэлтийг саадгүй харуулах нөхцөл бүрдүүлэхийн тулд өмнөх эгнээнд суусан үзэгчийн харааны түвшнээс түүний ард суусан үзэгчийн харааны түвшний шугамыг 0,14 м-ийн (шинэчлэлт хийх нөхцөлд энэ нь 0,12 м байж болно) дээр түвшинд байхаар тохируулж (суудал) болно.

Сандал дээр сууж байгаа үзэгчийн нүдний харааны түвшин шалны түвшнээс 1,2 метрийн өндөрт байхаар тооцно.

Г.2 Спорт-үзвэр хослуулсан олон зориулалттай заалны параметрын шаардлага

Хүснэгт Г.2


спортын төрөл	Арен, бассейнын хэмжээ , м	Хяналтын фокусын цэгийн- байршил F	фокусын цэгээс холдолж болох хязгаар F, м
Усанд сэлэлт, ус руу үсрэлт, усан поло, синхрон сэлэлт	21x50	Харайлт буюу замын тоноглолын тэнхлэгийн дагуух үзэгчдийн суудалд ойр байгаа усны гадаргуу дээр	60
Хоккей, уран гулгат	30x61	Хашлага дээгүүр давж харагдах гулгалтын талбайн хамгийн ойрын ирмэг	70
Бокс, бөх, хүнд атлетик	12x18	Үзэгчдийн суудалд ойр талын дэвжээн дээр	60
Спорт тоглоомын төрөл	18x36, 22x42	Үзэгчдийн суудалд ойрхон байгаа шалны захын талбай дээр	60
Спортын ба уран сайхны гимнастик	22x42	Үзэгчдийн суудалд ойрхон байгаа тавцангийн (помост ^{нт}) ирмэг дээр	60
Футбол, хөнгөн атлетик	75x126	Хамгийн ойрхон гүйлтийн замын тэнхлэгээс 0,5 м өндөрт	90

ЖИЧ: Налуу замын /пандусын/ параметрийг БД 31-112-11 -ын дагуу авна.


Д Хавсралт. Онцгой тохиолдол үед үзэгчдийг үзвэрийн заалаас гаргах маршрут

Д.1 Суудлынхаа эгнээг даган заалны аврах гарц руу явах үзэгчдийн хөдөлгөөний чиглэлийг хувиарлан зохион байгуулахдаа дараах И.1ба мөн И.1(а, б) дүгээр схем зурагт үзүүлсэнийн дагуу зохицуулна.

Харин онцгой тохиолдлын үед тэрхүү заалнаас гарч фойе, үүдний танхим руу орж ирсэн хүмүүсийн цааш явах хөдөлгөөнийг Д.2 зурагт харуулсан схемийн дагуу гадагш гаргахаар төлөвлөнө.




Зураг Д.1. Онцгой үед үзэгчдийн заалнаас гарах хүмүүсийн хөдөлгөөнийг зохицуулах маршрутын ерөнхий тойм.



Зураг Д.1 Онцгой үед үзэгчдийн заалнаас хүмүүсийг гаргах үеийн хөдөлгөөнийг зохицуулах маршрутын ерөнхий тойм зураг. / зурагт засвар бий/

Зураг Д.1 а нь - хажуу тал руугаа (дагуу) гарах ослын гарцтай үед; Зураг И.1 б нь - хажуу тал руугаа болон хөндлөн чигт зүглэсэн хослоомол гарцтай үеийн зохицуулалтын боломжийг тус тус харуулна;



Зураг Д 2–Аврах гарцад зориулсан тусгай люк(онгорхой зай /нүх) ашигласан тохиолдолд олон зориулалттай заал ба спорт-үзвэрийн заалны үзэгчдийн суудлыг блок болгон хувиарлах ерөнхий тоймыг харуулна. Гэхдээ:

Д.2а – Ерөнхий гарц нь тоглолтын гол талбайн түвшинд байх тохиолдолыг;

Д 2б – Ерөнхий гарц нь дээд талын хаалганы нээлхийгээр дамжин аврах ажиллагаа явуулах боломжийг тус тус үзүүлнэ.

Гарцын чиглэл

Д.2 Аврах ажиллагаа явуулах суудлын эгнээний *ерөнхий тоог m* гэж үзээд (зураг И.2а) , *хэрэв тэр тоог түүний 0.6-тай тэнцүү ($m_1= 0.6$ m) гэж үзвэл* доод талын , харин 0.4 m-тай тэнцүү ($m_2= 0.4$ m) байвал дээд талын *гарцыг тус тус ашиглан* үзэгчдийг аврах боломжтой.

Д.3 Аврах ажиллагааг люкээр дамжуулан гаргахад тавцан дээрх суудлын эгнээ нь хоёр түвшинд (И.2 дугаар зургийн б) тарж байрласан байвал тоглолт үзэхэд саад болохооргүйгээр 0,7 м-ээс өндөргүй хашлагаар биеэ даасан хоёр хэсэг болгон салган зохицуулна.

Хүмүүсийг аврахдаа хэсэг нэг бүрээс тус тусад зохион байгуулахдаа: дээд түвшин буюу хамгийн өндөрлөсөн (шалны түвшинээс хамгийн арын эгнээний суудлын түвшин хүртэл) эгнээний суудлын үзэгчдийг дээд люкээр, харин доод түвшиний суудалд суусан үзэгчдийг суудлын блокын ерөнхий гарцын эсрэг чигт байрласан гарц буюу доод люкээр аврахаар зохицуулна.

Д.4 N тооны суудалтай суудлын тавцангийн /ярусын/ эгнээг бүхэлд нь M тооны блок болгон зориуд хуваах, бас аврах ажиллагаа үргэлжлэх зөвшөөрөгдөх хугацааг тодорхойлохдоо: Хэрэв: блокын ерөнхий гарцын шатаар доошоо уруудах бол

$$M = 0,01NK / t_{зөвш} ? ; (И.1)$$

Харин блокын ерөнхий гарцын шатаар дээшээ өгсөх бол

$$M = 0,07NK / t_{зөвш} ? , (И.2) \text{ гэсэн томъёог тус тус ашиглана:}$$

Энд: $t_{зөвш}$ – нь зөвшөөрөгдөх хугацаа гэсэн утгатай гэж ойлгоно,

Д.5 Тавцант суудлын (өндөрлөсөн) урт L байна гэж үзээд холбогдох суудлын эгнээний тоог ($m_{дээш}$ буюу $m_{доош}$) дараах томъёог ашиглан тооцно.

$$m = 0,45 NK / L . (И.3)$$

Д.6 Урьдчлан сэргийлэх аврах ажиллагааны үед үзэгчдийн суудлын блокоос хүмүүсийг аврах тооцоот хугацаа нь ($t_{т.бл}$) дараах утгыг хангасан байна.

$$t_{т.бл} \leq t_{зөвш} - 0,04(l_{пр} + 5), (И.4)$$

Энд: $t_{т.бл}$, - блокоос хүмүүсийг аврах тооцоот хугацаа
 $l_{пр}$ – хамгийн алслагдсан эгнээнээс заалны гарц хүртэл туулах замын ерөнхий урт.

Д.7 Партер буюу тавцанд дээрх суудлын тоо $N_{бл}$ байхад суудлын блок дундуур туулах аврах ерөнхий гарцын зам (проход) өргөн нь доор зааснаас багагүй байна:


$$b_{бл} = N_{бл} / q t_{т.бл} , (И.5)$$

Энд: q – гийн утгыг дараах нөхцлөөр авна:

хэрэв гарцаар явах хөдөлгөөн нь шатаар доошоо уруудахаар байгаа буюу пандусаар явах бол -80.

хэрэв гарцаар явах хөдөлгөөн шатаар дээшээ өгсөх бол – 50

Д.8 Заалнаас гарсны дараах хүмүүсийн хөдөлгөөний чиглэлийн цаашдын сонголтыг И.3 дугаарт зурагт үзүүлсэнээр тодорхойлоно.



Зураг Д.3– Гарцуудын хооронд үзэгчдийн тоог хувиарлах нийтлэг байдал

Зураг Д.3а–N тооны хүний хөдөлгөөний урсгалыг хувиарлах схем ; зураг Д.3б – Гарц руу чиглэсэн хөдөлгөөний ерөнхий урсгалд орлцох хүмүүсийн тоог хувиарлахад гарцууд хүртлэх зайны хоорондын харьцааны нөлөөлөл:

Энд: 1гэсэн муруй нь – ижилхэн хоёр гарцын аль ойр руу ;

1 гэсэн муруй нь :гадагшаа, хонгилтой шат буюу задгай шатыг ашиглах I_1

2 гэсэн муруй нь– задгай шат руу буюу хонгилтой шатыг ашиглах I_2

Д.9 Хязгаарлалтгүй өргөнтэй хэсгээс (вестибюль, фойе, кулуар гм.) гарахаар хүмүүс бужигнах үед үүсэх хөдөлгөөний урсгалын схемийг И.3 дугаарт зурагт харуулсан.

Хязгаарлалтгүй өргөнтэй хэсэгт хөдөлгөөн болоход үүсэх урсгалын өргөн нь хүмүүсийн тоо N мөн тухайн хэсгийн урт l -ээс хамаарах ба энэ нь $N < 100$ хүн, $l \leq 6$ м нь байхад

$b = 4$ м байна. Бусад тохиолдолд $b = 6$ метр байна.

Д.10 Автомат хяналттай шалган бүртгэх цэгийн нэтрүүлэх чадамж 1200 хүн /цаг

Ийм цэг нь металл илэрүүлэгчтэй байвал нэтрүүлэх чадамж нь тухайн бүтээгдүүний паспортын өгөгдлөөр хэмжигдэнэ.

Эскалаторын зөөвөрлөх хамгий оновчтой хүчин чадлыг түүний хөдөлдөг шатны хурдаас хамааруулан тодорхойлох ба хэрэв шатны хурд 0,6-0,8 м/с байвал түүний зөөвөрлөх чадал нь 7750

Товчилсон үгийн тайлбар

АТС – Автомат телефон станц

БХБЯ – Барилга, хот байгуулалтын яам

БдДХТ - Бие даасан дулаан хуваарилах төв

ЕБСБ- Ерөнхий боловсролын сургуулийн барилга

ЗТБД –зураг төсөл боловсруулах даалгавар

СӨНХБ - Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага

СӨНХББ - Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын барилга

МУ – Монгол улс

НТ – нэр томъёо

ОАОС – Олон айлын сууц,

ОНБ – Олон нийтийн барилга,

ОНББ – Олон нийтийн барилга, байгууламж ,

ОНЗЗБ- Олон нийтийн зориулалттай засаг захиргааны барилга

ТМБСБ –Тусгай мэрэгжлийн боловсролын сургуулийн барилга

ХБИ – Хөгжлийн бэрхшээлтэй иргэн,

АГУУЛГА

1. **Хэрэглэх хүрээ**.....
2. **Нормативын эшлэл**.....
3. **Нэр томъёо болон тодорхойлолт**
4. **Ерөнхий шаардлага** (Эдэлбэр газар, барилгын давхар, өрөөний өндөр, орц, шат, босоо чиглэлийн тээвэр, ус, дулаан цахилгаан хангамж, цахим хэрэгсэл,холбоо мэдээлэл, галын аюул, ахуйн шатдаг хий, барилга дундуур нэвт гарах зам, галын гарц, дээврийн ус зайлуулалт эрчим хүч хэмнэх болон бусад зориулалтын өрөө тасалгаа,)
5. **Үндсэн өрөөний аюулгүй ажиллагааг хангах хамгийн зохистой параметр** (Боловсролын байгууллага, дотуур байр, захиргаа, эмнэлэгийн газар, үзвэрийн заал, хурлын танхим, боловсролын байгууллага, барилгын эзэлхүүн, архив, номын сан, уншлагын танхим, хооллох танхим , сувиллын газар, дотуур байрны хүн суух өрөө, үүдний танхим, хувцас өлгүүр , ариун цэврийн өрөө, тусгай өрөө тасалгаа,)
6. **Барилгын найдваршил, аюулгүй байдлыг хангахад тавих шаардлага** (Коммуникацийн / орц, гарц, хонгил, шат, ,эвакуаци,/ аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа ажиллагсад,үйлчлүүлэгчдийг болон барилгыг хамгаалах арга хэмжээ, давхаржуулалтад тавих шаардлага,)
7. **Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангалт** (сургууль, агаар солилцоо, хог зайлуулах суваг)
8. **Инженерийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага** (Үзвэрийн танхим, клуб,ус хангамж, ариутгах татуурга, хог , тоос зайлуулалт).....
9. **Эдэлгээний он жил ба засварлах нөхцөл бүрдүүлэлт**.....

А хавсралт. Үндсэн чиг үүрэг, хэв шинжийн дагуу төрөлжүүлэн бүлэглэсэн олон нийтийн зориулалттай барилга байгууламж ба өрөө тасалгааны жагсаалт.....

Б хавсралт . Олон нийтийн барилгын давхрын тоо , барилгажсан талбай, барилгын эзэлхүүн, түүний нийт, ашигтай, тооцооны талбайг тооцох дүрэм.....

В хавсралт. Олон нийтийн барилгын хаяавчийн, газар доорхи давхарт болон стилобатын хэсэгт эрхэлж болох үйл ажиллагаанд зориулсан өрөө тасалгааны жагсаалт.....

Г хавсралт . Үзвэрийн танхимын параметрт тавих шаардлага.....

Д хавсралт Үзвэрийн заалны аврах гарцын маршрут.....